



**НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ**

---

**Монголын нутгийн удирдлагын  
асуудалд холбогдох  
НОМ ЗҮЙ**

---

**Улаанбаатар 2006**

DDC  
320.8'517'016  
M-629

**Ном зүйг эмхлэн бэлтгэсэн баг:**

- Л.Лувсанжамц /Багийн ахлагч, ШУТИС-ийн харъяа КТМС-ийн Төрийн захиргаа, Хүний нөөцийн менежментийн профессорын багийн багш, “Бүсийн хөгжлийн санаачлага” ТББ-ын тэргүүн/
- Г.Бат-Эрдэнэ /Багийн гишүүн, “Бүсийн хөгжлийн санаачлага” ТББ-ын зөвлөх, судлаач/
- А.Батгэрэл /Туслах судлаач, ШУТИС-ийн харъяа КТМС-ийн Төрийн захиргааны менежментийн 4-р ангийн оюутан/

**Хянан тохиолдуулсан:**

- Я.Долгоржав МУ-ын Ерөнхийлөгчийн зөвлөх
- А.Гэрэлмаа ННФ-ын менежер

## **НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ**

Хаяг: Жамъян гүний гудамж-5/1, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар-48, Монгол Улс  
Утас: 976-11-313207  
Факс: 976-11-314857  
Вэб: <http://www.forum.mn>

© Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь хэвлэхийг хүсвэл  
ННФ-ын хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна.

**ISBN 99929-0-034-2**

“ADMON” компанид эхийг бэлтгэж хэвлэв.

## ГАРЧИГ

Өмнөх үг . . . . .	vii
Өмнөтгөл . . . . .	viii
Ном зүйг ашиглах заавар. . . . .	ix
Товчилсон үгийн тайлбар. . . . .	xi
<b>1. НУТГИЙН УДИРДЛАГАТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ . . . . .</b>	<b>1</b>
0101 Монгол Улсын Үндсэн хууль . . . . .	2
0102 Авто тээврийн тухай хууль . . . . .	4
0103 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль . . . . .	5
0104 Ашигт малтмалын тухай хууль . . . . .	5
0105 Аялал жуулчлалын тухай хууль . . . . .	6
0106 Байгаль орчныг хамгаалах тухай хууль . . . . .	7
0107 Боловсролын тухай хууль . . . . .	8
0108 Газрын тухай хууль . . . . .	9
0109 Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль . . . . .	10
0110 Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль . . . . .	11
0111 Монгол Улсын татварын ерөнхий хууль . . . . .	12
0112 Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль . . . . .	13
0113 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль. . . . .	14
0114 Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль . . . . .	14
0115 Усны тухай хууль. . . . .	15
0116 Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль . . . . .	16
0117 Эрүүл мэндийн тухай хууль. . . . .	17
<b>2. ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ТӨСЛИЙН ТАЙЛАН . . . . .</b>	<b>19</b>
<b>0200 Хөтөлбөр, төсөл . . . . .</b>	<b>20</b>
0201 Ардчилсан Монгол дахь сайн засаглал, 2002-2005 . . . . .	20
0202 “Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхийг бэхжүүлэх нь” I (1997-1999) болон II (2001-2004) төсөл . . . . .	20

0203	Төвлөрлийг сааруулах, нутгийн захиргааг өөрчлөн шинэчлэх хүрээ, үйл ажиллагааны төлөвлөгөө . . . . .	.23
0204	Төрийн захиргааны шинэчлэл хөтөлбөр . . . . .	.25
0205	Хотын ядуурлын туршилтын төсөл . . . . .	.26
0206	“Хөдөө худалдаа” борлуулалтын сүлжээ . . . . .	.26
<b>0210</b>	<b>Төслийн тайлан, бодлогын баримт бичиг . . . . .</b>	<b>.27</b>
0211	Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн чадавхийг бий болгох нь. . . . .	.27
0212	Монгол дахь Нутгийн Иргэдийн Хөгжлийн Төв төслийн үнэлгээний эцсийн тайлан . . . . .	.28
0213	Монгол Улстай хамтран ажиллах анхны үйл ажиллагааны хүрээ . . . . .	.29
0214	Монгол Улстай хамтран ажиллах хоёр дахь удаагийн үйл ажиллагааны хүрээ . . . . .	.29
0215	Төрийн зарлагын менежмент . . . . .	.30
0216	Улс орныг дэмжих хөтөлбөрийн үнэлгээ . . . . .	.31
<b>0230</b>	<b>Олон улсын болон төрийн бус байгууллагууд . . . . .</b>	<b>.32</b>
0231	Конрад Аденауэрын Сан . . . . .	.32
0232	Монголын Нутгийн Удирдлагын Холбоо . . . . .	.33
0233	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр . . . . .	.34
0234	Нээлттэй Нийгэм Форум (Хуучнаар Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн). . . . .	.34
0235	Орон Нутгийн Удирдлагын Хөгжил Сан . . . . .	.35
<b>3.</b>	<b>НОМ, ТОВХИМОЛ, ГАРЫН АВЛАГА, СЭТГҮҮЛ . . . . .</b>	<b>.37</b>
<b>0300</b>	<b>Гарын авлага, сэтгүүл . . . . .</b>	<b>.38</b>
0301	Багшийн гарын авлага. . . . .	.38
0302	Байгаль орчныг хамгаалах олон нийтийн үүрэг. . . . .	.38
0303	Иргэн ба хууль зүй. . . . .	.39
0304	Иргэдийг төлөөлөхүй, Шведийн ардчилсан засаглал . . . . .	.39
0305	Монгол Улсын нутгийн өөрөө удирдах ёсны тунхаг бичиг . . . . .	.40
0306	“Монгол Улсад нутгийн өөрөө удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь”, сургалтын гарын авлага . . . . .	.40
0307	Нутгийн өөрөө удирдах ёс . . . . .	.41
0308	Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь. . . . .	.42
0309	“Нутгийн удирдлага” сэтгүүл . . . . .	.42
0310	Орон нутгийн санхүүгийн хөгжил . . . . .	.43
0311	Сонсогчийн гарын авлага. . . . .	.44

0312	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл, ерөнхий тайлбарын гарын авлага . . . . .	.45
0313	Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл, онол, тайлбар, хэрэгжилт . . . . .	.45
0314	Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл, төсвийн байгууллагын бүтээгдэхүүнийг тодорхойлох, бүтээгдэхүүний өртөг тооцох гарын авлага . . . . .	.46
0315	Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл, хуулийн эмхтгэл. . . . .	.46
0316	Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл, заавар, журмын эмхтгэл . . . . .	.47
0317	Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл, төсвийн удирдлагын гарын авлага . . . . .	.47
0318	Хүний эрх ба нутгийн өөрөө удирдах ёс. . . . .	.48
0319	Хүрээлэн буй орчныг хамгаалах орон нутгийн удирдлагын үүрэг. . . . .	.49
<b>0330</b>	<b>Ном, товхимол . . . . .</b>	<b>.49</b>
0331	Багийн өнгөрсөн, одоо, ирээдүй . . . . .	.49
0332	Бүх шатны хурал, Засаг даргын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн актын эмхтгэл . . . . .	.50
0333	Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний өнөөгийн байдал, цаашдын хандлага. . . . .	.51
0334	Монголын бүс нутгийн тогтвортой хөгжлийн асуудлууд . . . . .	.51
0335	Монголын бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт, удирдлагын асуудлууд . . . . .	.52
0336	Монголын бүс нутгийн хөгжлийн эдийн засаг, математикийн загварчлал. . . . .	.53
0337	Монгол Улсын орон нутаг, түүний удирдлага. . . . .	.53
0338	Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, товхимол II . . . . .	.54
0339	Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, товхимол IV. . . . .	.55
0340	Нутгийн өөрийн удирдлага . . . . .	.56
0341	Нутгийн өөрийн удирдлагын өнөөгийн байдал ололт, дутагдал, хандлага . . . . .	.56
0342	Нутгийн удирдлага . . . . .	.57
0343	Санаачлага -Үр дүн. . . . .	.58
0344	Сумын судалгаа: Онол арга зүйн асуудал . . . . .	.59
0345	Хурал, өөрөө удирдах ёс . . . . .	.60

0346	“Хүчирхэг орон нутаг-Хүчирхэг Монгол Улс” илтгэлийн эмхтгэл . . . . .	.61
------	--	-----

<b>4. СУДАЛГААНЫ ТАЙЛАН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛ . . . . .</b>		<b>63</b>
<b>0400 Судалгааны тайлан . . . . .</b>		<b>64</b>
0401 Азийн Хөгжлийн Банк, “Шинэчлэлийг хэрэгжүүлэх төв ба нутгийн удирдлагын асуудлуудын судалгаа” . . . . .		.64
0402 Дэлхийн Банк, “Монгол, Төрийн зарлагын болон санхүүгийн удирдлагын судалгаа” . . . . .		.65
0403 Орон нутгийн улс төрийн ёс зүйн асуудал, судалгааны тайлан . . . . .		.66
0404 Орон нутгийн улс төрийн ёс зүйн асуудал судалгааны тайлан 2003 он . . . . .		.67
0405 Орон нутгийн улс төрийн ёс зүйн асуудал судалгааны тайлан 2001-2004 он . . . . .		.68
0406 “Орон нутгийн түвшинд ардчиллыг бэхжүүлэх нь: Тулгамдсан асуудлын судалгаа” . . . . .		.69
0407 Санхүүгийн төвлөрлийг сааруулах судалгаа . . . . .		.69
0408 Үндэсний ба нутгийн удирдлагын чиг үүргийн зохистой хуваарилалт . . . . .		.71
0409 Хөдөөгийн бизнесийн хөгжил-засаглалын үнэлгээ . . . . .		.72
<b>0420 Эрдэм шинжилгээний бүтээл . . . . .</b>		<b>73</b>
0421 Монгол Улсад нутгийн өөрөө удирдах ёсыг хөгжүүлэх үндсэн асуудал . . . . .		.73
0422 Монгол Улсын нутаг дэвсгэрийн хуваарийн түүхэн уламжлал 1921-1932 . . . . .		.74
0423 Монгол Улсын засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн хуваарийг оновчтой болгох газар зүйн асуудал . . . . .		.75
0424 Орон нутгийн удирдлагын эдийн засгийн механизмыг боловсронгуй болгох зарим асуудал . . . . .		.76
<b>НОМ ЗҮЙД ХАМРАГДСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ . . . . .</b>		<b>78</b>

## ӨМНӨХ ҮГ

Нээлттэй Нийгэм Форум нь бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад иргэдийн зүгээс идэвхитэй оролцоход дэмжлэг үзүүлэхийг зорьж ажилладаг төрийн бус байгууллага болохын хувьд энэхүү оролцоонд шаардлагатай мэдээлэл олон нийтэд хүргэхэд хүчин чармайлт тавьж ажиллаж байна. Энэ удаад бид Нутгийн удирдлага сэдвээр номзүйг боловсруулан, уншигч Танд хүргүүлж байна.

Энэхүү номзүйд Нутгийн удирдлагын холбоотой хууль тогтоомж, энэ хүрээнд бичигдсэн ном, гарын авлага, хийгдсэн судалгаануудыг тоймлон багтаалаа. Нутгийн удирдлагыг бэхжүүлэх, өөрөө удирдах ёсыг хөгжүүлэх нь Монгол орны ардчиллын хөгжлийн тулгамдсан асуудлуудын нэг болж, төр засгийн болон төрийн бус байгууллагууд, манай оронд үйл ажиллагаа явуулж буй гадаадын байгууллагууд, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн анхаарлын төвд оршиж буйг анхаарч, энэ чиглэлээр хэрэгжиж буй бүхий л үйл ажиллагааг тоймлон багтаахыг хичээлээ.

Энэ ялдамд уг номзүйг бичиж боловсруулахад өөрсдийн мэдлэг, чадавхийг дайчилж, амжилттай ажилласан “Бүсийн Хөгжлийн Санаачилга” ТББ-ын ажлын багт гүн талархал илэрхийлье.

Нутгийн удирдлагын асуудлыг сонирхож байгаа бодлого боловсруулагч, судлаач, иргэд, олон нийтэд энэ номзүй нь олон талын мэдээллийг агуулсан, цаг завьг нь хэмнэсэн тустай зүйл болсон гэдэгт найдаж байна.

П.Эрдэнэжаргал  
Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал

## ӨМНӨТГӨЛ

Монгол Улсад нийгмийн ардчилсан шинэчлэлийн үйл явц эхэлснээс хойш төрийн захиргааны шинэчлэл, төвлөрлийг сааруулах ба нутгийн захиргааны шинэчлэлийн талаар нилээдгүй ярьж, бичиж, судлаж байна. Ялангуяа засаглалын хүрээн дэх ардчиллын чухал үнэт зүйл буюу дөрөвдөгч засаглал хэмээгддэг нутгийн өөрөө удирдах ёсыг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх, түүний эрх зүйн баталгаат байдлыг хангах, орон нутгийн харьцангуй бие даасан, ил тод, иргэдийн оролцоонд суурилсан удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх талаар бодлогын хүрээнд судалгаа, шинжилгээ хийх, ном бүтээл туурвих ажлууд хийгдсээр байна.

Эдгээр судалгаа, төслийн ажил, ном бүтээлийн агуулгыг нэгтгэн, хураангуйлан тоймлож энэхүү ном зүйг бэлтгэсэн нь энэ чиглэлээр ажилладаг эрдэмтэн судлаач, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын төслийн байгууллагуудын цаашдын ажилд тус дөхөм болох, мэдээллээр хангах зорилготой билээ.

Монголын нутгийн удирдлагын асуудлыг шинэчлэх зайлшгүй шаардлагатай байгаа энэ үед Нээлтэй Нийгэм Форумас санаачлан “Монголын нутгийн удирдлагын асуудалд холбогдох ном зүй”-г анх удаа гаргаж уншигч авхай танаа толилуулж байна.

Ном зүйг эмхтгэхдээ цаг хугацааны хувьд 1990 оноос өнөөдрийг хүртэл хугацааг хамааруулж, Нутгийн удирдлагатай холбоотой хууль, Засгийн газрын хөтөлбөр, бодлогын баримт бичиг болон Олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн төсөл, Ном, товхимол, гарын авлага, Эрдэм шинжилгээний бүтээл, судалгааны тайлан гэсэн үндсэн дөрвөн бүлгийн хүрээнд эх сурвалжуудыг цуглуулан хураангуйлсан болно.

Ном зүйд хамрагдсан бүтээлүүдийг эмхтгэхдээ Улсын Төв номын сан, Удирдлагын Академийн номын сан, Улс Төрийн Боловсролын Академийн номын сан, их дээд сургуулиудын номын сан, Нээлтэй Нийгэм Форумын Хөгжлийн Мэдээллийн Төв, Улсын Их Хурлын номын сан, болон НҮБХХ, АХБ, Дэлхийн Банк, холбогдох төсөл, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагын эх сурвалж, судалгааны фондуудыг шүүн судалсан болно. Түүнчлэн Интернетийн сүлжээгээр нилээдгүй сайтуудад хайлт хийж ном зүйг баяжуулсан.



## НОМ ЗҮЙГ АШИГЛАХ ЗААВАР

Ном зүйд орсон материалуудыг “1 Нутгийн удирдлагатай холбоотой хууль”, “2 Засгийн газрын хөтөлбөр, бодлогын баримт бичиг, олон улсын байгууллагатай хамтарсан төсөл”, “3 Ном, товхимол, гарын авлага”, “4 Судалгааны тайлан, Эрдэм шинжилгээний бүтээл” гэсэн ерөнхий дөрвөн бүлэгт хувааж нэгдсэн дарааллаар байрлуулсан. Ном зүйд орсон бүтээл бүрийг дараах загвараар хураангуйлсан. Дараах жишээн дээр ном зүйд орсон материалыг хэрхэн загварчилсныг үзүүлэв:

**(1) 0336**

**(2) Монголын бүс нутгийн хөгжлийн эдийн засаг, математикийн загварчлал**

**(3) Р.Ринчинбазар**

**(4) Нэг сэдэвт бүтээл,**

**(5) 2004, Улаанбаатар,**

**(6) “ВСГ” ХХК-д хэвлэцлэв,**

**(7) 310 хуудас, Монгол**

**(8) Бүс нутгийн төдийгүй үндэсний хэмжээний нийгэм, эдийн засаг, экологийн тулгамдсан зорилтыг судалж, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах түвшинд ашиглаж болох математик загварчлал боловсруулах зорилготой бүтээл.**

Тогтвортой хөгжлийн чухал хүчин зүйл болох эдийн засаг, экологи, хүн амын эрүүл мэндийн асуудлыг авч үзсэн. Бүс нутгийн аж, ахуйн үйл ажиллагааг шинжлэх, бүсийн болон салбарын төлөвлөлтийг уялдуулах, үйлдвэрийн газрын бүтцийн өөрчлөлтийн шинжилгээ, үр ашгийн тооцоо хийх, жижиг, дунд үйлдвэрийн хөгжилд зээл, хөрөнгө оруулалтын үүргийг үнэлэх, ус, агаар, газар, ой, биологийн төрөл зүйл зэрэг байгалийн баялгийн нөөцийг зохистой ашиглах, хүрээлэн буй орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг судлах зэрэг асуудлуудыг багтаасан.

**(9) Бүс нутгийн эдийн засгийн математик загварчлалын онол, арга зүйн чиглэлээр хийгдсэн бүтээл болжээ.**

**(1) Бүтээлийн код.** Уг кодын эхний цифр болох 0 гэсэн хэсэг нь нутгийн удирдлагатай холбоотой материал гэсэн утгыг, дараагийн 3 гэсэн цифр тус ном зүйн

ерөнхий гуравдугаар бүлэгт хамаарахыг илтгэнэ, сүүлийн хоёр орон нь энэ бүлэгт орсон нийт бүтээлүүдийн дэс дугаар. Бүлэг дотор дэд бүлэг байгаа тохиолдолд дэд бүлгийн дугаар хэдээс эхлэнэ тэр бүлэгт орсон материалын дэс дугаар түүнээс хойших тоогоор илэрхийлэгдэнэ. Жишээ нь: 0300 Гарын авлага гэсэн байвал 0301 Багшийн гарын авлага, 0330 Ном, товхимол гэсэн салбарын кодтой 0331 гэсэн кодоор эхний бүтээл эхлэх жишээтэй. Бас нэг анхаарах зүйл нь бүлэг, салбар хоорондын код дараалж ороогүй байгаа нь тухайн бүлэг, салбарт нэмж материал оруулах тохиолдолд ашиглах зорилготой. Жишээ нь 3-р бүлгийн хувьд “Гарын авлага” гэсэн салбарын код 0301-ээс 0316 хүртэл яваад, дараагийн салбар болох “Ном, товхимол”-ын код 0331-ээс эхэлж байна. Энэ хоёрын хоорондох арван тоо нь нөөц кодын дугаар буюу цаашид ном зүйг өргөтгөхөд ашиглагдах учиртай.

- (2) Бүтээлийн нэр
- (3) Зохиогч/Хэвлэн нийтлэгч
- (4) Материалын төрөл
- (5) Он, хэвлэгдсэн газар
- (6) Хэвлэлийн газар
- (7) Бүтээлийн нийт хуудас, ямар хэл дээр хэвлэгдсэн байдал
- (8) Уг материалын товч агуулга гэсэн загвараар боловсруулсан.
- (9) Ташуугаар бичсэн энэ хэсэг нь тухайн материалын ач холбогдол, үр дүнгийн талаар уг ном зүйг хураангуйлсан судлаачдын дүгнэлт хэсэг болно.

Дээрх загвар нь эхний бүлэг болох хуулиудын хувьд толгойн хэсэгт код, хуулийн нэр, батлагдсан он, нэмэлт өөрчлөлт орсон он, нутгийн удирдлагад холбогдох заалтууд, товч агуулга гэсэн загвараар бичигдсэн болно.

Мөн хоёрдугаар бүлгийн хувьд төсөл, хөтөлбөр, бодлогын баримт бичиг, төслийн тайлан дээр зохиогч, хэвлэгчээр тус төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагыг бичсэнийг анхаарах хэрэгтэй.

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР**

<b>АХБ</b>	Азийн Хөгжлийн Банк
<b>ИТХ</b>	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
<b>ЗДТГ</b>	Засаг даргын тамгын газар
<b>ШОУХА (SIDA)</b>	Шведийн Олон Улсын Хөгжлийн Агентлаг
<b>ШТЗИ (SIPU)</b>	Шведийн Төрийн Захиргааны Институт
<b>МНУХ (MALA)</b>	Монголын Нутгийн Удирдлагын Холбоо
<b>ШНУХ (SALA)</b>	Шведийн Нутгийн Удирдлагын Холбоо
<b>НҮБХХ</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
<b>ТББ</b>	Төрийн бус байгууллага
<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>ОНУХС</b>	Орон Нутгийн Удирдлагын Хөгжлийн Сан
<b>НҮБ</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллага
<b>ТБУСТХ</b>	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилийн тухай хууль
<b>НӨҮЁ</b>	Нутгийн өөрөө удирдах ёс
<b>ЮНЕСКО</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага
<b>SALA IDA</b>	Шведийн Нутгийн Удирдлагын Холбооны зөвлөгөө өгөх компани
<b>НӨАТ</b>	Нэмэгдсэн өртгийн албан татвар
<b>МЭӨ</b>	Манай эриний өмнөх
<b>ДНБ</b>	Дотоодын нийт бүтээгдэхүүн
<b>НИХТ</b>	Нутгийн Иргэдийн Хөгжлийн Төв
<b>ӨАДХГ</b>	Өрхийн Амьжиргааг Дээшлүүлэх Хөтөлбөрийн Газар

# 1. НУТГИЙН УДИРДЛАГАТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ

**0101****Монгол Улсын Үндсэн хууль**

*Батлагдсан он: 1992*

*Нэмэлт өөрчлөлт орсон: 2000*

*Холбогдох заалтууд: 1[1.1, 1.2, 2.2, 3.1], 3[25.11, 25.12], 4 бүлгийн бүх заалт*

Монгол Улсын анхны ардчилсан Үндсэн хууль 1992 онд батлагдсан ба уг хуулийн нэгдүгээр бүлэгт

- Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, бүгд найрамдах улс мөн.  
(1-р зүйлийн 1)
- Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.  
(1-р зүйлийн 2)
- Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна. (2-р зүйлийн 1)
- Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана.  
(2-р зүйлийн 2)
- Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ (3-р зүйлийн 1) гэж заасан байдаг.

Монгол Улс нь төрийн байгууламжийн хувьд нэгдмэл буюу unitary<sup>1</sup> улс юм. Өөрөөр хэлбэл хууль тогтоох болон засаглах эрх бүхий нэг субъект байх ба засаг захиргааны нэгжүүд нь засаглалын хувьд салан тусгаарлах боломж нөхцөл байхгүй гэсэн санааг агуулдаг. Энэ зарчмын дагуу Улсын Их Хурал нь хууль тогтоох дээд байгууллага бөгөөд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг Засгийн газраас өргөн мэдүүлснийг үндэслэн хэлэлцэж өөрчлөх, батлах, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын зохион байгуулалт, эрх зүйн үндэсийг тогтоох зэрэг эрхтэй байдаг. Товчоор хэлбэл төрөөс орон нутагт олгох эрх, хэмжээ, чиг үүргийг Улсын Их Хурал шийднэ гэсэн үг.

<sup>1</sup>-Нутаг дэвсгэр нь зөвхөн засаг захиргааны нэгжүүдэд хуваагдах ба нэгдмэл засагтай байна гэсэн санаа. Орчин үеийн төрийн байгууламжийг холбооны ба нэгдмэл/unitary засаглалтай улсууд гэж хуваадаг.

Үндсэн хуулийн дөрөвдүгээр бүлэг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага гэсэн нэртэй. Энэхүү бүлгээр орон нутгийн удирдлагын үндсэн зарчим, удирдлагын байгууллагуудын эрх, хэмжээ тэдгээр хоорондын болон тэдгээрээс төрийн байгууллагуудтай харилцах харилцааг зохицуулдаг.

Уг бүлгийн тавин долдугаар зүйлийн нэгд “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана”, тавин наймдугаар зүйлийн нэгд “Аймаг, нийслэл, сум дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” гэж тус тус заасан байдаг.

Засаг захиргааны нэгжийн удирдлагын зарчмыг Үндсэн хуульд “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ” гэж зохицуулсан (59-р зүйл 1). Нутгийн өөрөө удирдах байгууллага нь ИТХ болон Иргэдийн нийтийн хурал, тухайн хурлын хуралдааны чөлөөт цагт түүний тэргүүлэгчид байна гэж заажээ. Харин тухайн нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ гэжээ.

Засаг дарга тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн хувьд харъяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар, харъяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын өмнө хариуцна. Засаг дарга тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй байдаг.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол Нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болдог.

Үндсэн хуульд нутгийн өөрөө удирдах ёс гэж чухам юуг хэлэх, ямар зарчмуудыг хангасан байх зэргээр түүний агуулгыг бүрэн илэрхийлэх тодорхой заалт байхгүй ба зөвхөн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн өөрөө удирдах ёс гэсэн хэллэгүүдийг хэрэглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл нутгийн өөрөө

удирдах зарчим гэж юу болох, түүний санхүү, төсөв, боловсон хүчин, зохион байгуулалт, эрх зүйн баталгааг хангах зарчим, арга замуудыг Үндсэн хуульд тодорхой тусгаагүй гэсэн шүүмжлэл манай судлаач, эрдэмтдийн дунд байдаг.

Тухайлбал, Үндсэн хуульд Засаг дарга тухайн шатны хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй гэж заасан. Энэ нь практикт ойлгомжгүй асуудлуудыг бий болгож байдаг. Жишээ нь: Өөрийн эрх ашигт нийцсэн шийдвэр бүрт хориг тавих уу гэх мэт олон асуудлуудыг гаргаж ирдэг. Уг нь хуульд нийцээгүй шийдвэрт гэж заасан бол агуулгын хувьд илүү ойлгогдохоор санагддаг. Ер нь хурлын шийдвэрт түүний шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий Засаг дарга хориг тавьж байгаа нь нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр хэрэгжих бодит чадвартай байна гэсэн нутгийн өөрөө удирдах ёсны тухай олон улсын түгээмэл зарчимтай зөрчилдөж байдаг.

## **0102**

### **Авто тээврийн тухай хууль**

*Батлагдсан он: 1999*

*Нэмэлт өөрчлөлт орсон: 2003*

*Холбогдох заалтууд: 2[7]*

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрхэд дараах асуудал хамаарна. Тухайлбал, нутаг дэвсгэртээ авто тээврийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, авто тээврийн талаар төрөөс баримтлах бодлоготой уялдуулан тухайн нутаг дэвсгэрт авто тээврийн талаар баримтлах бодлого боловсруулж хэрэгжүүлэх, авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран нутаг дэвсгэртээ авто тээврийн улсын хяналт хэрэгжүүлэх, нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийг тухайн нутаг дэвсгэрт зохицуулах, зохион байгуулах, хүн амын нутагшил, байршлын онцлог, зорчигч ба шуудан тээвэрлэлтийн хэрэгцээнээс шалтгаалан өрсөлдөх боломжгүй чиглэлд орон нутагт зорчигч, шуудан тээвэрлэлтийг зохих нөхөн төлбөр олгох нөхцөлтэйгээр тээвэрлэгчтэй гэрээ хийж гүйцэтгүүлэх зэрэг асуудлууд орно.

**0103****Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль**

*Батлагдсан он: 2001*

*Нэмэлт өөрчлөлт орсон: 2002, 2005*

*Холбогдох заалтууд: 2[16.2, 16.3]*

Дараахь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зөвшөөрөл олгоно. Үүнд: Аймаг хооронд, орон нутаг, хотын доторхи болон хот орчмын нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх, эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, хортой, бага хортой химийн бодис үйлдвэрлэх, импортлох, устгах, ерөнхий боловсролын сургууль байгуулах, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зэрэг хуульд заасан бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.

Дараахь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд сум, дүүргийн Засаг дарга тусгай зөвшөөрөл олгоно. Үүнд: Агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх, суурин эх үүсвэр ашиглах, орон нутагт нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх (энэ хэсэг дүүргийн Засаг даргад хамаарахгүй), цэцэрлэг байгуулах зэрэг хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

**0104****Ашигт малтмалын тухай хууль**

*Батлагдсан он: 2002*

*Нэмэлт өөрчлөлт орсон:*

*Холбогдох заалтууд: 2 [33.1, 33.2 33.3]*

Нутгийн захиргааны байгууллага нь дараахь эрх, үүрэгтэй. Үүнд: Нутаг дэвсгэртээ энэ хууль болон дээд шатны байгууллагын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, хууль тогтоомжоор ашигт малтмал хайх, ашиглахыг хязгаарласан эсхүл хориглосноос бусад тохиолдолд лицензийн тухай мэдээлэл авч тухайн газрыг уг лицензид заасан зориулалтаар ашиглуулах, байгаль орчныг хамгаалах, ажиллагсад болон оршин суугчдын эрүүл ахуйн нөхцөл, аюулгүй байдлыг хангах талаар болон орон нутгийн төсвийн өмнө хүлээсэн үүргээ лиценз эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, шалгалт хийх, эдгээртэй холбогдох мэдээ, тайланг гаргуулж авах зэрэг хуульд заасан бусад эрх үүргүүд орно.



**0105****Аялал жуулчлалын тухай хууль***Батлагдсан он: 2000**Нэмэлт өөрчлөлт орсон: 2001**Холбогдох заалтууд: 4[18]*

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь аялал жуулчлалын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Эдгээрт: Нутаг дэвсгэртээ аялал жуулчлалын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, шаардлагатай гэж үзвэл энэ талаар Засаг даргын тайланг хэлэлцэх, аялал жуулчлал хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг аялал жуулчлалын нөөц бүсэд хамруулах талаар аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал оруулах, нутаг дэвсгэртээ аялал жуулчлал хөгжүүлэх хөтөлбөр батлах зэрэг багтана.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга аялал жуулчлалын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд: Аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогыг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлж, аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах, зохион байгуулах, эрх хэмжээнийхээ хүрээнд тухайн газар нутагт байгуулах жуулчны үйлчилгээний байгууллагад газар эзэмших зөвшөөрлийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон тоо, байршлыг баримтлан зохих хууль тогтоомжийн дагуу олгож гэрээ байгуулах, нутаг дэвсгэртээ аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх бодлоготой уялдуулан хөтөлбөр, төсөл боловсруулж, зохих шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал оруулах, батлагдсан хөтөлбөрийн дагуу аялал жуулчлал хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрээрээ дайран өнгөрч яваа жуулчдаас хуульд зааснаас бусад тохиолдолд татвар, төлбөр, хураамж авахгүй байх зэрэг хуульд заасан бусад эрх үүргийг эдлэнэ.

**0106****Байгаль орчныг хамгаалах тухай хууль**

*Батлагдсан он: 1995*

*Нэмэлт өөрчлөлт орсон: 1998, 2003, 2005*

*Холбогдох заалтууд: 3[16, 17, 18]*

Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд: Нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих, нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоох, байгаль орчны улсын тусгай хамгаалалтад ороогүй объектыг орон нутгийн хамгаалалтад авах шийдвэр гаргаж, түүний хилийн зааг, хамгаалалтын дэглэм тогтоож, биелэлтэд нь хяналт тавих, хот, тосгон, бусад суурин болон амралт, сувиллын газар, гол, мөрний эх, нуур, рашаан, булаг, шанд, уст цэгийн орчинг хамгаалах, эрүүл ахуйн шаардлагыг хангах тусгай бүсийн заагийг тогтоох, байгаль орчны төлөв байдал, мэдээллийн сангийн тухай Засаг даргын мэдээлэл, тайланг хэлэлцэх зэрэг хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд: Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, байгаль орчны мэдээллийн сангийн мэдээ, баримтыг төрийн захиргааны төв байгууллагад хугацаанд нь ирүүлэх, нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар төрийн хяналт тавих байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах, нутаг дэвсгэртээ ажиллах байгаль орчны улсын ахлах болон улсын байцаагчийг энэ хуульд

заасны дагуу ялгах тэмдэг, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар хангах зэрэг багтана.

## **0107**

### **Боловсролын тухай хууль**

*Батлагдсан он: 2002.05*

*Нэмэлт өөрчлөлт орсон: 2002.07*

*Холбогдох заалтууд: 4[29,30,31,32]*

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал боловсролын асуудлаар дараах бүрэн эрхтэй. Үүнд: Боловсролын асуудлаар тухайн шатны ба доод шатны Засаг даргын тайлан хэлэлцэж, чиглэл өгөх, орон нутгийн харьяаллын боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавих, зохих нормативыг үндэслэн боловсролын байгууллагын төсвийг баталж, түүний гүйцэтгэл, зарцуулалтад хяналт тавих зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд: Боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, иргэнд суурь боловсрол эзэмшүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэжил эзэмшүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх, орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах, батлагдсан төсвийг хуваарилан олгох, өөрийн орлогоо нэмэгдүүлэхэд нь боловсролын байгууллагад дэмжлэг үзүүлэх, тэдгээрийг хичээлийн болон дотуур байр, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном, сурах бичгээр хангах ажлыг зохион байгуулах, төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх, ерөнхий боловсролын сургууль байгуулахад тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгэх, багш, суралцагчийн нийгмийн баталгааг сайжруулах, тэдний хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, хяналт тавих, боловсролын тайлан, мэдээ, мэдээллийг холбогдох байгууллагад гаргаж өгөх, орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн захирлыг томилох, чөлөөлөх, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын боловсролын асуудал эрхэлсэн нэгжийн болон боловсролын төвийн даргыг томилох, чөлөөлөх зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

*Боловсролын цйлчилгээтэй хамаатай нутгийн удирдлагын байгууллагуудын эрх, хэмжээ, чиг үүргийг засаг захиргааны өөр түвшиний нэгжүүдэд нэг маягаар адилтган зохицуулсан. Тухайлбал аймаг, нийслэлийн Засаг дарга, ИТХ нь уг хуулиар сум, дүүргийн Засаг дарга, ИТХ-тай ижил эрх, хэмжээтэй байна. Аль шатанд юу хариуцах талаар нарийн зааг, ялгаа байхгүй байна.*

## **0108**

### **Газрын тухай хууль**

*Батлагдсан он: 2002*

*Нэмэлт өөрчлөлт орсон: Ороогүй*

*Холбогдох заалтууд: 2[20, 21, 22]*

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь газрын асуудлаар дараах нийтлэг бүрэн эрхийг эдлэнэ. Үүнд: Хуулийн хэрэгжилтийг хангах, гарсан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлж гаргасан сум, дүүргийн тухай жилийн газрын төлөвлөгөөг хэлэлцэн батлах, Засаг даргын мэдүүлснийг үндэслэн сум, дүүргийн тусгай зөвшөөрлийн газрыг олгох журам батлах зэрэг бүрэн эрх багтана.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж хангах, газар эзэмшигч, ашиглагчаас газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, газрыг тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг газар эзэмшигч болон тухайн шатны Засаг даргатай тохиролцсоны дагуу Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, газар эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон доод шатны Засаг даргын хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, зөрчлийг арилгах арга хэмжээ авах, тухайн шатны газрын албаны дарга болон газрын даамлыг томилох, чөлөөлөх асуудлаар эрх бүхий байгууллагад санал өгөх, газар эзэмшигч, ашиглагч нь хууль тогтоомж, гэрээнд заасан үүргээ хангалтгүй биелүүлснээс байгаль орчинд сөргөөр

нөлөөлж байгаа тухай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан санал, гомдлын талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулах хүсэлтээ Засгийн газрын эрх бүхий байгууллагад гаргах зэрэг бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

## **0109**

### **Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль**

*Батлагдсан он: 2002*

*Нэмэлт өөрчлөлт орсон: 2003*

*Холбогдох заалтууд: Бүх заалт*

Энэ хуулиар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний удирдлагын тогтолцоо, эрх хэмжээ, үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалттай холбоотой харилцааг зохицуулдаг. Засаг захиргааны нэгж дахь төрийн болон нутгийн өөрийн удирдлага хоорондын эрх мэдэл, ерөнхий чиг үүргийн хуваарилалт, удирдлагын үндсэн зарчмыг тодорхойлж өгсөн.

Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн гэж тодорхойлсон. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ.

Хуулиар бүх шатны хурал, Засаг даргын эрх, хэмжээ, үүрэг, хариуцлагын хүрээг тодорхойлж хурал болон Засаг дарга хоорондын харилцааны үндсийг зохицуулдаг. Түүнчлэн хурлын байгууллагын үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалт, бүтэц, хурлын ээлжит ба ээлжит бус хуралдаан, түүнийг зарлах, шийдвэр гарах зэрэг харилцааг тодорхойлсон.

*Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн ялгаатай нэгжүүд дэх Засаг дарга, хурлын эрх хэмжээг ижил агуулгатайгаар, нэгэн төрлийн байдлаар тодорхойлж өгсөн байдаг. Өөрөөр хэлбэл аймаг, нийслэлийн Засаг дарга, Хурлын эрх хэмжээг түүний доод нэгжийн буюу сум, дүүргийн Хурал, Засаг даргын эрх хэмжээтэй нэг маягаар адилтган зааж өгчээ. Нутгийн удирдлагын эрх бүхий субъект Засаг дарга, Хурлуудын хоорондын харилцаа, эрх мэдлийн талаар тодорхой заасан хэдий ч тэдгээрийн ард иргэд, иргэний нийгмийн өмнө хүлээх хариуцлага, тайлагнах механизмын талаар нарийвчлан тодорхойлоогүй байна.*

**0110****Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль**

*Батлагдсан он: 2002*

*Нэмэлт өөрчлөлт орсон: Ороогүй*

*Холбогдох заалтууд: 1[7.1, 7.2] ; 2[11,12,13,14,15,16]*

Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутаг дэвсгэртээ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, тухайн жилд аймаг, нийслэлийн хэмжээнд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээний талаар аймаг, нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн саналыг сум, дүүрэг тус бүрээр хэлэлцэх, газар өмчлүүлэх ажлын явцад хяналт тавьж, шаардлагатай гэж үзвэл энэ асуудлаар тухайн шатны Засаг даргын тайланг хэлэлцэх зэрэг бүрэн эрхтэй.

Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд: Иргэдэд газар өмчлүүлэх талаархи төрийн нэгдсэн бодлого, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах, сум, дүүргийн Засаг даргын саналыг хянаж нэгтгэн тухайн жилд аймаг, нийслэлийн хэмжээнд иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээний тухай саналыг сум, дүүрэг бүрээр, энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан зориулалт тус бүрээр боловсруулж аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх, аймгийн төвийн сумын Засаг дарга болон нийслэлийн дүүргийн Засаг даргын өргөн мэдүүлснээр иргэний газар өмчлүүлэх тухай өргөдлийг хүлээн авч, тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн газар өмчлүүлэх тухай шийдвэр гаргах, аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр газар өмчилж авсан иргэн өмчийнхөө газрыг гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөл, эзэмшилд шилжүүлсэн, газар тариалангийн газрыг зориулалт бусаар ашигласан, хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан тохиолдолд тухайн газрыг хураан авах шийдвэр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

**0111****Монгол Улсын татварын ерөнхий хууль**

*Батлагдсан он: 1992*

*Хамгийн сүүлд нэмэлт өөрчлөлт орсон: 2001*

*Холбогдох заалтууд: 2[15- 18, 21.1-21.5]*

Энэ хуулиар Монгол Улсын үндэсний татварын тогтолцоо, албан татвар, хураамж, төлбөрийн нийтлэг зарчим, татвар төлөгчийн эрх, үүрэг, хариуцлага, үндэсний татварын алба, татварын улсын байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, эдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

Монгол Улсын үндэсний татварын тогтолцоо албан татвар, хураамж, төлбөрөөс бүрдэнэ. Монгол Улсын татвар нь улсын болон орон нутгийн татвараас бүрдэнэ. Улсын татварын хувь хэмжээг Улсын Их Хурал, Засгийн газраас тогтоож Монгол Улсын нутаг дэвсгэрт нийтлэг үйлчилдэг. Аймаг нийслэлийн ИТХ-аас хувь хэмжээг нь тогтоож, тухайн нутаг дэвсгэрт үйлчлэх татварыг орон нутгийн татвар гэдэг. Орон нутгийн татварт дараах татварууд хамаарагдана. Үүнд :

1. Бууны албан татвар
2. Нийслэл хотын албан татвар
3. Нохойны албан татвар
4. Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар
5. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
6. Улсын тэмдэгтийн хураамж
7. Ус, рашаан ашигласны төлбөр
8. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
9. Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж
10. Байгалийн ургамал ашигласны төлбөр
11. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
12. Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж
13. Газрын төлбөр
14. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр.

Үндэсний татварын алба нь Үндэсний Татварын Ерөнхий газар, нийслэл, аймаг, дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын улсын байцаагчаас бүрдэнэ. Үндэсний Татварын Ерөнхий газар Сангийн сайдын, нийслэл, аймгийн татварын газар, хэлтэс Үндэсний Татварын Ерөнхий газрын, дүүргийн татварын хэлтэс, сумын татварын улсын байцаагч нийслэл, аймгийн татварын газар, хэлтсийн удирдлага дор тус тус ажиллана.

Үндэсний Татварын Ерөнхий газрын дарга нь нийслэл, аймгийн татварын газар, хэлтсийн даргыг, нийслэлийн татварын газрын дарга нь дүүргийн татварын хэлтсийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилно.

## **0112**

### **Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль**

*Батлагдсан он: 1994*

*Хамгийн сүүлд нэмэлт өөрчлөлт орсон: 1995*

*Холбогдох заалтууд: Бүх заалт*

Энэ хуулиар Монгол Улсын нийслэлийн чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх эдийн засгийн үндэс, удирдлагын эрх хэмжээ, онцлог, нийслэлээс аж ахуйн нэгж, байгууллага, иргэд болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй харилцааг зохицуулдаг.

Нийслэл нь хуулиар тусгайлан олгосон онцлог чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор бөгөөд тусгай статус бүхий хот мөн. Нийслэл нь засаг захиргааны хувьд дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана. Нийслэл нь эдийн засгийн дэд бүтцийг тэнцвэртэй хөгжүүлэх, хүн амын хэт төвлөрөл болон хотын хангамж, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах, оршин суугчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгаль орчны зохистой харьцааг хадгалах үүднээс дагуул хот /алслагдсан дүүрэг, хаяа хот, тосгон/-той байж болно.

Нийслэл нь Улсын Их Хурлаас баталсан хилийн цэс бүхий нутаг дэвсгэртэй байх бөгөөд түүний дотор хотын эдэлбэр газар байна. Нийслэлийн удирдлагын тогтолцоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан ёсоор бүрдэнэ.

Мөн хуульд нийслэлийн удирдлагын эрх, хэмжээ, чиг, үүрэг, нийслэлийн төсөв, өмч, сантай холбогдох харилцааг тусгасан.



**0113****Төрийн болон орон нутгийн өмчийн тухай**

*Батлагдсан он: 1996*

*Хамгийн сүүлд нэмэлт өөрчлөлт орсон: Ороогүй*

*Холбогдох заалтууд: 3[10.5]*

Энэ хуулиар төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаархи бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулдаг.

Орон нутгийн өмч нь нийтийн зориулалттай өмч, орон нутгийн өөрийн өмчөөс бүрдэнэ. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна.

**0114****Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль**

*Батлагдсан он: 2002*

*Нэмэлт өөрчлөлт орсон: Ороогүй*

*Холбогдох заалтууд: 1[4.1.1, 4.1.3]; 2[11.1.12-11.1.15]; 5[45.1, 46.1]; 6[50-59]*

Энэ хуулиар төсвийн байгууллагуудын төсвийг батлах, төсвийн төсөл боловсруулах, зарцуулах, хянах, тайлагнахтай холбоотой эрх хэмжээ, төсвийн удирдлагын зарчмыг тодорхойлж өгсөн.

Орон нутгийн төсөв гэж орон нутгийн орлого, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, улсын төсвийн хөрөнгөөр худалдан авах бүтээгдэхүүний санхүүжилтийн нийлбэрийг үздэг. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын тэргүүлэгчдийн дарга тухайн шатны ИТХ-ын төсвийн ерөнхийлөн захирагч байна. Нийслэлийн Засаг дарга нийслэлийн төсөв болон нийслэлийн захирагчийн албаны төсвийн, аймгийн Засаг дарга аймгийн төсвийн, сум, дүүргийн Засаг дарга сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хэтийн төлөвлөгөөг хэлэлцэн батлаж, хэрэгжилтэнд нь хяналт тавих, орон нутгийн

төсвийг хэлэлцэн батлах, хэрэгжилтийг нь хянах үүрэгтэй. Орон нутгийн төсвөөс санхүүжигдэх бүтээгдэхүүний тоо хэмжээг тогтоож, бүтээгдэхүүнийг нийлүүлэх талаар Засаг даргатай гэрээ байгуулж ажиллана. ИТХ нь Засаг Даргын улсын төсвийн хөрөнгөөр бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний төсөлтэй танилцаж, бүтээгдэхүүний тоо хэмжээ, зардал, гэрээг дүгнэх болзол, журмын талаар санал, дүгнэлт гаргах эрхтэй.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь улсын төсвөөс санхүүжүүлэх (боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ болон бусад) бүтээгдэхүүнийг нийлүүлэх талаар тухайн асуудал эрхэлсэн сайдтай болон дээд шатны Засаг даргатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг зохион байгуулахын хамт орон нутгийн хэрэгцээт бүтээгдэхүүнийг нийлүүлэх, хэрэгжилтийг хангах үүрэгтэй. Орон нутгийн төсвийн төслийг Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн шатны ИТХ хэлэлцэн баталдаг.

*Улсын төсвөөс санхүүжүүлэх бүтээгдэхүүний тоо, хэмжээ, зардлыг яамдууд тогтоож байгаа нь бодит байдалд ИТХ-ын орон нутгийн төсвийг хэлэлцэж, батлах ажил нь ёс төдий зүйл байна. Угтаа орон нутгийн төсөв нь нутгийн захиргааны байгууллагуудын (ЗДТГ-ын төсөв, ИТХ-ын төсөв, баг, хорооны төсөв) төсвөөс бүрдэж байна. Бусад салбарын (боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ болон бусад) төсөвт нутгийн захиргааны байгууллагуудын оролцоо хумигдсан гэж үздэг.*

*Хуульд төрийн байгууллагууд хоорондын тайлагнах, мэдээлэх, хариуцлага тооцох механизмыг тодорхой зааж өгсөн хэдий ч тэдгээр байгууллагуудаас иргэд болон иргэний нийгэмд тайлагнах, мэдээлэх тухай заалтууд хангалтгүй тусгагдсан.*

## **0115**

### **Усны тухай хууль**

*Батлагдсан он: 2004*

*Нэмэлт өөрчлөлт орсон: Ороогүй*

*Холбогдох заалтууд: 2[13,14,15,16,17,18]*

Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд нь нутаг дэвсгэртээ ус хуримтлуулах, нөхөн сэргээх, зохистой ашиглах, чанарыг нь хамгаалах, усны хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, уршгийг арилгах арга хэмжээний төлөвлөгөө, түүнийг

хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, сум дундын болон дүүрэг дундын ус ашиглалт, хуваарилалтыг зохицуулах, усны нөөц хомсдох, чанар нь алдагдах, бохирдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны болон ахуйн хэрэгцээний усаар хангах арга хэмжээ авах зэрэг багтана.

## **0116**

### **Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль**

*Батлагдсан он: 1993*

*Хамгийн сүүлд нэмэлт өөрчлөлт орсон: 2003*

*Холбогдох заалтууд: Бүх заалт*

Уг хуулиар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгон, тэдгээрийн нийгэм, эдийн засгийн үндэс, удирдлагын үйл ажиллагааны зарчим, тогтолцоо, бүрэн эрхийг тодорхойлж, хот, тосгоны удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон аж ахуйн нэгж, байгууллага, оршин суугчидтай харилцах харилцааг зохицуулдаг.

Хуулиар хотыг 15000-аас доошгүй оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь голлон үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн, өөрийн удирдлага бүхий төвлөрсөн суурин газар гэж тодорхойлсон байдаг. Тосгон нь 500-15000 оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газрыг хэлдэг.

Хот нь улсын болон аймгийн зэрэглэлд хуваагддаг. Хот, тосгон нь засаг захиргааны хувьд оршин байгаа тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт харьяалагдана. Хот, тосгон нь эдэлбэр газартай байна. Хот, тосгон нь удирдлагын болон хөгжлийн санхүүгийн үндэс болсон хөрөнгийн сантай байна. Улсын зэрэглэлтэй хотын хөрөнгийн сан нь улсын ба орон нутгийн төсвөөс, аймгийн зэрэглэлтэй хот, тосгоны хөрөнгийн сан нь тухайн орон нутгийн төсвөөс тэдгээрийн мэдэлд хуваарилсан төсвийн хөрөнгө, түүнчлэн хот, тосгоны өөрийн мэдлийн аж ахуйгаас бий болсон орлого, гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүсээс өргөсөн хандив, буцалтгүй тусламж, бусад орлогоос бүрдэнэ.

Хот, тосгоны удирдлага нь захирагч, зөвлөлөөс бүрдэнэ. Хот, тосгоны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлж зохион байгуулах үүргийг захирагч гүйцэтгэнэ. Хот, тосгоны зөвлөлийг тухайн хот, тосгоны нийгэм, эдийн засагт нөлөө бүхий аж ахуйн нэгж, байгууллага болон захирагчийн ажлын албаны хүмүүсийг оролцуулан 5-11 хүний бүрэлдэхүүнтэйгээр захирагч байгуулна.

Хот, тосгоны зөвлөлийг захирагч тэргүүлнэ. Аймаг, сум, багийн төв болох хот, тосгоны удирдлагын бүрэн эрхийг тухайн хот, тосгон оршин байгаа засаг захиргааны нэгжийн засаг дарга хэрэгжүүлнэ. Хот, тосгоны захирагчийг тухайн хот, тосгоны сонгуулийн эрх бүхий оршин суугчид нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, 4 жилийн хугацаагаар сонгоно.

*Хот тосгоныг хуульд өөрийн удирдлага бүхий гэж тодорхойлсон боловч нилээд хэдэн заалтууд нь өөрийн удирдлагын зарчимтай зөрчилддөг. Тухайлбал, хот, тосгоны зөвлөлийг оршин суугчдын сонгуулиар бус захирагч байгуулдаг, санхүү, төсвийн хувьд оршин байгаа засаг, захиргааны нэгжээс хамааралтай, захирагчийн ажлын албыг өөрөө бус Засгийн газраас нэг маягаар тогтооно гэж хуульчилсан зэрэг нь өөрийн удирдлагын үндсэн зарчмыг бүрэн хангаж чаддаггүй.*

## **0117**

### **Эрүүл мэндийн тухай хууль**

*Батлагдсан он: 1998*

*Нэмэлт өөрчлөлт орсон: 2002, 2003*

*Холбогдох заалтууд: 2[9, 10]*

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь эрүүл мэндийн асуудлаар дараах бүрэн эрхийг эдлэнэ. Үүнд: Нутаг дэвсгэртээ авч явуулах эрүүл мэндийг хамгаалах, дэмжих арга хэмжээ, түүнд шаардагдах төсвийг баталж, хэрэгжилтэд хяналт тавих, хүн амын эрүүл мэндийн асуудлаар Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэн дүгнэлт өгөх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар хөтөлбөр, шийдвэр гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих, эрүүл мэндийг хамгаалах, дэмжих арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, иргэний хамтын оролцоог хангаж, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах зэрэг хуульд заасан бусад бүрэн эрх багтана.

Бүх шатны Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд: Нутаг дэвсгэртээ хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжихэд шаардагдах хөрөнгийг төлөвлөж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, гүйцэтгэлд нь хяналт тавих, эрүүл мэндийн талаархи хууль тогтоомж болон дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангуулах, мэдээлэх, нутаг дэвсгэртээ хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөр, чиглэл боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулах, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн нутаг дэвсгэртээ эрүүл мэндийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, зөв байршуулах, боловсон хүчин, материаллаг бааз, санхүүгийн нөөцийг зохистой хуваарилах, байгалийн гамшиг, томоохон осол болон олон улсын хөл хориот өвчин гарсан тохиолдолд холбогдох арга хэмжээг шуурхай авах зэрэг хууль тогтоомжинд заасан бусад бүрэн эрхийг бүх шатны Засаг дарга эдлэнэ.

**2. ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ,  
БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ,  
ТӨСЛИЙН ТАЙЛАН**

## **0200 ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ**

### **0201**

#### **Ардчилсан Монгол дахь сайн засаглал**

*ШОУХА -ийн санхүүжилтээр Монгол Улсын Засгийн газар болон ШТЭИ хамтран хэрэгжүүлсэн, төсөл, 2002-2005, Улаанбаатар, Монгол Улс*

Энэ төслийн гол зорилго нь хүмүүсийн ашиг сонирхолд нийцэх сайн засаглалыг бэхжүүлэх буюу төрийн бодлогыг үр дүнтэй, үр ашигтай, хэрэгжүүлэх, түүнийг боловсруулах төрийн албан хаагчийн чадварыг нэмэгдүүлэх болон хууль ёсыг сахиулахад чиглэгдсэн. Төсөл дараах үйл ажиллагаануудыг дэмжиж ажилласан. Үүнд:

- Сонгон авсан 3 яамны харъяа байгууллагуудын хөгжлийг дэмжих. Худалдаа Үйлдвэрийн, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн, Хууль зүй, Дотоод Хэргийн яамдуудад төслийн баг бий болгож, төрийн албан хаагчдын хөгжлийн асуудал болон байгууллагын төлөвлөлтийн тогтолцооны өөрчлөлтийн асуудлаар сургалт явуулж, зөвлөгөө өгч ажилласан.
- Төрийн удирдлагын хөгжлийн төв байгуулсан
- Шведэд суралцах аялалыг зохион байгуулж, төрийн албан хаагчдын манлайллын болон удирдлагын чадавхийг хөгжүүлсэн
- Төрийн албанд жендерийн асуудлыг авч үзэх, бодлогын хэрэгжилт болон стратегийн төлөвлөлтийн мэдээлэл, харилцаа, авилгалын эсрэг сүлжээг байгуулах зэрэг асуудлуудыг хөгжлийн хөтөлбөрт авч үзсэн.

Төслийн хүрээнд явагдсан хэд хэдэн удаагийн сургалт, семинараар сонгосон яамдын дунд шатны 220 гаруй удирдах ажилтнуудыг сургасан.

### **0202**

**“Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхийг бэхжүүлэх нь” төсөл**

**Capacity building for Decentralization and Local Self-Governance in Mongolia-I,II**

*Шведийн Олон Улсын Хөгжлийн Агентлагийн (ШОУХА) санхүүжилтээр Монгол Улсын Засгийн газар, Шведийн Төрийн Захиргааны Институт*

*(ШТЭИ) хамтран хэрэгжүүлсэн, төсөл, 1-р үе шат 1997-1999, 2-р үе шат 2001-2004, Монгол Улс*

Төслийн эхний үе шат 1997-1999 онуудад туршилтын зургаан аймагт хэрэгжсэн. Энэ үе шатанд үндэсний мастер сургагчдыг бэлтгэн туршилтын зургаан аймгийн ИТХ, ЗДТГ-ын албан хаагчдад нутгийн өөрөө удирдах ёс, түүний хууль эрх зүйн хүрээ, орон нутгийн санхүүгийн удирдлага, төрийн захиргааны менежмент, бизнес төлөвлөлт, төрийн ардчилсан удирдлага, төрийн үйлчилгээ зэрэг сэдвүүдээр сургалт явуулсан. Аймгийн ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, болон УИХ-ын зарим гишүүд Шведын коммунуудтай танилцах, туршлага судлах айлчлалд хамрагдсан.

Хоёрдугаар үе шат 2001-2004 онд хэрэгжсэн ба дараах гол 3 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан. Үүнд:

- (I) Сургалт ба хөгжлийн бүрэлдэхүүн хэсэг нь Улаанбаатар хотын 9 дүүрэг болон 21 аймгийн ИТХ, сумын ИТХ-ын төлөөлөгчид ЗДТГ-ын гол албан тушаалтнуудыг чадавхижуулах сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, сургагч нарын сургалтыг дэмжих,
- (II) Монголын Нутгийн Удирдлагын Холбоог (MALA) дэмжих, Шведийн Нутгийн Удирдлагын Холбоотой хамтран ажиллах (SALA) боломжийг бий болгох, улирал бүр гаргадаг “Нутгийн удирдлага” сэтгүүлд дэмжлэг үзүүлэх,
- (III) Орон нутгийн улс төр болон төрийн үйлчилгээн дэх ёс зүйн асуудал сэдвээр хийгдэх хавсрага судалгааны бүрэлдэхүүн хэсгийг дэмжих (2001-2004) зорилгуудыг тус тус агуулжээ.

Төслийн үр дүнд 21 аймаг, нийслэлийн 3,000 гаруй орон нутгийн төрийн албан хаагч болон улс төрчдийг нутгийн өөрөө удирдах ёс, төрийн удирдлага, иргэдийн оролцоо, орон нутгийн санхүү, төсөв болон бусад холбогдох сэдвээр сургасан. Сургалт нь эхлээд мастер сургагчдыг Швед зөвлөхийн тусламжтай бэлтгэж, мастер сургагчид орон нутгийн сургагч багш нарыг бэлтгэсэн. Орон нутгийн сургагчид нь орон нутагт ажиллаж буй төрийн албан хаагч болон ИТХ-ын ажилтан, төлөөлөгчдийг сургасан. Мастер сургагчаар 32, сургагчаар 153 хүн бэлтгэгдсэн. Нутгийн өөрөө удирдах ёс ба хууль, ардчилсан засаглал ба нутгийн өөрөө удирдах ёс, санхүүгийн удирдлага



ба нутгийн өөрөө удирдах ёс гэсэн гурван сэдвээр 28 ахисан түвшний сургагчдыг бэлтгэсэн.

Шведийн зөвлөхүүд, мастер сургагчид хамтран 10 гаруй сургалтын гарын авлага, материал боловсруулсан. Сургалтанд Улаанбаатар хотын 9 дүүрэг, бүх аймгийн удирдлагууд хамрагдсан. Нийт 3000 гаруй ИТХ-ын төлөөлөгчид төрийн захиргааны албан хаагчид хамрагдсан.

Төсөл Шведийн Нутгийн Удирдлагын Холбоо (ШНУХ), Монголын Нутгийн Удирдлагын Холбоотой (МНУХ) хоорондын хамтын ажиллагаа, туршлага солилцох ажлыг дэмжсэн. Үүнд: МНУХ-ны зохицуулагч болон мэргэжилтнүүдийг дагалдуулан сургах, МНУХ-ны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, МНУХ-ны сэтгүүлийн материал боловсруулах болон редакцийн зөвлөгөө өгөх, сургалт хийх, МНУХ-ны сэтгүүлийн хэвлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх болон МНУХ-ын ажилтануудыг Шведэд туршлага судлуулах, ижил төрлийн байгууллагатай холбоо тогтоох зэрэгт дэмжлэг үзүүлсэн болно.

Уг төслийн гурав дахь бүрэлдэхүүн хэсэг болох 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэгт асуулга, ярилцлагын аргаар хийгдсэн хавсрага судалгаа юм. Судалгааны үр дүнд дараах дүгнэлтэд хүрчээ. Үүнд: Төрийн албан хаагчид болон сонгогдсон ИТХ-ын тэргүүлэгчдийн ёс зүйн хэм хэмжээг ойлгож мэдэх, түүнийг үйл ажиллагаандаа сахих явдал сул байна. Ёс зүйгүй байдал нь Монголын нийгмийн тулгамдсан асуудал болоод байна гэж дүгнэжээ.

Судалгаанд төрийн албан хаагчдын ёс зүйтэй холбоотой дараах зөрчлүүд түгээмэл байгааг дурьдсан байна. Тухайлбал, төрийн албан хаагчид эрх мэдлийн төлөө хууль бусаар ажиллах, иргэдийг ялгаварлан харьцах, өөрийн сонирхолыг олон нийтийнхээс илүүд үзэх, аливаад хүнд суртал гаргах зэрэг зөрчлүүдийг нэрлэжээ.

ИТХ-ын төлөөлөгчийн ёс зүйн хамгийн хүнд зөрчилд сонгогч иргэдтэй уулзахгүй байх, тэдний ашиг сонирхолыг хангалттай төлөөлж ажиллахгүй байх, хурлын хуралдаанаас гарсан шийдвэрийг иргэдэд мэдээлэхгүй байх зэрэг доголдуудыг багтаасан байна.

Энэ төслийн хүрээнд дараах тайлан, гарын авлага боловсруулагдан хэвлэгдсэн. Үүнд:

- Төслийн үйл ажиллагааны жилийн тайлангууд англи, монгол хэл дээр
- “Монголын орон нутгийн өөрийн удирдлагыг сайжруулах” гарын авлага

хэвлэсэн (Монгол хэл дээр Хөх ном 3000 хувийг, хар ном 600 хувийг хэвлэсэн)

- “Шведийн ардчилсан засаглал-иргэдийн төлөөлөл” гэсэн нэмэлт гарын авлага (Монгол хэл дээр 300 хувь)
- “Сургалтаас тасралтгүй суралцахуйд” сургагчийн ном (200 хувийг монгол хэл дээр мөн цөөн хувийг Англи хэл дээр)
- Монголын төслийн удирлага гарын авлага (200 хувийг монгол хэл дээр мөн цөөн хувийг англи хэл дээр)
- Ахисан түвшний сургагч нарт зориулсан сурах бичгүүд. Үүнд: Нутгийн өөрөө удирдах ёс болон хууль, Ардчилсан засаглал болон нутгийн өөрөө удирдах ёс, Санхүүгийн удирдлага болон нутгийн өөрөө удирдах ёс гэсэн гурван сэдвээр (300 хувь хэвлэсэн) гарын авлага хэвлэсэн.
- “Орон нутгийн улс төрийн ёс зүйн асуудал” судалгааны жилийн тайлан 2002, 2003, судалгааны эцсийн тайлан 2004, Монгол хэл дээр

## 0203

**Төвлөрлийг сааруулах, нутгийн захиргааг өөрчлөн шинэчлэх хүрээ, үйл ажиллагааны төлөвлөгөө**

**(Government of Mongolia cabinet secretariat, Asian Development Bank),  
(Framework and Action Plan for Local government and Decentralization reform) (Ulaanbaatar, 1996)**

*Монгол Улсын Засгийн газрын Хэрэг Эрхлэх газар, Азийн Хөгжлийн Банк  
Бодлогын баримт бичиг, Засгийн газрын 1996 оны 11 сарын 9-ний өдрийн  
хуралдаанаар баталсан, Улаанбаатар, 122 хуудас, Монгол, Англи.*

Монгол Улсын Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийн төвлөрлийг сааруулах, нутгийн захиргааг бэхжүүлэх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 1996 онд Монгол Улсын Засгийн газар ба АХБ-ны техник туслалцааны хамтын ажиллагааны хүрээнд боловсруулагдсан баримт бичиг.

Тус баримт бичиг нь төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлийг орон нутгийн түвшинд гүнзгийрүүлэх талаар Засгийн газраас тавьж байгаа зорилтыг хэрэгжүүлэх, төв, орон нутгийн захиргаа, удирдлага, санхүүгийн харилцаа, нутаг дэвсгэрийн

нэгжүүдийн дотоод дахь зохион байгуулалтыг өөрчлөх, эдгээр өөрчлөлтийг хийж явуулахад тааламжтай орчныг бий болгох хууль зүйн зохицуулалтын хүрээг бий болгох, нутгийн удирдлагын чадавхийг бий болгоход чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөг тусгасан болно.

Энэхүү баримт бичигт Монгол Улсад төвлөрлийг сааруулах тогтолцоо, нутгийн захиргааг цаашид хөгжүүлэх хүрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөг дараах асуудлуудад хуваан авч тодорхойлсон. Үүнд:

- Төв ба орон нутгийн Төрийн захиргааны байгууллагууд хоорондын харилцааг өөрчлөх шинэчлэх тэргүүлэх чиглэлийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө
- Нутгийн захиргааны зохион байгуулалт, удирдлагын хүрээнд хийгдэх шинэчлэлийн тэргүүлэх чиглэлүүд
- Орлого, татвар бүрдүүлэх, орлого хуваарилах болон төв, орон нутгийн түвшин дэх улсын төсвийн зарлагын удирдлагын тогтолцоо, шилжүүлэг болон бусад санхүүгийн харилцаанд хийгдэх өөрчлөлт, шинэчлэлийн тэргүүлэх чиглэлүүд
- Одоогийн хууль зүйн зохицуулалтын хүрээ, түүнийг цаашид шинэчлэх шаардлага
- Төвлөрлийг сааруулах, нутгийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлийн хөтөлбөр зэрэг багтана.

Энэхүү шинэ хөтөлбөр нь Үндсэн хуулийн дагуу нэгдмэл удирдлагатай хэвээр байх, зарчмын хүрээнд нутгийн захиргааны байгууллагын ард иргэдийн хэрэгцээ, хүсэлтийг хангах талаар хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх, захиргаадалтаас илүү эдийн засаг, санхүүгийн арга нь нутаг дэвсгэрийн нэгжийг удирдах, эх үүсвэр хуваарилах гол механизм байх, орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, зохион байгуулалт, бүтцээ тодорхой хязгаарын хүрээнд нэгжүүд өөрсдөө тодоройлох зэрэг төвлөрлийг сааруулах гол зарчмуудыг агуулж байв.

*Хөтөлбөр нь төвлөрлийг сааруулах, нутгийн захиргааг шинэчлэх стратеги, чиглэлийг зах зээлийн эдийн засгийн харилцаанд үндэслэн, олон улсын хөгжлийн хандлагад нийцүүлэн өөрчлөх зарчмын гол үндэслэлийг тодорхойлж, хийх шинэчлэлийн хүрээг нэлээд нямбай байдлаар авч үзэж чадсан. Харамсалтай нь уг хөтөлбөрт тусгагдсан төвлөрлийг сааруулах гол зарчмууд бодит амьдралд өнөөг хүртэл хэрэгжээгүй байгаад судлаачид, бодлого тодорхойлогчид шүүмжлэлтэй*

ханддаг. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2-р үе шатанд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хууль батлагдсанаар орон нутгийн эрх мэдлийг боомилсон, төвлөрлийг улам гааруулсан бодит нөхцөл байдал үүсгэсэн гэж нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын төлөөлөгч, албан хаагчид үздэг болох нь өмнөх судалгаануудын үр дүнгээс харагддаг.

## **0204**

### **Төрийн захиргааны шинэчлэл хөтөлбөр**

*Монгол Улсын Засгийн газрын хөтөлбөр, 1996, Улаанбаатар, Монгол*

Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр Монгол Улсын Засгийн газар 1990-ээд оны дунд үеэс хэрэгжиж эхэлсэн хөтөлбөр юм. 1997 оноос Засгийн газрын төрийн захиргааны шинэчлэл хөтөлбөрт АХБ-наас дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байгаа билээ. Хөтөлбөрийн зорилго нь төрийн байгууллагуудыг олон нийтийн өмнө илүү нээлттэй, ил тод, хариуцлагатай ажилладаг болгоход чиглэгдэнэ. Үүний тулд иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний зохион байгуулалт, хүргэлт, санхүүжилтийн хүрээнд зарчмийн том өөрчлөлт оруулах шаардлагатай болсон. Энэ зорилгыг хэрэгжүүлэх үүднээс Төрийн захиргааны шинэчлэл хөтөлбөрийн хүрээнд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль 2002 онд батлагдсан.

Энэхүү хөтөлбөрийн үзэл санаа нь төвлөрлийг сааруулах бодлогын үргэлжлэл байхаар төлөвлөгдөж байв. Хөтөлбөрийн үр дүнд нутгийн өөрөө удирдах байгууллага ба төрийн удирдлагын байгууллагууд хоорондын чиг үүргийг тодорхой болгосон, төрийн захиргааны төв байгууллагууд болон бусад босоо удирдлагатай байгууллагуудын төсвийн санхүүжилт хугацаандаа саадгүй хийгддэг болсон зэрэг эерэг үр дүнгүүдийг дурьддаг. Гэвч бодит байдалд нутгийн өөрөө удирдах байгууллагын болон нутгийн захиргааны байгууллагын төсвийн эрх, хэмжээг бууруулж төрд төвлөрүүлсэн, төвлөрлийг өмнөхөөсөө илүү гааруулсан гэж нутгийн захиргааны албан хаагчид, ИТХ-ын төлөөлөгчид үздэг.

**0205****Хотын ядуурлын туршилтын төсөл****Urban Poverty Pilot Project**

*НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, төсөл, 2006 оны 1-р сар, Улаанбаатар, Англи, Монгол*

<http://www.undp.mn>.

НҮБХХ-өөс санхүүжүүлж 2004 оноос эхлэн Улаанбаатар хотын дүүргүүдийн таван хороонд хэрэгжиж эхэлсэн төсөл. Төслийн зорилго нь хорооны иргэд хамтран ажиллаж, хамтран суралцсаны үндсэн дээр хороогоо хөгжүүлж, ахуй амьдралаа сайжруулах санаачлагыг дэмжихэд чиглэгдэнэ.

Төслийн хүрээнд олгогдох тусламжийн мөнгийг хорооны Иргэдийн Нийтийн Хурал, өөртөө туслах бүлгээр хэлэлцэгдсэн төслүүдэд олгодог. Нэг хороонд олгогдох тусламжийн хэмжээ 10,000 доллар юм. Төсөлд хамаарагдсан хороодод нийт 20 өөртөө туслах бүлэг байгуулагдсан. Нийгмийн Хөгжлийн Төв ТББ эдгээр бүлгүүдэд Бүлгийн хөгжил, Нөөцийн удирдлага, Бичил хадгаламж, Төслийн удирдлага зэрэг сэдвүүдээр сургалт явуулж чадавхижуулсан байна. Энэхүү төсөл нь 2006 оноос НҮБХХ-ийн дэмжлэгээр эхэлж буй “Оролцоо бүхий хотын засаглалыг бэхжүүлэх” хөтөлбөрийн эхлэл байсан.

**0206****“Ходоо худалдаа” борлуулалтын сүлжээ**

*Техникийн туслалцааны төслийн санал, 1998, Улаанбаатар, 34 хуудас, Монгол, Англи*

Уг төслийн эрхэм зорилго нь бараа үйлчилгээ хүргэх болон түүхий эд бэлтгэн нийлүүлэх улсыг хамарсан борлуулалтын сүлжээ байгуулах замаар хөдөөгийн оршин суугчдыг зах зээлд ойртуулах явдал юм.

Хөдөөд бараа үйлчилгээг хямд хүргэх, бараа үйлчилгээг найдвартай тогтмол хүргэх, түүхий эд бэлтгэлийг зохион байгуулж үндэсний үйлдвэрлэгчдийг түүхий эдээр хангах, мал аж ахуйн бус орлогын эх үүсвэрийг өргөтгөж бэлэн мөнгөний хомсдолыг багасгах, бүс нутаг хоорондын худалдаа арилжааг идэвхижүүлэх хэрэгцээ шаардлагад

тулгуурлан хэрэгжүүлсэн байна. Энэ төслийг хэрэгжүүлснээр хөдөөгийн сумын аж ахуй эрхлэгчид, 120.000 малчин өрхийн 600.000 орчим иргэн, үндэсний мал аж ахуйн түүхий эд борлуулагчид, орон нутгийн засаг захиргаа, шуудан холбоо, эмнэлэг, сургууль, нийгмийн эмзэг бүлэг, гадаад худалдааны компаниуд зэрэг өргөн хүрээг хамарчээ.

## 0210 ТӨСЛИЙН ТАЙЛАН, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

### 0211

#### **Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн чадавхийг бий болгох нь Capacity Building for Integrated Regional Development Planning**

*Азийн Хөгжлийн Банк, ТА MON35396 Техникийн туслалцааны төслийн тайлан, 2002, Улаанбаатар, Англи*

[http://www.adb.org/Documents/tars/mon/tar\\_mon\\_35396.pdf](http://www.adb.org/Documents/tars/mon/tar_mon_35396.pdf)

УИХ-ын 2001 оны 57-р тогтоолоор Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн стратеги батлагдсан. 2001 онд Монгол Улсын Засгийн газраас Бүсчилсэн хөгжлийн бодлого, стратеги, хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Азийн Хөгжлийн Банкинд хүсэлт гаргасны дагуу уг төсөл хэрэгжсэн. АХБ-наас уг хүсэлтийг хүлээн авч 12 сарын хугацаанд хэрэгжүүлэхээр 1 сая долларын техникийн туслалцаа үзүүлсэн. Техникийн туслалцааны зорилго нь бүс нутгийн хөгжлийг тэнцвэржүүлэх бодлогыг дэмжих, уг асуудлаар Засгийн газрын бодлогын шинжилгээ хийх, хөгжлийн системчлэгдсэн төлөвлөлт хийх зэрэг чадавхийг нэмэгдүүлэхэд оршиж байв.

Уг төслийн хүрээнд дараах 4 гол бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Бүсчилсэн хөгжлийн стратегийн эдийн засгийн болон бодлогын үндэслэгээг шинжилсэн. Монгол орны эдийн засаг, газар зүйн онцлог бүхий нөхцөл байдалд бүсчилсэн хөгжлийн стратеги хэрхэн нийцэх талаар судалгаа шинжилгээ хийжээ. Энэ хүрээндээ эдийн засгийн одоогийн бодлого, стратеги, төлөвлөгөөний харилцан хамаарлын шинжилгээг явуулж, бүсчилсэн хөгжилд нөлөөлж болох сөрөг болон эерэг хүчин зүйлүүдийг тодорхойлсон.
2. Засгийн газрын харъяа байгууллагуудын албан хаагчдыг бүсчилсэн хөгжлийн асуудлаар бодлогын зөвлөгөө өгөх түвшинд сургаж бэлтгэсэн. Нийт 20 хүнийг гадаадад сургалтанд хамруулсан байна.

3. Бүсчилсэн хөгжлийн дунд хугацааны нэгдсэн төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх стратеги, үйл ажиллагааны удирдамжийг боловсруулахад Засгийн газарт техникийн туслалцаа үзүүлсэн.
4. Бүсчилсэн хөгжил дэхь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, бодлого тодорхойлоход сонирхогч талуудыг оролцуулах зорилгоор Засгийн газар, орон нутгийн захиргаа, иргэд, төрийн бус байгууллагуудын хамтарсан дөрвөн семинар, уулзалтыг зохион байгуулсан.

## 0212

### **“Монгол дахь нутгийн иргэдийн хөгжлийн төв” төслийн үнэлгээний эцсийн тайлан**

*Жон Логсен, Чи Жиун, төслийн тайлан, ЮНЕСКО Ази Номхон далайн бүсийн хөгжлийн төв, 2002, Улаанбаатар, 52 хуудас, Монгол*

Тайлангийн зорилго нь Монголын Нутгийн Иргэдийн Хөгжлийн Төв (НИХТ) төслийн өнгөрсөн ба өнөөгийн үр нөлөөг авч үзэхээс гадна бусад хүрээг хамарсан юм. ЮНЕСКО энэхүү тайланг Монголын НИХТ төслийн цаашдын хөгжил дэвшилд тодорхой зөвөлгөө болгох нөгөө талаас олон улсын болон үндэсний төрийн, төрийн бус байгууллагуудад мэдээлэл, лавлагааны материал олгох зорилгоор гаргажээ.

Төрөөс явуулж буй нийгмийн чиглэлийн хөтөлбөр үйл ажиллагаа нь сум, багийн түвшинд төдийлөн хүрч очихгүй байгаа, эсвэл чанар, хүртээмжийн хувьд иргэдийн хүсэл шаардлагад нийцэхгүй байх явдал ажиглагддаг. Өнөөгийн сулхан боловсролын системийн сөрөг нөлөө нь голчлон албан болон албан бус боловсролд хамрагдах боломж хязгаарлагдмал хөдөө нутгийг ханд (сум, багийн иргэдэд) хүндхэн тусч байна.

Тайланд Монголд хэрэгжүүлснээр орон нутгийн иргэдийн оролцоо тодорхой хэмжээнд нэмэгдсэн. Боловсон хүчиний чадавхи орон нутгийн хэмжээнд дээшилсэн, төрийн болон төрийн бус байгууллага ба иргэд хоорондын холбоо сайжирсан зэрэг үр дүн гарсаныг дурьджээ.

**0213****Монгол Улстай хамтран ажиллах анхны үйл ажиллагааны хүрээ**

*НҮБХХ-ийн Гүйцэтгэх Зөвлөл, НҮБ-ын Хүн Амын Сан, хамтын ажиллагааны бодлогын баримт бичиг, 1997, Нью-Йорк, Англи [http://mirror.undp.org/mongolia/publications/UNDP\\_CCF1997-2001.pdf](http://mirror.undp.org/mongolia/publications/UNDP_CCF1997-2001.pdf)*

НҮБХХ-ийн Гүйцэтгэх Зөвлөл, НҮБ-ын Хүн Амын Сангаас санаачлан мэргэжлийн зөвлөхүүдийн үнэлгээ, дүгнэлт болон Засгийн газар, иргэний нийгмийн төлөөлөлтэй хамтарсан хэлэлцүүлэгт үндэслэн уг баримт бичгийг боловсруулсан.

Баримт бичигт өмнөх харилцаанаас авсан сургамж, 1997-2001 онд хэрэгжих хөтөлбөрийн хамрах хүрээ, зорилго, хүлээгдэж буй үр дүн, зэрэг асуудлуудыг тусгажээ. Хамтын ажиллагааны баримт бичигт тусгагдсан нэг гол асуудал бол удирдлагын хөгжил ба засаглалын хөтөлбөр юм.

Энэ хүрээнд төвлөрөх гол асуудлуудад төвийн ба орон нутгийн засаглалын хууль эрх зүйн орчин, бусад донор байгууллага болон хамаатай талуудтай хамтран үр ашиг бүхий нутгийн удирдлагыг дэмжих, төвлөрлийг сааруулах бодлого боловсруулах, нутгийн удирдлагыг чадавхижуулах, төрийн захиргааны шинэчлэлийг дэмжих, бүтцийн өөрчлөлтийг түргэтгэх зэрэг багтсан байна.

*Тухайн цед төвлөрлийг сааруулах, нутгийн захиргааг бэхжүүлэх бодлогыг дэмжиж байсан гол донорын нэг нь НҮБХХ юм.*

**0214****Монгол Улстай хамтран ажиллах хоёр дахь удаагийн үйл ажиллагааны хүрээ**

*НҮБХХ-ийн Гүйцэтгэх Зөвлөл, НҮБ-ын Хүн Амын Сан, хамтын ажиллагааны бодлогын баримт бичиг, 2001, Нью-Йорк, Англи <http://mirror.undp.org/mongolia/publications/ccf2002-2006.pdf>*

НҮБХХ-ийн Гүйцэтгэх Зөвлөл, НҮБ-ын Хүн Амын Сангаас санаачлан Засгийн газар, иргэний нийгмийн төлөөлөлтэй хамтран хэлэлцэж боловсруулсан энэхүү баримт бичигт өмнөх харилцаанаас авсан сургамж, 2002-2006 онд хэрэгжих хөтөлбөрийн хамрах хүрээ, зорилго, хүлээгдэж буй үр дүн, зэрэг асуудлуудыг тусгажээ.



НҮБХХ-ийн зорилго бол Монгол Улсын тэнцвэртэй, тогтвортой хөгжлийг дэмжих явдал юм. 2002-2006 оны үйл ажиллагааны үндсэн хүрээг нийгмийн наад захын үйлчилгээг сайжруулах, сайн тэнцвэртэй эдийн засгийг хөгжүүлэх, засаглалыг дэмжих, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, үндэсний гамшигийн удирдлагыг чадавхижуулах гэсэн үндсэн таван хүрээнд тодорхойлжээ.

Ардчилсан засаглалыг бэхжүүлэх нь НҮБХХ-ийн хамгийн гол асуудлын нэг бөгөөд энэ хүрээнд төрийн бодлолын хөгжил, хууль, эрх зүйн ба институцийн хөгжил гэсэн хоёр хүрээнд хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэхээр болсон. Аливаа хөгжлийн бодлогыг тодорхойлоход олон нийт, иргэд, иргэний нийгэм, хувийн хэвшлийг өргөнөөр оролцуулж байх асуудлаар арван хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Түүнчлэн хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглалыг дэмжих зорилго бүхий арван нэгэн хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

*Нутгийн удирдлага, төвлөрлийг сааруулах асуудлаар тухайлсан хөтөлбөр, үйл ажиллагааны хүрээг тодорхойлоогүй ба засаглалыг дэмжих асуудлыг хүний аюулгүй байдал, эрх чөлөөг хангах асуудалтай холбон авч үзсэн байна.*

## 0215

### **Төрийн зарлагын менежмент**

#### **Public Expenditure Management**

*Азийн Хөгжлийн Банк, ТА 3317-MON Техникийн туслалцааны төслийн тайлан, 2003, Улаанбаатар, Англи*

<http://www.adb.org/Publications/country.asp?id=50&s=0&wp=6>

Азийн Хөгжлийн Банкнаас төрийн захиргааны шинэчлэлийг дэмжих техникийн туслалцааны хүрээнд Монгол Улс төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн шинэ системд шилжин орсонтой холбоотойгоор санхүү, эдийн засгийн яамны чадавхийг бэхжүүлэх зорилгоор энэ төсөл 2002-2003 онуудад хэрэгжсэн. Төслийн нийт өртөг 496,000 ам доллар.

Төслийн гол зорилго нь Санхүү, Эдийн Засгийн Яамны гарцад суурилсан төсвийн төлөвлөлт, дунд хугацааны төлөвлөлтийн чадавхи ба секторийн төсвийн төлөвлөлтийн чадавхийг нэмэгдүүлэхэд оршиж байв.

Төслийн хүрээнд Санхүү, Эдийн Засгийн Яам, Хууль Зүй Дотоод Хэргийн Яам, Гадаад Харилцааны Яам, агентлагийн ажиллагчдыг төрийн хөрөнгө оруулалтын

төлөвлөгөө, дунд хугацааны төлөвлөлт зохиох арга зүйн асуудлаар сургаж хэд хэдэн семинар, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулжээ. Сургалт, семинар, зөвлөгөө өгөх ажлыг Азийн Хөгжлийн Банкны болон дотоодын зөвлөхүүд хамтран зохион байгуулсан. Техникийн туслалцааны хүрээнд Засгийн газрын 18 төрийн албан хаагчид Шинэ Зеланд, Малайз зэрэг улсуудад туршлага судлах богино хугацааны семинарт хамрагдсан.

*Төслийн үр дүнд Засгийн газрын гурван (2002-2004) жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж, 2003-2005 онуудын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний стратеги, үндсэн чиглэлийг тодорхойлсон.*

## **0216**

### **Улс орныг дэмжих хөтөлбөрийн үнэлгээ**

#### **Country assistance program evaluation, Mongolia, 2002**

*Азийн Хөгжлийн Банк, MON 2002-12 Хөтөлбөрийн үнэлгээний тайлан, 2002, Улаанбаатар, Англи, Монгол*

<http://www.adb.org/Documents/PERs/cape-MON.pdf>

АХБ 1991 оноос Монгол Улсад үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 2001 он хүртэл нийт 505 сая долларын өртөг бүхий 25 төслийг хөдөө аж ахуй, эрчим хүч, санхүүгийн зах зээл, үйлдвэрлэл, харилцаа холбоо, тээвэр ба хот төлөвлөлтийн салбарт хэрэгжүүлээд байна. Үүнээс гадна 49 сая долларын техникийн туслалцааг Төрийн захиргааны шинэчлэлийн хөтөлбөрийг дэмжихэд зарцуулжээ. Энэ үнэлгээний тайлангийн зорилго нь өнгөрсөн арван жилийн хугацаанд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд нь бодит хэрэгцээ, шаардлагатай асуудлуудыг сонгож чадсан эсэх, төслийн төлөвлөлт, хэрэгжилт үр ашигтай явагдаж чадсан эсэхийг үнэлэхэд оршино. Мөн дээрх төслүүд нь Монголын эдийн засаг, нийгмийн шилжилтийн үйл явцад хэрхэн тус дөхөм болсоныг үнэлэх зорилготой.

Үнэлгээ нь АХБ-ны албан ёсны тайлан, баримт бичгүүдэд шинжилгээ хийх, Монголын талын түншүүдтэй хийсэн ярилцлага, тодорхой жишээг сонгон авч, анализ хийх зэрэг аргачлалд үндэслэн хийгдсэн. АХБ-наас үзүүлж буй засаглалыг сайжруулах техникийн туслалцаа нь бусад секторынхоос хамгийн их буюу нийт техникийн туслалцааны сангийн 26.4%-ийг эзлэж байна. Дараа нь хөдөө аж, ахуйн салбарт 14.3%, санхүүгийн зах зээлд 14% байна.

Үнэлгээний тайланд засаглалыг сайжруулах, хүрээлэн байгаа орчны асуудал ба ядуурал зэргийг хамгийн тулгамдсан асуудал гэж үзэн зөв сонгож, төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн болохыг дурьджээ.

АХБ өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Засгийн газартай хамтран ажилласан байдал, Монголын нийгэм, эдийн засгийн шилжилтийн үйл явцаас олж хуримтлуулсан туршлага, чадавхидаа үнэлэлт дүгнэлт өгөн цаашид баримтлах стратеги чиглэлээ томъёолжээ.

Цаашид засаглалын салбартай холбоотойгоор нийтийн салбарын менежментийг цогц байдлаар ойлгож, санхүүгийн сахилга бат ба мэргэжлийн чадавхийг дээшлүүлэхэд анхаарна гэжээ. Энэ хүрээнд гол асуудлууд дээр Засгийн газар ба орон нутаг зөвшилцөх, төрийн үйлчилгээний төрөл, хэрэглээний хэмжээг ард иргэд, иргэний нийгэмтэй зөвшилцөн тодорхойлох, төрийн нөөцийн менежментийн загварыг тодорхойлох, хамгийн үр ашигтайгаар үйлчилгээ үзүүлэх механизм бүрдүүлэх, үүнд хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг стратегийн асуудлууд чухал хэмээн дурьджээ.

## **0230 ОЛОН УЛСЫН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД**

### **0231**

#### **Конрад Аденауэрын Сан**

##### *Төрийн бус байгууллага*

1993 онд энэ сан өөрийн төлөөлөгчийн газраа Монголд байгуулсан. Сангийн үйл ажиллагаа нь Монголын ардчилалд дэмжлэг үзүүлэх, сонгогчдын боловсролыг сайжруулах, парламент ёсыг дэмжих, олон намын системийг хөгжүүлэх зэрэгт чиглэгддэг. Сан нь зургаан аймаг дахь салбараараа дамжуулан иргэдэд улс төрийн боловсрол олгох төслийг 1996 оноос хойш хэрэгжүүлж байна.

1996 оноос эхлэн сан нутгийн өөрөө удирдах ёсны хөгжлийн асуудалд анхаарал хандуулсан бөгөөд Өмнөговь, Өвөрхангай, Сэлэнгэ болон Төв аймгуудын ихэнх сумдын ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулан цөөнгүй сургалт явуулсан. Сургалтын гол сэдэв нь нутгийн удирдлага, нутгийн өөрөө удирдах ёс, эдгээрт хамаарах олон улсын туршлага зэрэг байсан. (Голчлон Германы туршлагад анхаарал хандуулсан).

Одоогоор бүх аймгийн, ихэнх сумдын нийтдээ 5,000 гаруй ИТХ-ын төлөөлөгч, нутгийн захиргааны албан хаагчдыг ардчилсан засаглал, нутгийн өөрөө удирдах ёсны чиглэлээр сургалтанд хамруулаад байна. Сургалтаас гадна Сан нутгийн өөрөө удирдах ёсны талаарх ном, бүтээлийг хэвлэх, МНУХ-ны санаачилгаар “Нутгийн өөрөө удирдах ёсны тунхаглал”-ыг боловсруулахад мэргэжлийн туслалцаа үзүүлж, нутгийн удирдлагатай холбогдох хуулийн төсөл боловсруулах ажлыг дэмжээд байна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газарт зохих техникийн туслалцаа үзүүлэх ажлуудыг хийж байна.

## **0232**

### **Монголын Нутгийн Удирдлагын Холбоо**

#### *Төрийн бус байгууллага*

МНУХ нь эгнээндээ Монголын бүх аймаг, сум, нийслэл, дүүргийг багтаасан гишүүнчлэл бүхий төрийн бус байгууллага. Монголын нутгийн удирдлагын хөгжилд хувь нэмэр оруулах, нутгийн өөрөө удирдах байгууллагуудын ашиг, сонирхолыг хамгаалах, шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх, нутгийн удирдлагад ажиллаж буй хүмүүсийг сургах, хөгжүүлэх зорилго бүхий байгууллага юм. МНУХ-ноос улирал тутам “Нутгийн удирдлага” сэтгүүл гаргадаг ба сэтгүүлд орон нутгийн эдийн засаг, нийгмийн амьдрал, нутгийн удирдлагын онол, практикийн асуудлуудыг нийтэлдэг.

МНУХ нь олон улсын донор байгууллагуудтай хамтран гишүүдийн болон олон нийтийн дунд төслүүд хэрэгжүүлж, сэтгүүл нийтлэх, үндэсний болон бүсийн семинар зохион байгуулах, сургалт явуулах зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Тус төрийн бус байгууллага нь гишүүд, нийгэмтэйгээ идэвхитэй ажилладаг боловч Засгийн газар, УИХ-тай хамтран ажиллах, бодлогод нөлөөлөх чадвар сул байна.

Тус холбооноос санаачлан Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, нутгийн өөрөө удирдах ёсны тунхаг бичиг боловсруулан батлах зэрэг ажлуудыг хийж байсан.

**0233****Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр**

*Олон улсын байгууллага*

Монголд НҮБХХ нь 1990-ээд оны дунд үеэс эхлэн төрийн удирдлагын төвлөрлийг сааруулах үйл ажиллагааг идэвхитэй дэмжиж ажиллаж ирсэн. 2006 онд 3 үндсэн чиглэлийн хамтын ажиллагааг тодорхойлоод байна. Үүнд: Ардчилсан засаглал, эдийн засгийн шилжилт болон ядуурлыг бууруулах, тогтвортой орчны удирдлага зэрэг багтана. НҮБХХ-ийн Сайн Засаглал хөтөлбөрийн хүрээнд 1994-1998 онуудад “Ардчилал болон төвлөрлийг сааруулалт” гэсэн төсөл хэрэгжүүлсэн. Гол зорилго нь нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлж, төвлөрлийг сааруулах замаар сайн засаглалд хүрэхэд оршиж байв.

Монголд уг хөтөлбөрийн хүрээнд туршилтын зургаан аймагт мэдээллийн төв байгуулж, Шведийн Олон Улсын Хөгжлийн Агентлагтай хамтран орон нутгийн улс төрчид болон албан хаагчдад сургалт зохион байгуулсан.

**0234****Нээлтэй Нийгэм Форум (Хуучинаар Монголын Нээлтэй Нийгэм Хүрээлэн)**

*Төрийн бус байгууллага*

Тус байгууллага нь Монголын Нээлтэй Нийгэм Хүрээлэн гэж байх үеэсээ Монголд ардчилалыг бэхжүүлэх зорилгын хүрээнд төв болон орон нутгийн удирдлагыг илүү нээлтэй, ил тод, хариуцлагатай болгох, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр нилээд ажлыг дэмжиж ирсэн. Тухайлбал, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, иргэний нийгмийн байгууллага, нутгийн удирдлагын болон төрийн бус байгууллагуудаас дэвшүүлсэн төсөл сонгож, санхүүжүүлж байв. (5.000 ам доллар хүртэл).

Энэ хөтөлбөр нь 2001 онд нийт 40000 ам долларын жижиг төслүүдийг санхүүжүүлсэн бөгөөд 2002 онд 11 төслийг 52000 гаруй ам доллараар санхүүжүүлжээ. Эдгээр дэмжсэн төслүүд нь нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлэх, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын чадавхийг нэмэгдүүлэх, илүү нээлтэй, ил тод, үр ашигтай

ажиллах, мэдээллээр хангах болон шийдвэр гаргалтанд иргэдийг оролцуулах зэрэг асуудлуудад чиглэгдэж байсан.

Нээлттэй Нийгэм Форум нь дараах ажлуудыг дэмжиж байна. Үүнд:

- Ардчилалыг бэхжүүлэх хүрээнд судлаач, ТББ, удирдлага болон хөрөнгө оруулагчдын хамтын ажиллагааг дэмжих, уулзалтыг зохион байгуулах
- Нийгэм, эдийн засгийн сэдвээр үндэсний телевизээр олон нийтийн хэлэлцүүлэг явуулахыг дэмжих. Тухайлбал, ИТХ-ын байгууллагын үүрэг роль, нутгийн удирдлагын чиглэлээр хоёр хэлэлцүүлэг зохион байгуулсан
- Нээлттэй Нийгэм Форум нь орон нутгийн удирдлагатай илүү нягт хамтран ажиллах боломжийг эрэлхийлж байгаа бөгөөд энэ чиглэлээр тэтгэлэгт хөтөлбөр, бодлогын судалгааг дэмжиж байна.

## 0235

### **Орон Нутгийн Удирдлагын Хөгжил Сан**

*Төрийн бус байгууллага*

ОНУХС нь хувийн хэвшлийн байгууллага, төрийн болон нутгийн удирдлагын байгууллага хоорондын хамтын ажиллагааны чадавхийг нэмэгдүүлж, тэрхүү чадавхийг орон нутгийн хөгжлийг түргэтгэхэд чиглүүлэх зорилго бүхий үйл ажиллагааг явуулдаг төрийн бус байгууллага юм. Төрийн ба нутгийн удирдлага, эдийн засаг, менежментийн чиглэлээр сургалт явуулж, жижиг төслүүд хэрэгжүүлдэг. Мөн аливаа байгууллагын менежер болон удирдах ажилтнуудад зориулан менежментийн холбогдолтой орчин үеийн ном зохиол хэвлэх, орчуулах үйл ажиллагааг эрхэлж байна.

Монгол Шведын Засгийн газар хоорондын “Монгол Улсад нутгийн өөрөө удирдах ёсны чадавхийг дээшлүүлэх” төслийн хүрээнд ОНУХС нь “Орон нутгийн улс төрчдийн ёс зүй” сэдэвт судалгааны ажил хийж гүйцэтгэсэн байна. Хэдийгээр, ОНУХС нь байгуулагдсан цагаасаа эхлэн нутгийн удирдлагын чиглэлийн судалгаа, сургалтын туршлага хуримтлуулсан байгууллага хэдий ч санхүүгийн гачигдлаас болж үйл ажиллагаа нь хязгаарлагдмал байна.

### **3. НОМ, ТОВХИМОЛ, ГАРЫН АВЛАГА, СЭТГҮҮЛ**

## **0300 ГАРЫН АВЛАГА, СЭТГҮҮЛ**

### **0301**

#### **Багшийн гарын авлага**

*“Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь-I” (1997-1999 ) төслийн баг, гарын авлага, 1999, Улаанбаатар, 115 хуудас, Монгол*

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг Эрхлэх газар, Шведийн Олон Улсын Хөгжлийн Агентлаг, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс санхүүжүүлж хэрэгжүүлсэн “Монгол Улсад нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд энэ гарын авлага боловсруулагдсан. Энэ гарын авлага нь сонсогчийн гарын авлагыг удирдлага болгож, сургалт явуулах сургагчдад зориулж хэвлэгдсэн.

Гарын авлага нь Орон нутгийн сургагчийн нутгийн өөрөө удирдах ёс, Хууль эрх зүйн хүрээ, Нутгийн хурлын дотоод ажил, зохион байгуулалт, Орон нутгийн санхүү, түүний удирдлага, Төрийн ардчилсан удирдлага, иргэдийн оролцоо, Төрийн үйлчилгээ түүнийг хүргэх нь, Төрийн захиргааны удирдлага, Бизнесийн стратеги төлөвлөлт зэрэг сэдвүүдээр сургалт явуулах үйл ажиллагааг хөнгөвчлөх, дэмжих зорилготой.

*Сэдэв тус бүрээр сургагч багшид зориулсан хичээлийн төлөвлөгөө, хичээл явуулах аргачлал, ашиглах үзүүлэн материал, дасгал ажлын санал болгож буй хариулт гэсэн бүрдэл хэсгүүдийг боловсруулсан байна.*

### **0302**

#### **Байгаль орчныг хамгаалах олон нийтийн үүрэг**

*“Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь-II” (2001-2004) төслийн баг, гарын авлага, 2005, Улаанбаатар, “Адмон” ХХК-д хэвлэв, 56 хуудас, Монгол*

Гарын авлага нь “Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхийг бэхжүүлэх нь II” (2001-2004) төслийн орон нутгийн хурлын сонгуульд төлөөлөгч, төрийн захиргааны албан хаагчдыг сургах бүрэлдэхүүн хэсгийн үр дүнд бий болсон. Сургалтын зориулалтаар хэвлэгдсэн гарын авлага ба агуулгадаа Хүрээлэн буй



орчны тухай ойлголт, Байгаль хамгаалах түүхэн уламжлал, Байгаль хамгаалах эрх зүй, төрийн бодлого, холбогдох стандартууд, тэдгээрийн хэрэгжилт, Байгаль хамгаалалхад олон нийтийн оролцоо, Хог хаягдлын менежмент зэрэг сэдвүүдийг багтаасан.

*Сэдэв тус бүрээр оролцогчдод унших материал, хамтран ажиллах дасгал ажил, дадлагын ажил зэргийг боловсруулжээ.*

### **0303**

#### **Иргэн ба хууль зүй**

*“Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь-II” (2001-2004) төслийн баг, сургалтын гарын авлага, 2005, Улаанбаатар, “Адмон” хэвлэлийн газарт хэвлэв, 141 хуудас, Монгол*

Швед-Монголын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд 2001-2004 онд хэрэгжсэн уг төслийн орон нутгийн Хурлын төлөөлөгчид, нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдыг сургах, хөгжүүлэх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд энэхүү гарын авлага боловсруулагдсан.

Гарын авлагад нутгийн өөрөө удирдах ёсны Үндсэн хуулийн үзэл баримтлал, эрх зүйн зохицуулалт, Бүсчилсэн хөгжил, түүний эрх зүйн үндэс, Бүсийн тулгуур төв, хотуудын тухай, Газрын эрх зүйн шинэтгэл ба нутгийн өөрөө удирдах ёс, Захиргааны хэргийн шүүх ба нутгийн удирдлагын байгууллагууд гэсэн сэдвүүдийг хамарчээ.

*Нутгийн удирдлагын байгууллагад ажиллаж буй сонгуультаан, албан хаагчдад шинэ мэдлэг, мэдээлэл өгөх, бие даан суралцах боломжоор хангахад тустай гарын авлага болсон.*

### **0304**

#### **Иргэдийг төлөөлөхүй, Шведийн ардчилсан засаглал**

*Гуннар Андерссон, гарын авлага, 2003, Улаанбаатар, 40 хуудас, Монгол, Англи*

Зохиогч Шведийн ардчилал, түүний хөгжил, нутгийн удирдлагын тотголцоо, нутгийн өөрөө удирдах ёс түүний түүхэн тойм, орон нутгийн санхүү, төсөв, удирдлагын ил, тод байдал, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, коммуны үзүүлэх үйлчилгээ,

түүний зохион байгуулалт, Шведын коммунуудын эрх ашгийг хамгаалах зэрэг олон асуудлуудыг практик талаас нь авч үзжээ.

*Энэхүү гарын авлага нь нутгийн удирдлагын байгууллагын сонгуультаан, албан хаагчид, эрдэмтэн, судлаачдад Шведийн нутгийн удирдлага, нутгийн өөрөө удирдах ёсны тухай мэдлэг, мэдээлэл олж авахад нь тус, дөхөм болохуйц бүтээл болжээ.*

### **0305**

#### **Монгол Улсын нутгийн өөрөө удирдах ёсны тунхаг бичиг**

*Монголын Нутгийн удирдлагын холбоо, гарын авлага, 2001, Улаанбаатар*

Торонто хотноо 1993 онд хуралдсан Нутаг Дэвсгэрийн Нэгжийн олон улсын Холбооны 31-р бага хурлаас батлан гаргасан “Нутгийн өөрөө удирдах ёсны олон улсын тунхаг”-ийн үзэл санааг дэмжиж Монгол Улсад “Нутгийн өөрөө удирдах ёс”-ыг бэхжүүлэх ардчилсан төрийн тогтолцоог боловсронгуй болгох, иргэний нийгэм бүрэлдэн тогтох явцыг эрчимжүүлэх зорилгоор Монголын нутгийн удирдлагын холбооны 2001 онд болсон II их хурлаас энэхүү тунхагийг гаргажээ.

Энэхүү тунхаг бичиг Улаанбаатарын гэгддэг ба тунхагт Нутгийн өөрөө удирдах ёсны эрх зүйн баталгаа, нутаг дэвсгэрийн нэгжийн бүрэн эрхийг хангах, төр ба нутаг дэвсгэрийн нэгж хоорондын чиг үүргийг хуваарилах, нутгийн удирдлагын зохион байгуулалтын зохимжтой хэлбэр, нутаг дэвсгэрийн нэгжийн төсөв, санхүүгийн бие даасан байдлыг хангах, нутаг дэвсгэрийн нэгжийн сонирхол, эрх ашгийг сахин хамгаалахтай холбоотой зарчмын үндсүүдийг тусгаж өгсөн. Энэхүү баримт бичгийн зарчим, үзэл санаа нь орчин үед дэлхий нийтээр нутгийн өөрөө удирдах ёсонд баримталж буй зарчим, бодлоготой нийцэж байгаа юм.

### **0306**

#### **“Монгол Улсад Нутгийн Өөрөө Удирдлагын Чадавхийг дээшлүүлэх нь”, сургалтын гарын авлага**

*“Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь-II” (2001-2004) төслийн баг, гарын авлага, 2003, Улаанбаатар, 198 хуудас, Монгол*

“Монгол Улсын төвлөрлийг сааруулах, нутгийн өөрөө удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь II” төслийн сургалтын гарын авлага нь орон нутгийн ЗДТГ-ын албан хаагчид, ИТХ-ын төлөөлөгчдийн нутгийн өөрөө удирдах ёсны тухай мэдлэгийг нэмэгдүүлж, түүнийг өөрийн ажил амьдралдаа хэрэгжүүлэх, бусдадаа зааж сургах санаачлагыг дэмжих зорилготой.

Нутгийн өөрөө удирдах ёс, хууль эрх зүйн хүрээ, Нутгийн хурлын дотоод ажил, зохион байгуулалт, Орон нутгийн санхүү, түүний удирдлага, Төрийн ардчилсан удирдлага, иргэдийн оролцоо, Төрийн үйлчилгээ түүнийг хүргэх, Төрийн захиргааны удирдлага, Бизнесийн стратеги төлөвлөлт зэрэг сэдвүүдийг хамарсан болно. Сургалтын гарын авлагад сэдэв тус бүрээр оролцогчдод зориулсан унших материал, танхимд хамтран хэлэлцэх, ажиллах дасгал, тэдгээрийн удирдамж, гэрийн даалгавар буюу дадлагын ажлын зааварчлага зэргийг багтааж уншиж, хэрэглэхэд хялбар байдлаар боловсруулсан.

Уг гарын авлагыг ашиглан орон нутгийн 3000 гаруй төрийн албан хаагч, ИТХ-ын төлөөлөгчдийг сургасан байна. Энэ сургалтаар дамжуулан НӨУЁ-ыг Монгол Улсад цаашид төлөвшүүлэхэд үнэтэй хувь нэмэр болсон гэж үздэг.

### **0307**

#### **Нутгийн Өөрөө Удирдах ёс /НӨУЁ/**

*Я.Долгоржав, гарын авлага, 2000, Улаанбаатар, 54 хуудас, Монгол*

Нутгийн өөрөө удирдах ёсны хөгжлийн туршлага, ач холбогдол, цаашдын хандлага, түүнд тавигдах шаардлага зэрэг асуудлыг тодорхойлоход энэ гарын авлагын үндсэн зорилго оршино. Номд нутгийн өөрөө удирдах ёсны Европын Хартийн тухай хуулийг монгол хэлээр орчуулан нийтийн хүртээл болгосон байна.

Монголын нутгийн өөрөө удирдах байгууллагын хөгжилд зарим ахиц гарч байгаа ч цаашид хийх ажил түүнээс хавьгүй их байгааг зохиогч дурьджээ. Нутгийн удирдлагад хамгийн хүндрэлтэй зүйл нь манай ихэнх засаг захиргааны нэгжүүд нь төсөв, хөрөнгийн хомсдолтой байгаа явдал юм. Энэ нь төрөөс нэг хэсэгтээ харьцангуй төсвийн орлого ихтэй засаг захиргааны нэгжээс орлогын тодорхой хэсгийг төсвийн хомсдолтой, алслагдмал, орлого бага орон нутгуудад шилжүүлэх “Тоорой Банди”-ийн үүргээ гүйцэтгэхийг шаардсаар байна.

Энэ бүтээлд нутгийн өөрөө удирдах ёсны түүхэн хөгжил, манай орны өнөөгийн байдлыг авч үзсэн ба Европын Харти, болон бусад нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлсэн баримт бичгийн талаар ойлголт өгч байгаагаараа ач тустай бүтээл юм.

### **0308**

#### **Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь**

*Ховд аймгийн ИТХ, Ховд Их Сургуулиас Баруун бүсийн онол практикийн бага хурлын илтгэлцүдийг эмхэтгэн гаргасан эмхтгэл, 2006, Улаанбаатар, Соёмбо хэвлэлийн газар, 362 хуудас, Монгол*

Уг номонд нэгдсэн хуралдааны илтгэлүүдээс гадна дөрвөн салбар хуралдааны 55 илтгэл багтсан. Нутгийн өөрөө удирдах байгууллагын /НӨУБ/ өнөөгийн үйл ажиллагаа, өдөр тутмын үйл ажиллагаанд учирч буй бэрхшээл, ололттой талууд, салбар бүрт НӨУБ-ын оролцоо ямар байх талаар аймаг сумын ИТХ-ын төлөөлөгч, бусад ажилтнуудын санал дүгнэлтүүд илтгэлд багтсан байна.

Өнөө үед НӨУБ-уудад Үндсэн хууль бусад хуулиар олгогдсон орон нутгийн асуудлыг шийдэх эрх хумигдан түүнийг төрийн төв байгууллагууд төвлөрүүлэн хэрэгжүүлэх болсон. Тухайлбал төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн хуулиар орон нутаг өөрөө төсвөө хэлэлцэн батлах үйл ажиллагаа нь нэр төдий болон хувирсан, үүний улмаас НӨУБ-ын чадавхи, нэр хүнд нөлөө буурч орон нутгийн онцлогт тохирсон нутгаа хөгжүүлэх бодлого хэрэгжих нөхцөл муудсан. Эдгээр бэрхшээлүүдийг арилгах тухай санал, зөвлөмжийг хурлаас аймаг сумын ИТХ, багийн ИНХ-уудад хандаж гаргасан зөвлөмжийг багтаасан.

Аймаг сум, багийн НӨУБ-д ажиллаж байгаа хүмүүсийн санал бодол сэтгэгдлийг агуулсан ач холбогдол бүхий ном болсон байна.

### **0309**

#### **“Нутгийн удирдлага” сэтгүүл**

*Г.Маналжав, сэтгүүл, 2006, Улаанбаатар, Монгол*

Монголын Нутгийн Удирдлагын Холбооноос эрхлэн 1996 оноос эхлэн гаргадаг улирал тутмын сэтгүүл юм.. Сэтгүүл нь МНУХ-оос зохион байгуулж буй ажил,

сургалт, хурал зөвлөгөөний талаар мэдээлэл өгөх, НӨУЁ-ны тухай онол, орчин үеийн хандлага, гадаадлын туршлагын талаарх судлаачдын илтгэл, нийтлэл, хийгдэж буй ажлын танилцуулга үр дүн, аймаг сумдын ИТХ, багийн ИНХ-ын үйл ажиллагааны танилцуулга, ажлын туршлага зэрэг мэдээллийг нийтлэлийнхээ бодлого болгон ажиллаж байна.

1996 оноос хойш улиралд нэг удаа хэвлэгдэн гарч байв. 2006 оноос жилд 8 дугаар нэг удаадаа 2000 ширхэг хэвлэгдэн гарч байна. Тус сэтгүүл орон нутгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн дарга, нарийн бичгийн дарга төлөөлөгч, ажилтнууд, ЗДТГ-ын албан хаагчид өөрсдийн санал бодлоо илэрхийлэх, харилцан туршлага солилцох индэр болж байдаг.

Сэтгүүлээс орон нутгийн удирдлага, нутгийн өөрөө удирдах ёсны чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажил тогтмол хийж, нийтлэл бичдэг дараах эрдэмтэн, судлаачдын бүтээлүүдийг олж үзэх боломжтой. Үүнд:

- Б.Чимид - Доктор, профессор
- Я.Долгоржав - Доктор профессор
- С.Нармандах - Доктор
- Ж.Ядамсүрэн - судлаач
- Г.Маналжав - судлаач
- Г.Ганхуяг - судлаач
- Я.Бямбаяр - судлаач
- Б.Баттүвшин - судлаач
- Л.Лувсанжамц - судлаач

## 0310

### **Орон нутгийн санхүүгийн хөгжил**

*“Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь-II” (2001-2004) төслийн баг, сургалтын гарын авлага, 2005, Улаанбаатар, “Адмон” хэвлэлийн газарт хэвлэв, 73 хуудас, Монгол*

Орон нутгийн санхүүгийн эрх зүйн орчин, Төсвийн байгууллагын санхүүгийн бүртгэл, Төсвийн байгууллагын бүтээгдэхүүн, Орон нутгийн төсөв, Төсвийн төлөвлөлтийн аргууд, Төсвийн төсөл боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт

тавих, Орон нутгийн төсөв дэхь иргэдийн оролцоо зэрэг сэдвүүдийг гарын авлагад багтаажээ.

*Гарын авлага нь онолоос илүү аймаг, сумдын бодит практик жишээнүүд дээр үндэслэн суралцагчийн орон нутгийн санхүү, төсвийн талаарх мэдлэг, чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн.*

## **0311**

### **Сонсогчийн гарын авлага**

*“Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь-1” (1997-1999 ) төслийн баг, Гарын авлага, 1999, Улаанбаатар, 223 хуудас, Монгол*

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг Эрхлэх газар, Шведийн Олон Улсын Хөгжлийн Агентлаг, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс санхүүжүүлж хэрэгжүүлсэн “Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь-1” төслийн хүрээнд энэ гарын авлагыг боловсруулсан.

Энэ гарын авлагыг ашиглан туршилтын зургаан аймагт сургалтууд зохион байгуулагдсан ба ИТХ-ын төлөөлөгчид, хурлын ажилтнууд, ЗДТГ-ын гол албан тушаалтнууд хамрагдсан. Гарын авлагад Нутгийн өөрөө удирдах ёс, хууль эрх зүйн хүрээ, Нутгийн хурлын дотоод ажил, зохион байгуулалт, Орон нутгийн санхүү, түүний удирдлага, Төрийн ардчилсан удирдлага, иргэдийн оролцоо, Төрийн үйлчилгээ түүнийг хүргэх, Төрийн захиргааны удирдлага, Бизнесийн стратеги төлөвлөлт зэрэг сэдвүүдийг багтаасан. Гарын авлагыг төслийн мастер сургагчид болох зургаан аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Улаанбаатар хотоос бэлтгэгдсэн мэргэжлийн багш нар хамтран боловсруулжээ.

*Сэдэв тус бүрээр оролцогчдод зориулж хичээлийн төлөвлөгөө, унших материал, дасгал ажлын болон арга зүйн заавар, гэрийн даалгавар гэсэн бүрдэл хэсгүүдийг боловсруулсан байна.*

**0312****Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл, ерөнхий тайлбарын гарын авлага**

*Төрийн захиргааны шинэчлэлийн төслийн баг, гарын авлага, 2002, Улаанбаатар, “Хөх судар” хэвлэлийн газарт хэвлэв, 184 хуудас, Монгол*

Монгол Улсын Их Хурлаас ТБУСТХ-ийг (Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль) 2002 оны 6 дугаар сарын 27-ны өдөр батлан гаргасан. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн албан хаагчдыг шинэ тогтолцоонд шилжихэд бэлтгэх, сургах шаардлага гарсан. Энэ зорилгоор төрийн захиргааны шинэчлэл төслөөс хэд хэдэн цуврал гарын авлага боловсруулсан юм.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн шинэчлэлийн тухай энэхүү гарын авлагыг төрийн захиргааны шинэчлэлийн гол үзэл санаа, үндсэн агуулга, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар мэдээлэл, тайлбар өгөх зорилгоор бичсэн болно. Гарын авлагад шинэчлэлийн үзэл баримтлал, үндсэн санаа, улсын төсөв боловсруулах, батлах, зарцуулах үйл явц, төсвийн удирдлага, байгууллагад үзүүлэх нөлөө, хариуцлагын тогтолцоо, төрийн захиргааны төв байгууллагуудын шинэ тогтолцоог хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага, төрийн хяналт зэрэг өргөн хүрээтэй асуудлуудыг хамарчээ.

*Гарын авлагад орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийг шинэчлэх үндсэн гурван хувилбар болон тэдгээрээс сонгогдсон хувилбарын талаар тайлбар хийсэн байна.*

**0313****Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл, онол, тайлбар, хэрэгжилт**

*Б.Намхайжанцан, гарын авлага, 2003, Улаанбаатар, “Хөх судар принтинг” ХХК-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв 158 хуудас, Монгол*

Энэхүү гарын авлага нь төрийн захиргааны шинэчлэлийн гол үзэл санаа, үндсэн агуулга, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар мэдээлэл, тайлбар өгөх зорилгоор бичигдсэн. 2002 онд хэвлэгдсэн гарын авлагыг дахин шинэчлэн, нэмэлт өөрчлөлт, засвар хийн хэвлүүлэв.

Гарын авлагад шинэчлэлийн үзэл санаа, улсын төсөв боловсруулах үйл явц, төсвийн удирдлага, байгууллагад үзүүлэх нөлөө, шинэчлэлийг хэрэгжүүлэх байгууллагууд, тэдгээрийн үүрэг, хариуцлага, шинэчлэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө зэргийг багтаажээ.

### **0314**

**Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл, төсвийн байгууллагын бүтээгдэхүүнийг тодорхойлох, бүтээгдэхүүний өртөг тооцох гарын авлага**

*Төрийн захиргааны шинэчлэлийн төслийн баг, гарын авлага, 2003, Улаанбаатар, 98 хуудас, Монгол*

ТБУСТХ-ийг хэрэгжүүлэх, ялангуяа төсвийн байгууллагаас төсвийн ерөнхийлөн захиргачид нийлүүлэх бүтээгдэхүүнийг тодорхойлох, түүний өртгийг тооцоход төсвийн байгууллагад туслах зорилготой.

Гарын авлага нь төсвийн байгууллагын бүтээгдэхүүнийг тодорхойлох, төсвийн байгууллагын бүтээгдэхүүний өртөг тооцох гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Гарын авлагад төсвийн байгууллагаас нийлүүлэх бүтээгдэхүүний гүйцэтгэх үүрэг, бүтээгдэхүүнийг тодорхойлох, томъёолох, бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт ба хүрэх түвшин, бүтээгдэхүүний ангийг тодруулах зэрэг төрийн захиргааны шинэчлэлийн өргөн хүрээг хамарч байна.

*Улсын салбарын бүтээгдэхүүний тухай шинэ ойлголт, бүтээгдэхүүнийг тодорхойлох, хэмжих, бүтээгдэхүүний өртгийг тооцох аргачлалаар хангаж, тодорхой жишээ дасгал, хавсралт материалуудаар баяжуулсан нь хэрэглээний ач холбогдолтой болсон.*

### **0315**

**Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл, хуулийн эмхтгэл**

*Төрийн захиргааны шинэчлэлийн төсөл, гарын авлага, 2003, Улаанбаатар, 182 хуудас, Монгол*

Энэхүү хуулийн эмхтгэлд ТБУСТХ-тай уялдан гарсан төрийн албаны тухай, төрийн аудитын тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулиас гадна ТБУСТХ-ийн агуулга, ач холбогдол, зарчмыг тайлбарласан товч өгүүлэл зэргийг багтаасан.



*Төрийн захиргааны шинэчлэлийн хүрээнд шинээр гарсан болон нэмэлт өөрчлөлт орсон гол хуулиудыг эмхэтгэн толилуулжээ.*

### **0316**

#### **Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл, заавар, журмын эмхтгэл**

*Төрийн захиргааны шинэчлэлийн төслийн баг, гарын авлага, 2003, Улаанбаатар, Аригц графикс ХХК-д хэвлэв, 228 хуудас, Монгол*

Гарын авлагад санхүү, эдийн засгийн сайд болон төрийн албаны зөвлөлөөс батлан гаргасан шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбоотой заавар, журмыг эмхэтгэв. Эмхтгэлд бүтээгдэхүүн нийлүүлэх төсвийн санхүүжилтийн гэрээний загвар, заавар, төсвийн байгууллагын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайлан гаргах журам, үлгэрчилсэн загвар, бүтээгдэхүүн тодорхойлох заавар, төрийн албаны зөвлөлийн шинэчилсэн дүрэм, төрийн албаны мэргэшлийн шалгалт авах болзол, журам, төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежертэй үр дүнгийн гэрээ байгуулах заавар зэрэг арав гаруй журам, заавар багтжээ.

*Төрийн захиргааны шинэчлэлтэй холбогдох заавар, журмыг боловсруулан гаргах нь шинэчлэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөт ажлын нэг хэсэг юм.*

### **0317**

#### **Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл, төсвийн удирдлагын гарын авлага**

*Төрийн захиргааны шинэчлэлийн төслийн баг, гарын авлага, 2003, Улаанбаатар, “Бишрэлт тэнгэр” хэвлэлийн газарт хэвлэв, 135 хуудас, Монгол,*

Гарын авлага нь төсвийн ерөнхийлөн захирагч, яам, агентлаг, төсвийн байгууллагын удирдах болон санхүүгийн ажилтнуудад зориулагдсан. Гарын авлагад төсвийн удирдлагыг шинэчлэх шаардлага, шинэ системийн мөн чанар, төрийн үйлчилгээг сайжруулахад түүний үзүүлэх нөлөө, улсын төсвийн үйл явц, байгууллагын төсвийн систем, төлөвлөлтийн үндэс, төсвийн хөрөнгө нөөцийг үр ашигтай удирдах арга, механизм, улсын салбарын тайлагнал, хяналтад тавигдах шаардлага, хяналтын арга, хэрэгсэл зэрэг асуудлуудаар тайлбар өгөхөд чиглэгджээ.

*Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл, батлагдсан эрх зүйн орчинг шинэчлэлийн үндсэн үзэл санаа, зарчмуудтай холбон тайлбарлаж, уг салбарт ажиллаж буй мэргэжилтнүүд ажилдаа хэрэглэж, нэвтрүүлэхэд нь тус дөхөм болохуйц гарын авлага болсон.*

### **0318**

#### **Хүний эрх ба нутгийн өөрөө удирдах ёс**

*Д.Баярсайхан, багийн иргэдэд зориулсан гарын авлага, 1999, Улаанбаатар, 54 хуудас, Монгол*

Энэ гарын авлагыг хөдөөгийн хүн ам, багийн иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг бие даан дээшлүүлэхэд нь туслах зорилгоор бэлтгэв.

Уг гарын авлага нь Хүний эрх бол таны боломж мөн, Нутгийн өөрөө удирдах ёс бол ардчилал, Ард түмний засаглал мөн, Улс төрийн ардчилал ба эдийн засгийн хөгжил гэсэн гурван бүлэгтэй. Бүлэг тус бүрийн эхэнд тухайн бүлгээс ямар сэдвийг уншиж судлах, үүний үр дүнд та ямар мэдлэгийг олж авах, тэр нь таны амьдралд ямар ач холбогдолтой болохыг харуулсан тойм ба уншиж судлах материал, гүйцэтгэх дасгал, ойлгосноо шалгах сорил гэсэн хэсгээс бүрдэж байна.

Гарын авлагад дараах санааг хөнджээ. Үүнд: Хүний эрх, эрх чөлөө нь хөгжлийн хэд хэдэн үе шатыг дамжин хөгжиж ирсэн бөгөөд 1990 оноос энэхүү хөгжилд ихээхэн дэвшил өөрчлөлт гарсан ажээ.

Нутгийн өөрөө удирдах ёс гэдэг нь ардчилсан нийгэмд иргэн хүн өөрийн амьдарч буй орон нутгийнхаа асуудлыг шийдвэрлэхэд оролцох бүрэн баталгаа боломжоор тодорхойлогддог. Нутгийн өөрөө удирдах ёс хэрхэн хэрэгжиж буй талаар тухайн нутгийн ард түмэн хамгийн зүй зохистойгоор тодорхойлж, үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгч чадна. Тус гарын авлагыг ЮНЕСКО “Сурч амьдарья” төсөл, “Баг дахь хүний эрх, орон нутгийн ардчилал ба хөгжил” төслийн багаас хамтран гаргажээ.

*Хүний эрхийн талаархи ойлголт, хүний эрхийн төрөл, ангилал, түүхэн хөгжил, хүний эрхийн талаархи Үндсэн хуулийн зарчим зэрэг асуудлын талаархи хөдөөгийн иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд тус дөхөм болсон гэж найдаж байна. Нутгийн өөрөө удирдах ёс гэж чухам юу болохыг багийн иргэдэд ойлгуулж, орон нутгийн ардчиллын гол шинжийн нэг нутгийн өөрөө удирдах ёс хэрэгжиснээр орон*

*нутагт тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд ард олон хэрхэн оролцох талаархи ойлголтыг нэмэгдүүлсэн ач холбогдол бүхий гарын авлага болсон байна.*

### **0319**

#### **Хүрээлэн буй орчныг хамгаалах орон нутгийн удирдлагын үүрэг**

*“Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь-II” (2001-2004), Баян-Өлгий, Увс аймгийн орон нутгийн төслийн баг, гарын авлага, 2005, Улаанбаатар, “Адмон” ХХК-д хэвлэв, 47 хуудас, Монгол*

Орон нутгийн ИТХ болон Засаг дарга, төрийн албан хаагчдийн хүрээлэн байгаа орчныг хамгаалах санаачлагыг өрнүүлэх зорилго бүхий сургалтын гарын авлага юм. Гарын авлагад экологийн шинжлэх ухааны судлах зүйлийн тойм, байгаль орчныг хамгаалах тухай ойлголт, хог хаягдал, эрүүл мэндэд нөлөөлөх нь, цэвэр орчин бий болгох, байгаль орчныг хамгаалах төрийн бодлого, холбогдох хуулиуд ба нутгийн удирдлагын байгууллагуудын эрх, үүрэг, байгаль хамгаалах, мэдээлэл ба сурталчилгааны хэлбэр зэрэг өргөн агуулга багтжээ.

*Байгаль орчныг хамгаалах талаархи орон нутгийн үүсэл санаачлагыг бий болгох, хуулиар олгогдсон үүрэгээ нутгийн удирдлагын байгууллагууд хэрхэн хэрэгжүүлэх тухай асуудлыг хөндсөнөөрөө ач холбогдолтой.*

### **0330 НОМ, ТОВХИМОЛ**

### **0331**

#### **Багийн өнгөрсөн, одоо, ирээдүй**

*Б.Чимид, нэг сэдэвт бүтээл, 2002, Улаанбаатар, “Интерпресс” хэвлэлийн компани, 185 хуудас, Монгол*

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн доод нэгж болсон багийн тухай сэдвээр дагнасан ба багийн эртний уламжлалыг гол эх сурвалжаар илэрхийлэх, орчин үеийн зохион байгуулалт, эрх зүйн асуудлыг, болон ирээдүйн дүр төрхийг тодорхойлоход уг бүтээлийн зорилго оршино.

Номын тэргүүн бүлэгт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх шатны нэгж, тэдгээрийн удирдлагын талаархи шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлал үндэслэлийг эрх зүйн онолын үүднээс тайлбарласан. Хоёрдугаар бүлэгт олон зууны угшилтай Монгол түмний байгаль, түүхийн бүтээгдэхүүн, нүүдэлчдийн соёл иргэншлийн үнэт зүйл болсон засаг захиргааны доод нэгжийн үүсэл, 1921 оноос хойш багийн талаар засаг төрөөс явуулсан бодлого, түүний алдаа оноог зохиогчийн зүгээс дүгнэжээ. Багийн өнөө ба ирээдүйн тухай асуудал, 1990-ээд оноос үүсч үргэлжилсэн ардчилсан шинэтгэлийн явцад түүхэн уламжлалт багийг сэргээн байгуулсан үндэс шалтгаан, үйл явц, үр дүн ач холбогдолыг гуравдугаар бүлэгт тодорхойлов.

Баг бол хийсвэр зүйл бус харин эзэн Чингисийн үеэс дамжин хувьсаж үүсээд монголын соёл иргэншлийн бүтээгдэхүүн, уламжлалт язгуур нэгж мөн. Шинэхэн түүхийн үед хоёр удаа багийг татан буулгасан нь алдаа байсныг зохиогч тэмдэглэжээ. Өнөө үед багийг хүн ам, өрх айл, нутаг дэвсгэр, эрх хэмжээний хувьд зохистой хэмжээнд хүргэж, шинэтгэн байгуулах нь тулгамдсан зорилт болж байна гэсэн санааг зохиогч дэвшүүлжээ.

*Энэхүү ном уншигч олны хүртээл болсноор Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай ойлголт, орон нутгийн өөрөө удирдах ёсны гол шинж, энэ талаархи бусад орны жишиг, багийн үүсэл, хөгжил, багийн иргэдийн нийтийн хурлын өнөөгийн байдал зэрэг асуудлын талаархи тодорхой ойлголт өгч байгаагаараа онцлог ач холбогдолтой юм.*

## **0332**

### **Бүх шатны Хурал, Засаг даргын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн актын эмхтгэл**

*Монгол Улсын Засгийн газрын Хэрэг Эрхлэх газар, Хууль Зүйн Яам, Хууль Зүйн Мэдээллийн Төв, хуулийн эмхтгэл, 1998, Улаанбаатар, 481 хуудас, Монгол*

Эмхтгэлд хурал, Засаг даргын бүрэн эрх үйл ажиллагаанд холбогдох зарим хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг бүхэлд нь, бусад хууль тогтоомж, шийдвэрээс холбогдох бүлэг, зүйл, заалтыг хэсэгчлэн оруулжээ. Эрх зүйн актад орсон өөрчлөлт, хөдөлгөөнийг 1998 оны 1 дүгээр сарын 15-ны байдлаар бүрэн тусгаж хэвлүүлсэн. Монгол Улсын хуулиудаас 86, Ерөнхийлөгчийн зарлиг 3, Сайд нарын зөвлөл, Засгийн газрын тогтоол 238-ыг тус тус эмхтгэн үзүүлжээ.

*Эмхтгэл нь мэдлэг мэдээлэл хомс, олж авах боломж хязгаарлагдмал байсан тухайн үед нутгийн удирдлагын байгууллагуудад ажилладаг хүмүүсийн ширээний лавлагаа болж байсан. Уг эмхтгэлийг 1998 оноос хойших эрх зүйн актуудын нэмэлт өөрчлөлтүүдийг дахин тусгаж хэвлэмэл, электрон хэлбэрээр дахин гаргах нь зүйтэй.*

### **0333**

#### **Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний өнөөгийн байдал, цаашдын хандлага**

*Онол практикийн бага хурлын илтгэлцүүдийн эмхтгэл, эмхэтгэж редакторласан, П.Увш, В.Удвал, 2005, Улаанбаатар, 155 хуудас, Монгол*

Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, хэрэглээ, үнэ, өртөг зэрэг эдийн засаг, нийгмийн өргөн хүрээг хамарсан эрдэмтэн, судлаачдын хийсэн судалгааны үр дүн, хэд хэдэн илтгэлүүд эмхтгэлд оржээ. Уг эмхтгэлд нутгийн удирдлагын тухай “Сумын түвшин дэх төрийн үйлчилгээний өнөөгийн байдал” сэдэвт Я. Бямбаярын тавьсан илтгэл орсон байна. Илтгэлд одоогийн төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээний хүртээмжийн бодит байдлыг сумын түвшинд үнэлж, тэдгээр үйлчилгээг оновчтой ангилах, зохион байгуулалтыг сайжруулах талаар санал дэвшүүлжээ.

### **0334**

#### **Монголын бүс нутгийн тогтвортой хөгжлийн асуудлууд**

*Р.Ринчинбазар, нэг сэдэвт бүтээл, 2004, Улаанбаатар, “BCI” ХХК-д хэвлэцлэв, 188 хуудас, Монгол*

Бүс нутгийн асуудлаар урьд өмнө гарсан ном зохиол, судалгааг тоймлон шинэ мэдлэг, мэдээлэл, дүгнэлт санаагаар баяжуулах оролдлого хийх зорилгоор энэхүү нэг сэдэвт бүтээлийг бичжээ. Зохиогч номондоо хөгжлийн тухай орчин үеийн ойлголт, бүс нутгийн хөгжлийн үзэл санаа, хандлага, зорилго, нөлөөлөх хүчин зүйл, Монгол Улсын хөгжлийн стратеги, Монголын бүс нутгуудын хөгжлийн түвшиний ялгаа, эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлууд, гол төрийн үйлчилгээний өнөөгийн байдлыг

салбар тус бүрээр авч үзсэн байна. Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн өнөөгийн дүр, төрхийг үйлдвэрлэл, уул уурхай, ашигт малтмал, дэд бүтэц, хөдөө аж ахуй, гадаад худалдаа зэрэг салбаруудаар сүүлийн жилүүдийн статистик үзүүлэлт болон өмнө хийгдсэн судалгаануудын эх үүсвэрийг ашиглан тодорхойлжээ.

*Бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг зохистой хангахад цаашид барих бодлого, авч хэрэгжүүлэх ажил зэрэгт зохиогчийн зүгээс тодорхой саналуудыг дэвшилцжээ. Урьд өмнө энэ чиглэлээр хийж байсан зохиол, судалгаа зэргийг нэгтгэн, тоймлон авч үзсэнээрээ ач холбогдолтой.*

### **0335**

#### **Монголын бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт, удирдлагын асуудлууд**

*Р.Ринчинбазар, нэг сэдэвт бүтээл, 2004, Улаанбаатар, “BCI” ХХК-д хэвлүүлэв, 344 хуудас, Монгол*

Зохиогчоос бүс нутгийн хөгжлийн талаар бичсэн цуврал номын хоёр дахь нь болох энэ бүтээл бүхэлдээ бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт, удирдлагын асуудалд зориулагдсан. Бүсчилсэн хөгжлийн онол, арга зүйн үндэс, бүс нутгийн шинжлэх ухааны үүсэл, хөгжил, бүсийн төлөвлөлт, прогноз боловсруулах тухай нутаг дэвсгэрийг бүсчлэх арга, тэргүүлэх чиглэлийг тогтоох арга болон эдийн засаг, математик аргуудыг онолын хувьд авч үзжээ.

Монгол Улсын эдийн засгийн макро бүсүүдийн эдийн засаг, нийгмийн байдлын товч тойм, бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих арга, механизм, энэ чиглэлээр бусад оронд хэрэгжүүлж ирсэн арга хэмжээ, төрийн зохицуулалтын асуудлууд, төв ба орон нутгийн төсвийн харилцаа, бүсийн хөгжлийг дэмжих банк, санхүүгийн бодлого, бүс нутгийн удирдлагад мэдээллийн технологийг ашиглах хэтийн төлөв, бүс нутгийн менежмент, маркетинг, мониторингийн зэрэг асуудлуудыг хөнджээ.

*Бүсчилсэн хөгжлийн асуудлыг онол, арга зүйн үндэслэл, түүний эдийн засаг, нийгмийн хамрах хүрээг бүхэлд цогцоор авч үзэхийг оролдсон бүтээл болжээ.*

**0336****Монголын бүс нутгийн хөгжлийн эдийн засаг, математикийн загварчлал**

*Р.Ринчинбазар, нэг сэдэвт бүтээл, 2004, Улаанбаатар, "BCI" ХХК-д хэвлэжээ, 310 хуудас, Монгол*

Бүс нутгийн төдийгүй үндэсний хэмжээний нийгэм, эдийн засаг, экологийн тулгамдсан зорилтыг судалж, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах түвшинд ашиглаж болох математик загварчлал боловсруулах зорилготой бүтээл.

Тогтвортой хөгжлийн чухал хүчин зүйл болох эдийн засаг, экологи, хүн амын эрүүл мэндийн асуудлыг авч үзсэн. Бүс нутгийн аж, ахуйн үйл ажиллагааг шинжлэх, бүсийн болон салбарын төлөвлөлтийг уялдуулах, үйлдвэрийн газрын бүтцийн өөрчлөлтийн шинжилгээ, үр ашгийн тооцоо хийх, жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжилд зээл, хөрөнгө оруулалтын үүргийг үнэлэх, ус, агаар, газар, ой, биологийн төрөл зүйл зэрэг байгалийн баялгийн нөөцийг зохистой ашиглах, хүрээлэн буй орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг судлах зэрэг асуудлуудыг багтаасан.

*Бүс нутгийн эдийн засгийн математик загварчлалын онол, арга зүйн чиглэлээр хийгдсэн анхны бүтээл болсон.*

**0337****Монгол Улсын орон нутаг, түүний удирдлага**

*Г.Маналжав, М.Мандах, Нэг сэдэвт бүтээл, 2004, Улаанбаатар, "Хөх судар" принтинг хэвлэлийн компанид хэвлэв, 112 хуудас, Монгол*

Орон нутаг үүсэж хөгжсөн товчоон, нутгийн удирдлагын тухай, орон нутаг түүний удирдлагын талаарх Үндсэн хуулийн үзэл санаа бодит байдал, цаашдын хандлагын талаарх ойлголтыг орон нутгийнханд санаа болох, судлаач эрдэмтдэд дохио өгөхөд нэмэр болох, иргэдийн оюун ухаанд дусал ч атугай мэдлэг нэмэх зорилгоор уг бүтээлийг бичжээ.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж үүсэж хөгжсөн товчоон буюу (Эртний үеийн хошуу, таван аймгийн үүсэл хөгжил болон одоогийн 21 аймгийн үүсэл), нутгийн удирдлагын тухай ойлголт, орон нутаг түүний удирдлагын талаарх Үндсэн хуулийн үзэл санаа, бодит байдлын зөрүү зэрэг асуудлын хүрээг хамарчээ.

Бүс нутгийн хөгжлийн бодлого чиглэлийг эхнээс нь зөв тодорхойлж хэрэгжүүлж чадвал өөрчлөлт шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэх нэг нөхцөл болно. Хүн ам цөөн тархай бутархай оршин суудаг уудам нутаг дэвсгэртэй, хязгаарлагдмал нөөц бололцоотой манай орны хувьд орон нутгийг бүсчлэн хөгжүүлэх нь тулгамдсан асуудал болоод байгааг зохиогчид дурьджээ. Улс орны эдийн засаг, дэд бүтэц, нийгмийн салбарыг бүс нутгийн зарчмаар хөгжүүлэн төвлөрлийг сааруулж нутгийн өөрөө удирдах ёсыг зөв төлөвшүүлэх нь улс орны хөгжлийг түргэтгэх нэг нөхцөл мөн. Зохиогчид Монгол орны төрт ёсны олон зуун жилийн түүхэн хөгжлийн явц дахь орон нутгийн тогтолцоо, тэдгээрийн удирдлагын бүтэц, чиг үүргийг нарийвчлан гаргах нь Монгол орны цаашдын хөгжлийн асуудалд нэн ач холбогдолтой хэмээн тэмдэглэжээ.

*Энэхүү бүтээлийн гол үр дүн нь Монголын түүхэн уламжлалт засаг захиргааны нэгж, түүний үзэл хөгжил, өөрчлөлтийн товчоон болон өнөөгийн нутгийн удирдлагын талаарх Үндсэн хуулийн үзэл санаа, бодит байдал дахь хэрэгжилтийн талаар зохиогчид тодорхой санаа, дүгнэлтийг боловсруулсанд оршино.*

### **0338**

#### **Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, товхимол II**

*Улс Төрийн Боловсролын Академи, товхимол, 2000, Улаанбаатар, Адмон ХХК-д хэвлэв, 115 хуудас, Монгол*

Уг товхимолд Б. Чимид, орон нутгийн удирдлагын тухай Монгол Улсын хандлага, Г. Ганхуяг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өнөөгийн байдал, хэтийн төлөв, төсөв санхүү, Б. Баттүвшин, Нутгийн өөрөө удирдах ёсны тухай шинэ үндсэн хуулийн заалтууд, нутаг дэвсгэрийн нэгжийн төсөв, санхүүгийн бие даасан байдал зэрэг илтгэлүүдийг оруулжээ.

Ардчиллын арван жилийн хугацаанд нутгийн удирдлагын үзэл санаа хүмүүсийн амьдралын нэгэн салшгүй хэсэг болсоор байна. Ийм ч учраас нутгийн удирдлагын тогтолцооны улс төр, эдийн засгийн орчныг боловсронгуй болгохын зэрэгцээ өөрөө удирдах ёсны боломж чадамжийг бүрэн нээх, ИТХ, Засаг даргын хамтран ажиллах үйл ажиллагааг тодорхой болгож, эл хоёр субъектийн эрх үүргийг нарийвчлан тодотгох, төв засгийн болон орон нутгийн харилцаа зэргийг боловсронгуй болгох



арга замын талаар илтгэгчид тодорхой санал гаргаж тавьсанаараа уг бүтээлийн ач холбогдол оршино.

*Илтгэлцүдэд “Нутгийн өөрөө удирдах ёсны тухай Үндсэн хуулийн заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах зайлигцуй шаардлага байгаа, ингэснээр Монголд ардчиллын цнэт зүйлсийг баталгаажуулах, иргэний нээлттэй нийгэм бүрдүцлэхэд ихээхэн хувь нэмэр оруулна” гэсэн санааг дурьджээ.*

### **0339**

#### **Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, товхимол IY**

*Улс Төрийн Боловсролын Академи, товхимол, 2002, Улаанбаатар, Экимто ХХК-д хэвлэв, 192 хуудас, Монгол*

Үндсэн хуулийн арван жилд зориулан Улс Төрийн Боловсролын Академиас Дархан уул, Дорнод, Дундговь, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Ховд аймагт зохион явуулсан онол практикийн бага хурлаар нутгийн удирдлагын үзэл баримтлалын хэрэгжилт, учирч буй бэрхшээл, шийдвэрлэвэл зохих асуудал зэрэг сэдвээр хэлэлцүүлэг явуулсан эдгээр хурлаар хэлэлцсэн гол илтгэлүүдийг товхимолын энэ дугаарт нийтэлжээ.

Энэ бүтээлд Б.Дэлгэрмаагийн “Монгол Улсын шинэ үндсэн хуулийн арван жилд”, С.Нармандахын “Нутгийн удирдлага, олон түмний оролцоо”, Д.Ганзоригийн “Нутгийн хурлын эрх хэмжээний тухай асуудал”, О.Тунгалагын, “Баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурал, эрх хэрэгжүүлж байгаа асуудал”, П.Доржсүрэн, Я.Баябасүрэн нарын “Орон нутагт бодлого боловсруулах асуудал”, Б.Алтансүхийн “Орон нутгийн төсвийн тогтолцооны асуудал”, А.Пагмын “Орон нутгийн сонгууль ба нутгийн удирдлага” зэрэг орон нутагт зохиогдсон онол, практикийн бага хурлууд дээр тавигдсан илтгэлүүдийг оруулсан. Бага хурлуудад эрдэмтэд бус нутгийн удирдлагыг гардан хэрэгжүүлж буй орон нутгийн улс төрчид, төрийн албан тушаалтан, төрийн бус байгууллага, иргэдийг өргөнөөр оролцуулж, санал солилцсон байна.

*Нутгийн өөрөө удирдах байгууллага нь бие даан ажиллах цүднээс юуны түрцүнд дотоод зохион байгуулалтынхаа асуудлыг бие даан шийдвэрлэх, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг шинэчлэх, төсвийн шинэчлэлийг хийх, орон нутгийн өмчийг өмчийн бусад хэлбэрийн нэгэн адил хүлээн зөвшөөрөх,*

захиргааны эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчлан хийх зэрэг асуудлуудыг шийдэх шаардлагатай байна гэж хэлэлцүүлэгт оролцогчид дүгнэжээ.

### **0340**

#### **Нутгийн өөрийн удирдлага**

*Б.Өлзийбаян, тцүхэн цйл явцын эмхтгэл, 2004, Чойбалсан хот Засгийн газрын хэвлэх цйлдвэр, 152 хуудас, Монгол*

Зохиогч өөрийн ажил, амьдралын туршлагадаа үндэслэн Дорнод аймгийн нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үүсэл хөгжил, туулж өнгөрүүлсэн түүхэн замнал, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлтийн түүх, аймаг, сумдын ИТХ-ын хуралдаан, зарим чухал асуудал хэлэлцсэн байдал, гарсан шийдвэр зэргийг тухайн үед ажиллаж байсан хүмүүсийн хэлсэн үг, хуралдааны протокол, түүхэн эх сурвалжуудад үндэслэн олон нийтэд үзүүлэхийг зорьсон байна.

Уг бүтээлд Дорнод аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллагуудад түүхэн үеүдэд ажиллаж байсан ИТХ-ын тэргүүлэгчдийн дарга, тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, ИТХ-ын тэргүүлэгчдийн даргаар ажиллаж байсан хүмүүсийн тухай мэдээллийг хавсралтаар үзүүлжээ.

*Тодорхой нэг аймгийн жишээн дээр нутгийн өөрөө удирдах байгууллагын хөгжил, тцүхэн замнал, олж авсан туршлага, сургамж зэргийг нэгтгэн цзүцлсэнээрээ ач холбогдолтой бүтээл болсон.*

### **0341**

#### **Нутгийн өөрийн удирдлагын өнөөгийн байдал, ололт, дутагдал, хандлага**

*Монголын Нутгийн Удирдлагын Холбоо, онол практикийн бага хурал, илтгэл, хэлсэн цгийн эмхтгэл-2002.09.22, 2003, Улаанбаатар, “Экитмо ХХК-ийн хэвлэх цйлдвэрт хэвлэв, 135 хуудас,” Монгол*

Нутгийн удирдлагын орчин үеийн хөгжил дэвшил, өнөө ба хэтийн чиг хандлага, гадаад орнуудын жишиг жаяг, нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг улам боловсронгуй болгох талаархи УИХ-ын гишүүд, Засгийн газар, “Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхийг бэхжүүлэх нь-II”

Монгол-Шведийн хамтарсан төслийн мэргэжилтнүүд зэрэг зохих түвшний эрх бүхий хүмүүсийн үзэл бодлыг олон нийтийн хүртээл болгох зорилгоор эмхтгэлийг гаргав. Эмхтгэлийг Монголын Нутгийн Удирдлагын Холбооноос эрхлэн гаргасан бөгөөд нутгийн өөрийн удирдлагын тогтолцоо үүсэж хөгжсөний 10 жилийн ойд зориулсан.

Нутгийн өөрийн удирдлагын өнөөгийн байдал, ололт, дутагдал, хандлага сэдвийн дор УИХ-ын Төрийн Байгуулалтын Байнгын Хорооны дарга Д.Дэмбэрэлийн “Нутгийн өөрөө удирдах ёсыг Үндсэн хуулиар баталгаажуулсан нь ардчиллын ололт мөн”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Я.Долгоржавын “Монгол Улсын нутгийн удирдлагын тогтолцоо, ололт, дутагдал”, Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын дэд дарга Б.Шатарын “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн тухай”, Сайн засаглал хөтөлбөрийн зохицуулагч Д.Цэрэндоржын “Төвлөрлийг сааруулж нутгийн удирдлагыг бэхжүүлэх дэлхийн хандлага, Монголын онцлог” сэдэвт илтгэлүүд болон тодорхой эрх бүхий албан тушаалтнуудын хэлсэн үг зэргийг эмхтгэн тус номонд оруулжээ.

*Нутгийн өөрийн удирдлагын өнөөгийн байдал, ололт, дутагдал, хандлага сэдвийн хүрээнд явагдсан бага хурлаар оролцогчид өөр өөрийн цнэлэлт дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход санал зөвлөмж гаргаж, түүнийг хэрэгжүүлэх асуудлыг хэлэлцсэн. Тухайлбал “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах саналууд зэрэг тодорхой асуудлыг хэлэлцсэн байна.*

## **0342**

### **Нутгийн удирдлага**

*М.Сандаг-Очир, нэг сэдэвт бүтээл, 2003, Улаанбаатар, Удирдлагын Академийн хэвлэх тасагт хэвлэв, 152 хуудас, Монгол*

Монгол Улсын өнөөгийн нутгийн өөрөө удирдах ёс, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны онолын болон эрх зүйн үндэслэл, тэдгээрийн практик үйл ажиллагааг нэгтгэн дүгнэж, нутгийн удирдлагын байгууллагын ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх асуудлыг хөнджээ. Бүтээлд өнөөгийн нутгийн удирдлагын байгууллагын эрх, хэмжээг төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооны үеийн Хурал, захиргааны байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалттай харьцуулан дүгнэж, ялгагдах онцлог, ижил талуудыг гаргахыг зорьсон.

Монгол Улсын нутгийн удирдлагын тогтолцооны тухай Үндсэн хуулийн үзэл баримтлал, нутгийн өөрөө удирдах ба нутгийн захиргааны байгууллагын статус, эрх хэмжээ, үйл ажиллагааны зохион байгуулалт, чиг үүрэг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, хот, тосгоны ангилал, зэрэглэл, удирдлагын хэв маяг онцлог, нутгийн удирдлагын байгууллагаас төрийн дээд болон төрийн захиргааны төв байгууллагатай харилцах харилцаа болон Хурал, Засаг даргын харилцааны асуудал, нутгийн хурлын сонгууль, гадаад орнуудын нутгийн удирдлагын тогтолцоо зэрэг өргөн агуулгын хүрээнд авч үзэх оролдлого хийжээ.

*Зохиогч бүтээлдээ нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь өөрсдийн эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаагаа харилцан уялдуулах, төр засгийн байгууллагатай харилцах, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх орон нутгийн боловсон хүчнийг сургах, мэргэшижүүлэх, давтан сургах зэрэг асуудлыг Швед болон бусад орнуудын туршилагад тулгуурлан хөгжүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлжээ.*

### **0343**

#### **Санаачлага -Үр дүн, арга барил, туршлага**

*Монголын Нутгийн Удирдлагын Холбоо, Г.Маналжав, Б.Шарбанди, нутгийн өөрөө удирдах ёс цэц хөгжсөний 10 жилийн ойд зориулсан эмхтгэл, 2002, Улаанбаатар, 78 хуудас, Монгол*

Нутгийн өөрөө удирдах байгууллагын ажил манай улсын, аймаг, сумдуудад зохистойгоор төлөвшин тогтож, нутгийн удирдлагын байгууллагуудын ажилд шинэлэг арга барил нэвтэрч, ихээхэн туршлагыг хуримтлуулаад байгаа энэ үед тэргүүний гэгдэх байгууллага, хүмүүсийн ажлын шинэлэг, арга барилыг нэгтгэн энэхүү товхимолыг бүтээжээ.

Товхимолд Баянхонгор, Говь-сүмбэр, Төв, Сэлэнгэ, Дундговь, Дорноговь, Ховд, Говь-Алтай, Дархан-Уул, Завхан зэрэг аймгуудийн нутгийн өөрөө удирдах байгууллагуудын үйл ажиллагааны шинэлэг туршлага, санаачлагыг тухайн орон нутгийн хүмүүсийн бичсэн 24 илтгэлийг хураангуйлан үзүүлжээ. Илтгэлүүдэд аймаг, сумдын ИТХ-ын үйл ажиллагаа, зохион байгуулалт, ЭДТГ-ын туршлага, санаачлага, хүн эмнэлэг, мал эмнэлэг, халамж зэрэг төрийн үйлчилгээний зохион байгуулалт ба орон нутгийн төсөв санхүүгийн асуудлуудыг хамарсан байна.

*Нутгийн удирдлагын ажилтнууд, сонирхогч талууд, судлаачдад хандан нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг цаашид боловсронгуй болгоход шинэ санаа дэвшицүлэхэд, мөн сургалт, сурталчилгаа, практик хэрэглээний ач холбогдолтой товхимол болсон.*

## **0344**

### **Сумын судалгаа: Онол арга зүйн асуудал**

*“Сум, баг хөгжүүлэх загвар” судалгааны баг, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын эмхтгэл, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэг агентлаг Удирдлагын Академи, 2004, Улаанбаатар, Удирдлагын Академийн хэвлэх тасагт хэвлэв, 378, хуудас, Монгол*

Хөдөөгийн хөгжлийн удирдлагын хүрээнд сумын зах зээлийн харилцааг төлөвшүүлэх орон нутгийн хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлж эдийн засгийн хувьд бие даан хөгжүүлэх арга боломжийг илрүүлэхэд судалгааны ажлын зорилго оршиж байна.

Эмхтгэлд Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэг агентлаг Удирдлагын Академи, “Сум, баг хөгжүүлэх загвар” сэдэвтэй 2003 онд явуулсан судалгааны ажлын үр дүн, профессор Б.Чимидийн “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид сумын эзлэх байр суурь”, Т.Энэбишийн “Сумын зохистой хэмжээг тогтоох нийгэм, эдийн засгийн асуудал”, Г.Жаргалсайханы “Хөдөөг хөгжүүлэх стратегийн хувилбарууд”, Д.Ганзоригийн “Сумын засаг захиргааны үйлчилгээний байдал”, Б.Баясгалангийн “Сумын төсвийн харилцаа, өнөөгийн байдал” зэрэг судалгааны нийт 10 өгүүлэл орсон болно.

Орон нутгийн удирдлагын үзэж байгаагаар сумын Хурлын эрх хэмжээний хамгийн гол асуудал нь сумын төсөв батлах төсөв хуваарилах асуудал юм. Орон нутагт нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх, суманд ажиллаж буй нийгмийн үйлчилгээний байгууллагын уялдаа холбоог сайжруулах, суманд тулгамдаж буй асуудлыг орон нутгийн боломжоор шийдвэрлэх зэрэгт орон нутгийн төсөв ихээхэн үүрэгтэйг тодорхойлон гаргасан.

Төсвийн орлогыг бүрдүүлж байсан зарим нэр төрлийн орлогын татварыг тухайлбал, Онцгой албан татвар, НӨАТ, Газар үл хөдлөх хөрөнгийн албан татвар

гэх мэт орлого өндөртэй татваруудыг улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлдэг болсон нь томоохон сумдын удирдлагын ажлын идэвхи санаачлагыг сулруулж, орлогоо өөрөө бүрдүүлдэг байсан сумдыг татаас харж суудаг хэв шинжтэй болгосон гэж судлаачид үзжээ.

Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн хууль хэрэгжиж эхэлсэнээр төрийн үйлчилгээний байгууллагууд буюу сумын хувьд томоохон байгууллага болох сургууль, эмнэлгийн үйл ажиллагаанд хяналт тавих, удирдах боломж Засаг дарга ба ИТХ-д дутагдаж байна.

*Сумын өнөөгийн эдийн засаг, нийгмийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж, сумын хөгжилд тулагмдаж буй асуудлуудыг тодорхойлохыг оролдож, цаашид сумыг хөгжүүлэх талаар хийх ажил, арга хэмжээний санлыг дэвшүүлжээ.*

### **0345**

#### **Хурал, өөрөө удирдах ёс**

*Г.Маналжав, Нэг сэдэвт бүтээл, 2000, Улаанбаатар, Адмон компанид хэвлэв, 132 хуудас, Монгол*

Орон нутгийн Хурлын байгууллагын онцлог, ажлын чиг үүрэг, түүнд сонгогдсон хүмүүсийн идэвхи санаачлага, ялангуяа нийслэлийн эдийн засаг, нийгмийн олон талт асуудлыг шийдвэрлэхэд хотын Хурал ямар үүрэгтэй байсан тухай, өөрөө удирдах байгууллагын өнөөгийн болон хэтийн төлөв чиглэлийг тодорхойлоход энэхүү бүтээлийн гол зорилго оршиж байна.

Товхимолд Ардын хурлын тухай, Нутгийн өөрөө удирдах ёс, түүний цаашдын төлөвшил, Нутгийн өөрөө удирдах байгууллага, түүнийг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах, Шведийн туршлага, Нийслэлийн хурлын түүхэн замнал, ИТХ сахилга, дэг журам зэрэг сэдвийг хамарчээ.

Нутгийн өөрөө удирдах ёсыг жинхэнэ утгаар нь төлөвшүүлж, орон нутаг бие даан ажиллах боломжийг бүрдүүлэхэд гадаадын орнуудын арга туршлага чухал гэдгийг анхаарах ёстой. Манай улсад орон нутаг нь өөрийн нутаг дэвсгэртэй, хүн амтай, өөрийн удирдлагатай, удирдлагаа сонгож байгуулдаг зарчимтай нь өөрөө удирдах ёс төлөвшиж хөгжих бодит нөхцөл нь бүрэлдсэн гэж зохиогч өгүүлжээ. Энэ бодит нөхцөлд өөрөө удирдах ёсыг жинхэнэ утгаар нь бий болгож өөрөө удирдах ёсны

байгууллагын эрх мэдэл, чиг үүргийг тодорхой, оновчтой болгох, түүнийг хэрэгжүүлэх хүмүүсийн санаачлага, идэвхийг өрнүүлэх явдал гол зорилт болоод байна гэж зохиогч тэмдэглэжээ.

*Үе цөийн хурлын байгууллагыг хөгжцүлэх, зохион байгуулалт, ажлыг нь сайжруулах талаарх зохиогчийн санаа бодол нь өнөөгийн сонгуультаан, хурал, захиргааны байгууллагын ажилтнуудад санаа өгөх, хууль, төрийн захиргааны удирдлагын чиглэлээр суралцаж буй оюутан сурагчдад танин мэдэхүйн ойлголт өгөхөд ач холбогдолтой юм.*

### **0346**

#### **“Хүчирхэг орон нутаг-Хүчирхэг Монгол Улс” илтгэлийн эмхтгэл**

*УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, товхимол, 2006, Улаанбаатар, Монгол*

Шинэ үндсэн хууль ба нутгийн өөрөө удирдах ёс илтгэл Б.Баттүвшин, “Нутгийн удирдлагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал” Д. Дондог, “Орон нутгийн бие даасан байдлыг хангаж, төвлөрлийг сааруулах нь”, Д. Идэвхтэн, “Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаар МАХН-ын баримтлах байр суурь”, Я. Бямбаяр, “Нутгийн удирдлагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал”, М. Үүрийнтуяа, “Орон нутагт нутгийн өөрөө удирдах байгууллагын өнөөгийн байдал”, зэрэг орон нутгийн удирдлагын чиглэлээр судалгаа хийдэг багш, судалгааны ажилтнуудын илтгэлүүдийг багтаасан товхимол юм.

Дээрх илтгэлүүдээс нэг илтгэлийг жишээ болгон авч үзье. Б.Баттүвшингийн тавьсан “Шинэ үндсэн хууль ба нутгийн өөрөө удирдах ёс” гэсэн илтгэлдээ 1992 оны Үндсэн хуулийн ач холбогдол, түүгээр баталгаажиж буй эрх, эрх чөлөөгөө олон нийт хэрхэн эдэлж байгаа зэрэг асуудлыг хөндөөд манай улсад хийгдэж буй төвлөрлийг сааруулах үйл ажиллагааны талаар өөрийн санал дүгнэлтийг гаргаж, боловсронгуй болгох хувилбарыг дэвшүүлжээ.

Судлаачийн гол дүгнэлтээ гаргахдаа Засаг даргын үйл ажиллагаандаа удирдлага болгон хэрэглэж буй хууль эрх зүйн актуудын талаар, нутгийн захиргааны байгууллагын өөрийн үйл ажиллагааг дээд шатны байгууллагадаа тайлагнах тэр үйл явцад дүгнэлт хийсэн байна.

**4. СУДАЛГААНЫ ТАЙЛАН,  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ  
БҮТЭЭЛ**



## 0400 СУДАЛГААНЫ ТАЙЛАН

### 0401

**Шинэчлэлийг хэрэгжүүлэх төв ба нутгийн удирдлагын асуудлуудын судалгаа**

**Asian Development Bank, Study of Central-Local Government Aspects of Reform Implementation**

*Азийн Хөгжлийн Банк, ТА 3318-MON: Техникийн туслалцааны судалгааны тайлан, 2001, Улаанбаатар, Англи*

[http://www.adb.org/Documents/TACRs/MON/tacr\\_mon\\_3318.pdf](http://www.adb.org/Documents/TACRs/MON/tacr_mon_3318.pdf)

АХБ-ны техникийн туслалцааны хүрээнд Засгийн газрын Хэрэг Эрхлэх газар, Санхүү, Эдийн Засгийн Яам хамтран 2000 оны 1-р сараас 2001 оны 8-р сарын хооронд энэ судалгааны төслийг хэрэгжүүлжээ.

Энэхүү төсөл нь Засгийн газрын төрийн захиргааны шинэчлэл хөтөлбөрийн хүрээнд төвлөрлийг сааруулахтай холбоотой асуудлуудыг судлах зорилгоор хийгдсэн. Төсвийн байгууллагын шинэчлэлийн туршилтын эхний үе шатанд (1999-2002) Засгийн газрын таван яам, агентлагийн үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд чиглэсэн төсөв, санхүүгийн зарчмыг хэрэгжүүлж эхэлсэн билээ. Техникийн туслалцаа нь төсөв, санхүүгийн шинэ систем нь төв Засгийн газрын болон орон нутгийн түвшинд хэрхэн хэрэгжиж болох, хэрэгжүүлэхэд ямар зүйлүүдийг анхаарах, орон нутгийн түвшинд ямар өөрчлөлт хийх зэрэг асуудлуудыг тодорхойлоход чиглэгдэж байв. Төслөөр дараах зорилтуудыг тавьсан.

- Үр дүнд чиглэсэн дунд хугацааны төлөвлөлт хийх, таван туршилтын агентлагт гүйцэтгэлд суурилсан захиргааны шинэчлэл хийх
- Туршилтын аймгуудад төсөв, захиргааны удирдлагын шинэчлэлийг хийхэд туслах
- Засгийн газрын Хэрэг Эрхлэх газарт шинэчлэлтэй холбоотойгоор орон нутгийн засаглалын түвшинд хийж болох өөрчлөлт, арга хэмжээнд санал, зөвлөмж боловсруулж өгөх

Төслийн хүрээнд туршилтын төвийн агентлагууд болон аймгуудын удирдах ажилтнуудын хамтарсан уулзалт, семинарыг хэд хэдэн удаа зохион байгуулсан. Гол

сэдэв нь төсвийн байгууллагын шинэчлэлийн шинэ зарчим, бизнес төлөвлөлт, орон нутгийн үүрэг функц, нягтлан бодох бүртгэлийн зарчим, төлөвлөлтөө хэрэгжүүлэх зэрэг асуудлууд байв.

Орон нутгийн уулзалт семинар туршилт Архангай, Сэлэнгэ аймгуудад тус бүр 3 удаа болсон. Үндэсний семинар 2001 оны 8 сард болж орон нутгийн засаг захиргааны 22 нэгжээс төлөөлөл оролцжээ. Гадаадын мэргэжлийн зөвлөхүүд санхүүгийн төвлөрлийг сааруулах, төрийн захиргааны шинэ удирдлага ба нягтлан бодох бүртгэл зэрэг асуудлуудаар Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон туршилтын агентлагуудад зөвлөгөө өгсөн. Төслийн хүрээнд хэд хэдэн бичиг баримтыг боловсруулж, төслийн уулзалт семинараар хэлэлцсэн байна.

## **0402**

### **Монгол, Төрийн зарлагын болон санхүүгийн удирдлагын судалгаа**

#### **The World Bank, Mongolia, Public Expenditure and Financial Management Review**

*Дэлхийн Банк, бодлогын судалгааны тайлан, 2002, Улаанбаатар, Англи*

Монгол Улсад төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл хийгдэж байгаатай уялдуулан Дэлхийн Банкнаас энэ шинэчлэлийг түргэтгэх, эрчимжүүлэх зорилгоор улсын салбарын үйлчилгээ, түүний санхүүжилтийн асуудалд дүн шинжилгээ хийн цаашид шинэчлэлд анхаарах бодлогын зөвлөмж, саналуудыг энэхүү тайланд боловсруулсан болно.

Санал, зөвлөмжүүдийг сүүлийн жилүүдэд хийгдэж буй (2002 он хүртэл) эдийн засаг, нийгмийн гол бодлогуудын шинжилгээ, Монгол Улсын төсвийн зарлагын цаашдын хандлагад өгсөн үнэлэлт дүгнэлт, төсвийн одоогийн процесс, Засгийн газрын түвшингүүд хоорондын санхүүгийн харилцаанд хийсэн дүн шинжилгээ зэрэгт үндэслэн боловсруулжээ.

Зөвлөмжид орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх механизмыг урамшуулах, төв Засгийн газар ба орон нутгийн хуваан авдаг татварыг багасгах, орон нутагт олгох татаасыг тодорхой шалгуурт үндэслэн, томъёонд суурилан олгодог байх, орон нутгийн өмчийн татварын баазыг нэмэгдүүлэх, орон нутгийн төсвийн өөрийн орлогын хэмжээг нэмэгдүүлэхийн зэрэгцээ ил тод, хариуцлагатай байдлыг бий болгох, Засгийн газрын

түвшингүүд хоорондын үүрэг функцийн ялгаа, заагийг тодорхой болгох, энэ чиглэлийн хууль, эрх зүйн шинэтгэл хийх зэрэг олон дэвшилтэд санаанууд багтсан юм.

*Монгол Улсад өрнөсөн төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн шинэчлэлийн үр дүнд 2002 онд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль батлагдаж төсвийн хяналт, төсөв батлах үйл явц, төсвийн хариуцлага зэрэг асуудлуудыг зарчмын шинэ шатанд гаргасан гэж үздэг. Гэвч шинэтгэлийн явцад яригдаж байсан олон дэвшилтэд санаа, ялангуяа орон нутгийн засаглалыг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах зэрэгтэй холбоотой зорилтууд бодит байдалд хэрэгжиж чадаагүй байна. Дэлхийн Банкнаас орон нутгийн төсвийн харилцааг шинэчлэх талаар санал болгосон дээрх зөвлөмжүүд уг хуульд тусгалаа олоогүй юм.*

### **0403**

#### **Орон нутгийн улс төрийн ёс зүйн асуудал, судалгааны тайлан, 2002 он**

*Монгол Улсын Засгийн газар, “Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь-II” төсөл, Орон Нутгийн Удирдлагын Хөгжлийн Сан, Шведын Ореброгийн Их сургуулийн судалгааны хамтарсан баг, 2002, Улаанбаатар, 74 хуудас, Монгол*

Орон нутгийн улс төрийн ёс зүйн төлөвшилд удирдлагын өнөөгийн үйл ажиллагааны нэгдмэл чанар, харилцан хамаарал, ёс зүйт байдлын төлвийг илрүүлж үнэлэлт, дүгнэлт өгөхөд судалгааны зорилго чиглэгдсэн. Судалгаанд дараах зорилтуудыг тавьсан. Үүнд:

- Орон нутгийн удирдлагын /ИТХ ба Засаг дарга, түүний тамгын газар/ үйл ажиллагааны өнөөгийн төлөв байдалд иргэдийн хандаж буй хандлагыг тодруулах
- Орон нутгийн ИТХ ба нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, тэдгээрийн уялдаа холбоо, орон нутгийн удирдлага дахь ёс зүйн байдлын талаар тодруулах.

Судалгаа явуулахдаа анхдагч мэдээлэл цуглуулах асуулгын аргыг ашигласан. Иргэдээс авах хаалттай асуулга, орон нутгийн хурлын төлөөлөгчид, нутгийн захиргааны

албан хаагчдаас авах хаалттай асуулга, сонгосон бүлгээс авах гүнзгийрүүлсэн асуулга гэсэн 3 төрлийн асуулгын тусламжтайгаар мэдээлэл цуглуулсан. Асуулга судалгаанд 21 аймаг, 9 дүүргийн 1500 орчим иргэн, 870 орчим ИТХ-ын төлөөлөгч, төрийн захиргааны албан хаагчид, 160 орчим орон нутгийн удирдах дээд албан тушаалтан (Засаг дарга, ИТХ-ын төлөөлөгчдийн дарга, нарийн бичгийн дарга нар) хамрагдсан болно.

Судалгаанд оролцогч гурван төлөөлөл болох иргэд, хурлын төлөөлөгчид, нутгийн захиргааны албан хаагчид орон нутагт ИТХ, ба Засаг даргын шийдвэр, үүрэг ролийг маш чухал гэж санал нэгтэй илэрхийлжээ.

Аливаа асуудлыг шийдэх, иргэдийг төлөөлөхөд тухайн орон нутгийн хувьд засаг захиргааны доод нэгж нь илүү чухал үүргийг гүйцэтгэх шаардлагатай гэж судалгаанд оролцогчид үзсэн байна. Судалгаанд оролцогчдын олонх нь бодит байдалд Засаг даргыг ИТХ-аас илүү эрх мэдэлтэй байдаг гэж үзсэн. Үнэн хэрэгтээ орон нутагт ИТХ нь Засаг даргаас илүү эрх мэдэлтэй байх ёстой гэж үзжээ.

#### **0404**

##### **Орон нутгийн улс төрийн ёс зүйн асуудал судалгааны тайлан, 2003 он**

*Монгол Улсын Засгийн газар, “Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь-II” төсөл, Орон Нутгийн Удирдлагын Хөгжлийн Сан, Шведын Ореброгийн Их сургуулийн судалгааны хамтарсан баг, 2003, Улаанбаатар, 84 хуудас, Монгол*

Уг төслийн хоёрдахь үе шатны судалгаа нь орон нутаг дахь улс төр, засаглалын хүрээнд төрийн захиргааны албан хаагчид, ИТХ-ын төлөөлөгчдийн ёс зүйт байдлын өнөөгийн төлөв, хандлагыг тодруулахад чиглэгдэнэ. Энэ зорилгын хүрээнд:

1. Орон нутагт ажиллаж буй хүмүүсийн, ИТХ ба Засаг дарга, түүний тамгын газрын албан хаагчдын ёс зүйн тухай ойлголтыг тодруулах
2. Орон нутгийн ИТХ ба нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаан дахь ёс зүйтэй холбоотой бэрхшээлүүд, тэдгээрийн шалтгаан нөхцөл, цаашид анхаарах асуудлыг тодорхойлох.

Судалгааг ярилцлага, асуулга авах гэсэн хоёр хэлбэрээр хийсэн. Асуулга судалгааг 21 аймаг, нийслэл хот болон түүний 9 дүүргийн нутаг дэвсгэрт явуулж, нийтдээ 1796

иргэд, 1728 орон нутгийн сонгуульд төлөөлөгч болон төрийн албан хаагчид хамрагдсан. Гүнзгийрүүлсэн ярилцлагыг 5 аймаг, нийслэлийн 2 дүүрэгт явуулж, 130 орчим иргэд, 160 орчим сонгуульд төлөөлөгч, төрийн албан хаагчидтай уулзсан.

Судалгааны үр дүнгээс харахад төрийн албан хаагчидтай холбоотой ёс зүйн асуудал нь өнөөдөр Монголын нийгэмд нилээд тулгамдсан асуудал мөн гэдгийг судалгаанд оролцсон иргэд болон орон нутгийн удирдлагын байгууллагад ажиллаж буй төрийн албан хаагчдын олонх хэсэг нь хүлээн зөвшөөрч байна.

*Асуулга судалгаанд оролцогч иргэдийн 77.1 хувь нь ёс зүйн зөрчил ямар нэгэн байдлаар гардаг гэж үзсэн. Судалгаанд хамрагдсан иргэд болон төрийн албан хаагчид төрийн захиргаанд харилцааны доголдол, иргэдийг ялгаварлах, танил тал харах, хүнд суртал гаргах зэрэг албан хаагчдын ёс суртахуунтай холбоотой зөрчлүүд нилээд байна гэж дүгнэв.*

## **0405**

**Орон нутгийн улс төрийн ёс зүйн асуудал судалгааны тайлан, 2001-2004 он**  
*Монгол Улсын Засгийн газар, “Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь II” төсөл, Орон Нутгийн Удирдлагын Хөгжлийн Сан, Шведын Ореброгийн Их сургуулийн судалгааны хамтарсан баг, 2004, Улаанбаатар, 110 хуудас, Монгол*

Энэхүү төгсөлтийн шатны судалгааны зорилго нь өмнөх хоёр шатны судалгаагаар гарсан үр дүнг нарийвчлан тодруулах, зөрүүтэй хандлага байгаа эсэхийг судлан шинжлэх явдал байв. Ярилцлагын аргаар явуулсан энэ судалгаанд судлаачид ИТХ-ын төлөөлөгчид, нутгийн захиргаанд ажиллагчид болон иргэдийн төлөөллийг аль алиныг нь хамруулахыг зорьж ажилласан.

Судалгаа нь сонгон авсан 5 аймаг, нийслэлийн 3 дүүрэгт ярилцлагын аргаар явагдаж 88 иргэн, 150 орчим орон нутгийн сонгуульд төлөөлөгч, төрийн албан хаагчид оролцжээ. Судалгааны үр дүнгээс үзэхэд төрийн албан хаагчид болон орон нутгийн улс төрчид үйл ажиллагаагаа зохицуулдаг хууль эрх зүйн талаар сайн мэдлэгтэй байдаг ба харин ёс зүйн хэм хэмжээ, харилцааны талаар мэдлэг дутмаг байгаа нь харагдав.

Иргэдийн хувьд ч төрийн албан хаагч орон нутгийн улс төрчдийн (Сонгуульд төлөөлөгч) ёс зүйтэй холбоотой зөрчил байгаа гэдгийг илэрхийлжээ. Тухайлбал,

төрийн албан хаагчдын харилцаа доголдолтой, хүмүүсийг ялгаварласан байдлаар ханддаг, үл тоомсорлох, дээрэнгүй өнгө аясаар ханддаг зэрэг зөрчлүүдийг иргэд нэрлэж байв. Ёс зүйн асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн удирдлага дахь албан хаагчид, хурлын төлөөлөгчид, бизнес эрхлэгчид, иргэдийн оролцоо, хамтын ажиллагаа чухал гэж үзжээ.

Ёс зүйн зөрчлийн үндсэн шалтгаануудыг албан хаагчдын цалин, ахуй хангамж муу, хувь хүний ёс суртахууны төлөвшил муу, сахилга хариуцлагын механизм сул гэж судалгаанд оролцогчид үзжээ.

### **0406**

#### **“Орон нутгийн түвшинд ардчиллыг бэхжүүлэх нь: Тулгамдсан асуудлын судалгаа”**

*Жон Кйуага-Нсүбуга, Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон олон улсын V бага хурлаас гаргасан “Судалгааны ажлууд ба төгсгөлийн баримт бичгийн эмхтгэл”, 2003, Улаанбаатар, 69-82 хуудас, Монгол*

Орон нутагт ардчиллыг дэмжин бэхжүүлэх замаар орон нутгийг хөгжүүлэх асуудлыг авч үзсэн судалгаа. Тухайлбал орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор орон нутгийн засаглалыг хэрхэн хөгжүүлэх, үүний тулд төвлөрлийг сааруулах, орон нутгийн захиргаа ба хөгжлийн хооронд ямар харьцаа байгаа, орон нутагт ардчиллыг хөгжүүлэхийн тулд шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хөгжлийн явцыг хянаж чадахаа болино гэсэн төв засгийн газрын болгоомжлолыг шийдвэрлэх, улмаар хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд ба нөөцийн хуваарилалтыг тодорхойлоход жинхэнэ ёсоор эрх мэдэлтэй байх эрхийг орон нутгийн захиргаа ба байгууллагуудад олгох зэрэг асуудлуудыг азийн орнуудын жишээн дээр судалж тайлбарласан.

### **0407**

#### **Санхүүгийн төвлөрлийг сааруулах судалгаа**

*Өрхийн амьжиргааны дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд тус хөтөлбөрийн газрын санхүүжилтээр Монгол Менежмент Төв ТББ, судалгааны тайлан, 2004, Улаанбаатар, Монгол*

“Санхүүгийн төвлөрлийг сааруулах” судалгаа нь Өрхийн Амьжиргааг Дээшлүүлэх Хөтөлбөрийн Газрын (ӨАДХГ) захиалгаар 2004 онд 3 сарын хугацаанд хийгдсэн. Судалгааны зорилго нь төсвийн санхүүгийн төвлөрлийг сааруулах судалгааны цаашдын чиг хандлагыг тодорхойлох, түүний хууль эрх зүйн орчныг тодорхойлох, одоогийн бодит байдлыг үнэлэхэд чиглэгдсэн. Судалгаагаар аймаг, сумын санхүүгийн төвлөрлийг сааруулах эрх зүйн орчин, төвлөрөл сааруулалтын одоогийн төлөв байдлыг тодорхойлохыг оролдсон.

Судалгааны ажлын хүрээнд:

- Санхүүгийн харилцааг зохицуулж байгаа хууль эрх зүйн баримт бичгийг шинжлэн 4 аймаг, 8 сумын санхүүгийн төвлөрлийг сааруулж байгаа өнөөгийн байдалд нарийвчилсан судалгаа хийж тайлан боловсруулсан.

Судалгааны баг дараах дүгнэлт, зөвлөмжийг боловсруулжээ. Үүнд:

- Иргэдийн үүрэг, хариуцлага болон төрийн бүх шатны удирдлагыг хамарсан санхүүгийн төвлөрлийг сааруулах арга замыг тодорхойлсон бодлогын нэгдсэн баримт бичиг боловсруулах. Энэ баримт бичигт дараахь зүйлсийг тусгасан байх ёстой:
  - Төсвийн асуудалд холбогдох бүх үүрэг хариуцлагыг тодорхойлох
  - Орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх
  - Санхүүгийн удирдлагын уян хатан байдал мэдрэмжийг сайжруулах
  - Төсвийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах
  - Орон нутгийн эдийн засгийн өсөлт, өөрийн орлогыг нэмэгдүүлэх.
- Хуулийн дагуу аймаг, сумд бизнес төлөвлөгөөгөө боловсруулж, төсвөө зохиох байтал бодит байдалд бизнес төлөвлөгөө ёс төдий хийгдэж байна. Төсөв нэрээр зөвхөн зардлын саналыг орон нутаг боловсруулж байна.
- Төсвийг хэлэлцэн батлахдаа доод шатны нэгжийн сонирхол, эдийн засгийн бодит нөхцөл байдлыг үл харгалзан зөвхөн өмнөх жилийн төсөвт суурилах байдал илүүтэй байна.
- Төсвийн хяналт мониторинг сул хийгдэж байна. Ялангуяа ИТХ ба иргэдийн зүгээс төсвийн хэрэгжилтэнд тавих хяналт огт хийгдэхгүй байна. Энэ талаар маш цөөн газруудад санал санаачлага гарчээ.

- Иргэдийн төсөвт оролцох байдал тун хязгаарлагдмал байна. Энэ нь мэдээлэл хомс, баг, хороо зэрэг доод түвшиний нэгжийн хурал дээр төсвийн асуудлыг огт ярьдаггүй байгаатай холбоотой.
- Аймаг ялангуяа сумдуудад эдийн засгийн орлого олох өөрийн нөөц хомс байна.

## 0408

### **Үндэсний ба нутгийн удирдлагын чиг үүргийн зохистой хуваарилалт**

*Нээлттэй Нийгэм Форум, гүйцэтгэгч Л. Лувсанжамц, 2005, Улаанбаатар, Соёмбо принтинг ХХК-д хэвлэв, 54 хуудас, Монгол*

Бодлогын судалгаа нь Монгол Улсын төв Засгийн газар болон орон нутгийн удирдлага, тэдгээрийн үүрэг роль, эрх мэдлийн хуваарилалт, төсвийн харилцааны өнөөгийн нөхцөл байдал, практикт тохиолдож буй бэрхшээлтэй асуудлыг тодорхойлох, тэдгээр асуудлыг олон улсын нийтлэг хандлагын дагуу өөрчлөх боломжийн талаар зөвлөмж боловсруулахад чиглэгдсэн байна.

Судалгааны ажил нь төвлөрлийг сааруулах чиглэлээр хийгдэж буй өөрчлөлтүүдийн тухай олон улсын туршлага, холбогдох судалгаа, тайланг судлах, Үндсэн хууль болон бусад эрх зүйн орчны шинжилгээ хийх, төв Засгийн газрын болон орон нутгийн холбогдох албан тушаалтнуудтай хийсэн ярилцлага хийх зэрэг аргачлалаар явагдсан.

Судлаач Монголын Засгийн газар ба орон нутгийн удирдлага хоорондын ерөнхий эрх мэдэл, чиг үүргийн хуваарилалтын асуудал, төсвийн орлогын хуваарилалтын асуудал зэрэгт дүн шинжилгээ хийж, тэдгээрийг шинэчлэх бодлогын тодорхой зөвлөмжийг боловсруулжээ. Зөвлөмжид “Нутгийн өөрөө удирдах ёс гэсэн ойлголтыг агуулгын хувьд хууль, эрх зүйгээр баталгаажуулах, Засгийн газар ба нутгийн удирдлагын хоорондын чиг үүрэг, эрх мэдлийн ялгаа заагийг тодорхой болгох, төрийн үйлчилгээг нийлүүлэхэд орон нутгийн оролцоо, үүргийг нэмэгдүүлэх, засаг захиргааны нэгжийн өөр өөр түвшингүүдэд чиг үүргийг хуваарилахдаа тэдгээрийн онцлог байдлыг харгалзах, орлого хуваарилахдаа ил тод, эрх тэгш, урьдчилан тооцож болох, тогтвортой байх зарчмуудыг үндэслэх” зэрэг санааг дэвшүүлжээ.



**0409****Хөдөөгийн бизнесийн хөгжил-засаглалын үнэлгээ**

*АНУ-ын Азийн Сан, Мерси Кор төрийн бус байгууллагуудын хамтарсан судалгааны тайлан, Монгол*

Хөдөөгийн бизнесийн хөгжил дэх орон нутгийн удирдлагын үүрэг ролийг тодорхойлж, бизнесийн хөгжилд тэдний анхаарлыг хандуулах зорилгоор хийгдсэн судалгааны ажил. Судалгаа нь эрх зүйн шинжилгээ хийх, асуултанд хариулах замаар нөхцөл байдлын шинжилгээ хийх аргачлалаар явагдсан. Судалгаа нь хөдөөгийн бизнесийн хөгжилд нутгийн удирдлагын зүгээс нөлөөлөх, дэмжих эрх зүйн болон бусад боломж байгаа эсэх, хэрэв байвал хэрхэн ямар арга замаар нөлөөлөж болох зэрэг асуудлуудад хариулт өгөхөд чиглэгдсэн.

Судалгаанд хөдөөгийн 53 бизнес эрхлэгчдийг аймаг, сумдаас сонгон авч хамруулсан. Мөн дөрвөн аймгийн удирдах гол албан тушаалтнуудтай ярилцлага хийсэн. Бодлогын асуудал хариуцсан Төрийн захиргааны төв байгууллагын 6 мэргэжилтэн, шинжээчидтэй уулзсан байна. Судалгаагаар төрөөс бизнест үзүүлэх үйлчилгээнд Засгийн газар болон нутгийн удирдлагын үр дүнтэй хамтын ажиллагаа муу, харилцаа сул, удирдлагын шат дамжлага олон зэрэг саад бэрхшээл байгааг тогтоосон. Үүнийг арилгахад төрөөс бизнесийг дэмжих урт хугацааны бодлого боловсруулах, төрийн байгууллагууд хоорондын үйл ажиллагааг уялдуулах, зохицуулалт, хамтын ажиллагааг сайжруулах асуудал чухал байгааг судалгаанд өгүүлжээ.

Судалгаагаар бизнесийн хөгжлийг дэмжих тал дээр нутгийн удирдлага ба Засгийн газар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаа идэвхигүй байдалтай, нутгийн удирдлагын байгууллагууд нь дээд байгууллагуудаас гаргасан тогтоол, захирамжийг ёс төдий биелүүлэх төдийхнөөр ажиллаж байна гэж үзсэн. Орон нутгийн удирдлагын зүгээс нутаг дэвсгэрийнхээ эдийн засгийн хөгжлийн алс ирээдүйг харж ажиллахгүй зөвхөн өнөө маргаашийн асуудлуудыг аргацаан шийдвэрлэх байдлаар ажилладаг болохыг судалгаанд дүгнэжээ.

Судалгаа нь орон нутгийн удирдлагын эрх мэдэлтэн, төрийн албан хаагчид нь бизнес эрхлэгчдыг дан ганц татвар, зөвшөөрөл, хяналтын асуудлаар шахаж, шаардах, тэдэнд хүнд суртал гаргаж ажиллахын оронд нөхөрсөг байдлаар хамтран ажиллах нь илүү үр дүнтэй байна гэсэн дүгнэлтэд хүрчээ.

## 0420 ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛ

### 0421

#### **Монгол Улсад нутгийн өөрөө удирдах ёсыг хөгжүүлэх үндсэн асуудал**

*С.Нармандах, удирдахуйн ухааны доктор (Ph.D)-ийн зэрэг горлох диссертаци, эрдэм шинжилгээний удирдагч: Философийн ухааны доктор, (Ph.D) профессор Я.Долгоржав, мэргэжил: 12.00.02,Төрийн удирдлага, 2002, Улсын төв номын сан, Улаанбаатар, 139 нцур, Монгол*

Нутгийн өөрийн удирдлагын тогтолцоог хөгжүүлэх онол арга зүйн үндэслэлийг задлан шинжлэх, олон улсын баримт бичиг, гадаадын зарим улс орны практик, туршлагыг нэгтгэн дүгнэсний үндсэн дээр Монгол Улсад нутгийн өөрөө удирдлагын тогтолцоог хөгжүүлэх онол арга зүйн тогтолцоог боловсруулан өөрийн орны онцлогт тохирсон хувилбарыг судалж, тодорхойлоход энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Судалгааны ажил нутгийн өөрөө удирдах ёсны онол практик хөгжлийн хандлага, олон улсын баримт бичгийн үзэл санаа, туршлага, Монгол Улс дахь нутгийн өөрөө удирдах ёсны төлөвшил хөгжлийн өнөөгийн байдал, хөгжлийн асуудлууд зэрэг өргөн хүрээг хамарчээ.

Төрийн тогтолцоонд системийн онолын үүднээс дүгнэлт хийж, төрийн удирдлагын шатлалыг цогцолбороор нь авч үзэх, түүний дотор НӨУЁ-ыг хөгжүүлэх нь зайлшгүй болохыг авч үзсэн. НӨУЁ-ны зарчмыг төвлөрсөн тогтолцоонд олон жил байсан буурай хөгжилтэй орнуудад улс орны онцлог, хөгжлийн түвшинд зохицуулан хэрэгжүүлэх боломж, зайлшгүй шаардлагыг судлан тодорхойлсонд бүтээлийн гол үр дүн оршино. Түүнчлэн НӨУЁ-ны үүсэл, хөгжил, төлөвшилийг судлан түүнийг үечлэх оролдлого хийсэн, Монгол Улсын нутгийн удирдлагын өнөөгийн байдалд анализ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч, түүний цаашдын хандлагыг тодорхойлж, үйл ажиллагааг нь улам боловсронгуй болгох асуудлаар санал дэвшүүлсэнд судалгааны ажлын практик ач холбогдол оршиж байна.

Өнөөгийн НӨУЁ-ны хөгжлийн түвшинг онолын үндэслэл, олон улсын хөгжлийн чиг хандлагатай харьцуулан авч үзвэл хуучин тогтолцооны цеэс хуримтлагдаж ирсэн об'ектив, суб'ектив хүчин зүйлийн улмаас ардчилсан

нийгмийн давуу талыг тэр бүр илэрхийлж чадахгүй байна гэдгийг судлаач дүгнэжээ.

## **0422**

### **Монгол Улсын нутаг дэвсгэрийн хуваарийн түүхэн уламжлал 1921-1932**

*Д.Сүхбаатар, түүхийн ухааны доктор (Ph.D)-ийн зэрэг горилох диссертаци, 2000, Улсын төв номын сан, Улаанбаатар, 119 нүцр, Монгол*

“Монгол Улсын нутаг дэвсгэрийн хуваарийн түүхэн уламжлал 1921-1932” хэмээх сэдэвт холбоотой археологийн дурсгалууд болон сонгон авсан сэдэвт хамаарч болох түүхэн сурвалж, тулгар бичгүүд хийгээд дотоод гадаадын судалгааны бүтээлийг эх сурвалж болгон энэхүү өргөн цар хүрээтэй асуудлыг судалж тодорхойлохыг зорьжээ.

Судалгааны ажил Монгол Улсын нутаг дэвсгэрийн хуваарилалт үүсч хөгжсөн түүхэн уламжлал, овгийн байгууллын үеийн нутаг дэвсгэрийн хуваарилалт, МЭӨ 209 оноос XVII зууны үеийн газар нутгийн хуваарилалт, XVII-XX зууны эхэн үеийнх болон өнөөгийн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэ бүтэц зэрэг түүхэн урт хугацааг хамарсан. Түүхэн газар зүйн судалгааны аргыг хэрэглэж нутаг дэвсгэрийн хуваарийн физик газар зүйн тодорхойлолтыг дэлхийн бөмбөрцөгийн уртраг, өргөрөгөөр аймаг хошуу тус бүрээр гаргаж нутаг дэвсгэрийн хэмжээг газар зүйн дөрвөлжин палетикийн аргаар тодорхойлсон байна.

*Нутаг дэвсгэрийн хуваарилалт нь түүхэн цаг үе, тухайн үеийн төрийн бүтэц, өөрчлөлт, Монгол Улсын төрийн түүхэнд гарсан өөрчлөлттэй хамааралтай нутаг дэвсгэрийн хуваарилалт нь улс орны эдийн засгийн амин судас болсон нүүдлийн мал аж ахуйд зохицсон, нутаг дэвсгэрийн хуваарийн анхны хэлбэрийг хэдий үеээс үүсэлтэйг тодорхойлж чадсан, түүхэн уламжлалт газар нутгийн хуваарийн төрлүүдийг нээсэн зэрэг онцлог ач холбогдолтой бүтээл болжээ.*

**0423****Монгол Улсын засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн хуваарийг оновчтой болгох газар зүйн асуудал**

*Б.Батбуян, газар зүйн шинжлэх ухааны боловсролын доктор (Ph.D) зэрэг горилсон диссертаци, эрдэм шинжилгээний удирдагч газар зүйн шинжлэх ухааны доктор, дэд профессор Д.Базаргүр, 2000, Улсын төв номын сан, Улаанбаатар, 109 нүцр, Монгол*

Бүтээлийн зорилго нь Монгол Улсын засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн хуваарь түүний төвүүдийн байршлын түүхэн уламжлал, нийгэм эдийн засгийн тэнхлэгүүд, бэлчээрийн малын экологийн зохистой нутгийн хэв шинжүүд түүний онцлогтой уялдуулан оновчтой болгох боломжуудыг судлах явдал байв.

Судалгааны ажил Монгол Улсын засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн хуваарийн газар зүйн онцлог нөлөөлөх хүчин зүйлүүд, оновчтой болгох зарим хувилбар /Завхан аймгийн жишээн дээр/ зэрэг хүрээг хамарсан. Монгол Улсын засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн хуваарийн түүхэн өөрчлөлтийг тус орны эдийн засгийн үндсэн салбар болох бэлчээрийн мал аж ахуй эрхлэх экологийн зохистой нутгийн хэв шинж болон бусад хүчин зүйлтэй холбон судалсан нь энэ судалгааны арга зүйн шинэлэг тал юм.

Монгол Улсын засаг захиргааны нэгжийн төвүүд ба нутаг дэвсгэрийн хуваарийг “Объект-байршил шалгуураар” гэсэн системийн хүрээнд дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох арга зүйн асуудлыг дэвшүүлж шийдвэрлэсэн. Энэ аргачиллаар Монгол Улсын засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн болон төвүүдийн байршлыг оновчтой болгох схем боловсруулж гаргасан зэрэг үр дүнд хүрчээ.

*Судлаач одоогийн Монгол Улсын засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн хуваарийн оновчгүйгээс нийгэм эдийн засгийн олон сөрөг үр дагавар илэрч байна гэж тэмдэглэсэн. Улс төр, эдийн засгийн удирдлагын нэгдлийг хангах засаг захиргааны хил хязгаарыг зах зээлийн эдийн засгийн нөхцөлтэй хослуулж төрийн удирдлагын аппаратын зардлыг хямдруулах зорилгоор 21 аймгийг 18, 329 сумыг 140 сум болтол цөөрцүлэх боломжтой, ийм шаардлагатай байгааг тодорхой үндэслэлүүдээр нотолж байна.*

**0424****Орон нутгийн удирдлагын эдийн засгийн механизмыг боловсронгуй болгох зарим асуудал**

*Л.Галбадрах, эдийн засгийн ухаанаар боловсролын докторын (Ph.D) зэрэг горилох диссертаци, удирдагч: Эдийн засгийн шинжлэх ухааны доктор, профессор Д.Базаргүр, Улсын төв номын сан, Улаанбаатар, 208 нүцр, Монгол*

Энэхүү эрдэм шинжилгээний ажлын зорилго нь улсын буую төрийн өмч давамгайлсан нийгмээс хувийн өмч давамгайлсан төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засгийн нийгмийн харилцаанд шилжих үед эдийн засгийн механизмыг хэрхэн ашиглаж орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах арга зам болон төрийн удирдлагын эдийн засгийн механизмын үр ашигтай хувилбарыг эрэлхийлж, тодорхой санал дэвшүүлэхэд чиглэсэн байна.

Энэхүү бүтээлд нутгийн удирдлагын эдийн засгийн механизмыг бүрдүүлэн төлөвшүүлэх онол арга зүйн асуудал, орон нутгийн эдийн засгийн удирдлагын өнөөгийн байдал, түүнд хийсэн судалгаа, орон нутгийн эдийн засгийн механизмыг боловсронгуй болгох асуудал зэрэг хүрээг хамарсан. Эрдэм шинжилгээний бүтээл нь макро эдийн засгийн болон орон нутгийн эдийн засгийн механизмыг үр дүнтэй ашиглах асуудлыг эдийн засгийн өнөөгийн нөхцөлд судлан үзэж цаашид боловсронгуй болгох санал дэвшүүлж байгаагаараа шинэлэг юм.

Орон нутгийн түвшинд ДНБ-ийг тооцож түүнээс татварын механизмаар дамжуулан төсвийн орлогыг бүрдүүлэх замаар аймаг сумын төсвийн алдагдлыг арилгах арга зүйн саналыг дэвшүүлж байна. Мөн орон нутгийн тухайн жилд шаардагдах мөнгөний хэмжээг тодорхойлохдоо орон нутагт үйлдвэрлэсэн ДНБ-ий өсөлт дээр инфляцийг тооцох замаар шийдэх саналыг дэвшүүлжээ.

Энэхүү судалгаагаар орон нутгийн удирдлагын эдийн засгийн механизмыг боловсронгуй болгох зарим асуудлыг судлахдаа онол практикийн талаас нь одоогийн бодит амьдралтай уялдуулж, түүний ололтой талыг бэхжүүлэх, дутагдал, доголдолыг шинэ механизмаар өөрчлөх, зах зээлийн улс орнуудад үр дүнгээ өгч байгаа механизмыг Монгол орны онцлогтой уялдуулан нэвтрүүлэхэд гарах үр дүнг тодорхойлсоноороо ач холбогдолтой юм.

Орон нутгийн тухай ойлголтыг цэгцэлж түүний удирдлагын чиг үүрэг, хэм хэмжээг төв засгийн удирдлагаас салган зааглаж төвлөрлийг сааруулж, нутгийн удирдлагыг бэхжүүлэх бодлогын хүрээнд эрх зүйн шинэчлэл хийх нь зүйтэй, төрийн мөнгөний бодлого нь макро түвшинд тогтворжилтын асуудлыг төлөвшүүлэхэд чиглэгдэж байгаа боловч орон нутгийн хөгжлийг дэмжсэн мөнгөний бодлого алга байна гэсэн дүгнэлтүүдийг гаргаж тавьсан байна.

## НОМ ЗҮЙД ХАМРАГДСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

Салбарын Код	Код	Зохиогчийн нэр, овог	Бүтээлийн нэр	Хаана, хэдэн онд, ямар хэл дээр хэвлэгдсэн
<b>1. НУТГИЙН УДИРДАГАТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ</b>				
<b>Хуулиуд 0100</b>	0101		Монгол Улсын Үндсэн хууль	1992 онд Улаанбаатар хотод монгол хэл дээр
	0102		Авто тээврийн тухай хууль	1999
	0103		Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	2001
	0104		Ашигт малтмалын тухай хууль	2002
	0105		Аялал жуулчлалын тухай хууль	2000 онд батлагдаад 2001 онд нэмэлт орсон
	0106		Байгаль орчныг хамгаалах тухай хууль	1995 онд анх батлагдаж 2005 онд нэмэлт орсон
	0107		Боловсролын тухай хууль	2002 онд батлагдаж тэр ондоо зарим зүйл заалтад өөрчлөлт хийсэн
	0108		Газрын тухай хууль	2002 он
	0109		Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	2002 онд баталж, 2003 онд зарим хэсэгт нэмэлт оруулсан
	0110		Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай	2002 онд батлагдсан
	0111		Монгол Улсын татварын ерөнхий хууль	1992 онд батлагдаж, 2001 онд нэмэлт өөрчлөлт оруулсан
	0112		Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль	1994 онд батлагдаж, 1995 онд нэмэлт оруулсан
	0113		Төрийн болон орон нутгийн өмчийн тухай	1996 онд батлагдаж 2003 онд өөрчлөлт орсон
	0114		Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль	2002 онд батлагдсан
	0115		Усны тухай хууль	2004
0116		Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль	1993 онд анх батлагдсан 2003 онд нэмэлт өөрчлөлт орсон	
0117		Эрүүл мэндийн тухай хууль	1998	

Салбарын Код	Код	Зохиогчийн нэр, овог	Бүтээлийн нэр	Хаана, хэдэн онд, ямар хэл дээр хэвлэгдсэн
<b>2. ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ТӨСЛИЙН ТАЙЛАН</b>				
<b>0200 Хөтөлбөр, төсөл</b>	0201	Шведийн Олон Улсын Хөгжлийн Сан санхүүжилтээр (SIDA) Монгол Улсын Засгийн газар, Шведийн Төрийн Захиргааны Институт (SIPU) хамтран хэрэгжүүлсэн	Ардчилсан Монгол дахь сайн засаглал, 2002-2005	2005 онд монгол хэл дээр сургалтын материал хэвлэгдсэн
	0202	Шведийн Олон Улсын Хөгжлийн Сан санхүүжилтээр (SIDA) Монгол Улсын Засгийн газар, Шведийн Төрийн Захиргааны Институт (SIPU) хамтран хэрэгжүүлсэн.	“Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхийг бэхжүүлэх нь” I (1997-1999) болон II (2001-2004) төсөл	2002, 2003, 2004 онд монгол хэл дээр хэвлэгдсэн
	0203	Монгол Улсын Засгийн газрын Хэрэг Эрхлэх газар, Азийн Хөгжлийн Банк	Төвлөрлийг сааруулах, нутгийн захиргааг өөрчлөн шинэчлэх хүрээ, үйл ажиллагааны төлөвлөгөө	Бодлогын баримт бичиг, Засгийн газрын 1996 оны 11 сарын 9-ний өдрийн хуралдаанаар баталсан, 122 хуудас, Монгол, Англи
	0204	Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр Монгол Улсын Засгийн газар хэрэгжүүлсэн	Төрийн захиргааны шинэчлэл хөтөлбөр	1997 оноос төрийн захиргааны шинэчлэл хөтөлбөр дээр АХБ-наас Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байгаа, монгол хэл дээр
	0205	НҮБХХ-өөс санхүүжүүлж 2004 оноос эхлэн Улаанбаатар хотын дүүргүүдийн таван хороонд хэрэгжиж эхэлсэн төсөл	Хотын ядуурлын туршилтын төсөл	Энэ төсөл нь 2004 оноос эхлэн хэрэгжиж эхлсэн
	0206		“Хөдөө худалдаа” борлуулалтын сүлжээ	Технизийн тусалцааны төслийн санал, 1998, Улаанбаатар, 34 хуудас, Монгол, Англи



Салбарын Код	Код	Зохиогчийн нэр, овог	Бүтээлийн нэр	Хаана, хэдэн онд, ямар хэл дээр хэвлэгдсэн
0210 Төслийн тайлан, бодлогын баримт бичиг	0211	Азийн Хөгжлийн Банк	Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн чадавхийг бий болгох нь	2001 оны УИХ, Засгийн газрын тогтоолоор хэрэгжиж эхэлсэн
	0212	Жон Логсен, Чи Жиюн,	Монгол дахь нутгийн иргэдийн хөгжлийн төв төслийн үнэлгээний эцсийн тайлан	Төслийн тайлан, ЮНЕСКО Ази Номхон далайн бүсийн хөгжлийн төв, Улаанбаатар, 2002, 52 нүүр
	0213	Монгол Улстай хамтран ажиллах анхны үйл ажиллагааны хүрээ		1997 онд хэрэгжүүлж эхэлсэн англи бодлогын баримт бичиг
	0214	Монгол Улстай хамтран ажиллах хоёр дахь удаагийн үйл ажиллагааны хүрээ		2001 онд Ньюрк хотод баталсан, англи бодлогын баримт бичиг
	0215	Азийн Хөгжлийн Банк	Төрийн зарлагын менежмент	Техникийн тусалцааны төслийн тайлан, Англи
	0216	Азийн Хөгжлийн Банк	Улс орныг дэмжих хөтөлбөрийн үнэлгээ	Mongolia, 2002 Мон 2002-12 Хөтөлбөрийн үнэлгээний тайлан, Англи, Монгол
0230 Олон улсын болон төрийн бус байгууллагууд	0231	Конрад Аденаерын Сан		
	0232	Монголын Нутгийн Удирдлагын Холбоо (МНУХ) ТББ		
	0233			
	0234	НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр		
	0235	Нээлттэй Нийгэм Форум /Хуучнаар Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн/		
	0236	Орон Нутгийн Удирдлагын Хөгжил Сан (ОНУХС) ТББ		

Салбарын Код	Код	Зохиогчийн нэр, овог	Бүтээлийн нэр	Хаана, хэдэн онд, ямар хэл дээр хэвлэгдсэн
<b>3. НОМ, ТОВХИМОЛ, ГАРЫН АВЛАГА, СЭТГҮҮЛ</b>				
<b>0300</b> гарын авлага, сэтгүүл	0301	Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь I (1997-1999) төсөл	Багшийн гарын авлага	1999, Улаанбаатар, 115 нүүр, монгол
	0302	Монгол Улсын Засгийн газар, Шведийн Төрийн Захиргааны Институт, Шведийн Нутгийн Удирдлагын Холбоо (SALA IDA), төслийн баг	Байгаль орчныг хамгаалах олон нийтийн үүрэг	Гарын авлага, 2005, Улаанбаатар, 56 нүүр, “Адмон” ХХК-д хэвлэв,
	0303	“Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь II”	Иргэн ба хууль зүй	Улаанбаатар, 141 нүүр, “Адмон” хэвлэлийн газарт монгол хэл дээр хэвлэв.
	0304	Гуннар Андерссон	Иргэдийг төлөөлөхүй	Улаанбаатар, 2003, 40 нүүр, Монгол, Англи
	0305	Монголын Нутгийн удирдлагын холбоо	Мнгол улсын нутгийн өөрөө удирдах ёсны тунхаг бичиг	гарын авлага, 2001, Улаанбаатар, Монгол
	0306	Сургалтын гарын авлага боловсруулах баг,	Монгол Улсад нутгийн өөрөө удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь	2004 онд монгол хэл дээр гаргасан
	0307	Я.Долгоржав	Нутгийн өөрөө удирдах ёс /НӨУЁ/	2000, Улаанбаатар, 54 нүүр, монгол дээр
	0308	Ховд аймгийн ИТХ	Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь	Ховд Их Сургуулиас Баруун бүсийн онол практикийн бага хурлын илтгэлүүдийг эмхтгэн гаргасан эмхтгэл, 2006, Улаанбаатар, Соёмбо хэвлэлийн газар, 362 хуудас, Монгол
	0309	Г.Маналжав	“Нутгийн удирдлага” сэтгүүл	Сэтгүүл, 2006, Улаанбаатар, Монгол
	0310	“Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь II”	Орон нутгийн санхүүгийн хөгжил	Улаанбаатар, “Адмон” хэвлэлийн газарт хэвлэв, 73 нүүр. Монгол

Салбарын Код	Код	Зохиогчийн нэр, овог	Бүтээлийн нэр	Хаана, хэдэн онд, ямар хэл дээр хэвлэгдсэн
0300 гарын авлага, сэтгүүл	0311	“Монгол Улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь I” (1997-1999 ) төсөл	Сонсогчийн гарын авлага	1999, Улаанбаатар, 223 нүүр монгол дээр
	0312	Монгол Улсын Их Хурлаас	Төрийн захиргааны шинэчлэлийн төсөл	Улаанбаатар, “Хөх судар” хэвлэлийн газарт хэвлэв, 2002, 184 нүүр,
	0313	Б.Намхайжанцан	Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл, онол, тайлбар, хэрэгжилт	Улаанбаатар, 2003, 158 нүүр, “Хөх судар принтинг” ХХК-ийн хэвлэх үйлдвэрт монголоор хэвлэв.
	0314	Төрийн захиргааны шинэчлэлийн төсөл	Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл, төсвийн байгууллагын бүтээгдэхүүнийг тодорхойлох, бүтээгдэхүүний өртөг тооцох гарын авлага	Улаанбаатар, 2003, 98 нүүр төсвийн байгууллагын бүтээгдэхүүн тодорхойлох, бүтээгдэхүүний өртөг тооцох гарын авлага
	0315	Төрийн захиргааны шинэчлэлийн төсөл	Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл, хуулийн эмхтгэл	Улаанбаатар, 2003, 182 нүүр, Монгол дээр
	0316	Төрийн захиргааны шинэчлэлийн төсөл	Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл, заавар, журмын эмхтгэл	Улаанбаатар, 2003, 228 нүүр, Аригү графикс ХХК-д хэвлэв.
	0317	Төрийн захиргааны шинэчлэлийн төсөл	Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл, төсвийн удирдлагын гарын авлага	Улаанбаатар, 2003, 135 нүүр, “Бишрэлт тэнгэр” хэвлэлийн газарт хэвлэв.
	0318	Д. Баярсайхан	Хүний эрх ба нутгийн өөрөө удирдах ёс	Багийн иргэдэд зориулсан гарын авлага, Редактор Ц.Ундрах, Улаанбаатар, 1999, 54 нүүр
	0319	Монгол Улсын Засгийн газар, Шведийн Төрийн Захиргааны Институт	Хүрээлэн буй орчныг хамгаалах орон нутгийн удирдлагын үүрэг	Баян-Өлгий, Увс аймагт хэрэгжүүлсэн төслийн гарын авлага, 2005 онд хэвлэгдсэн 47 нүүр бүтээл

Салбарын Код	Код	Зохиогчийн нэр, овог	Бүтээлийн нэр	Хаана, хэдэн онд, ямар хэл дээр хэвлэгдсэн
0330 ном, товхимол	0331	Б.Чимид	Багийн өнгөрсөн, одоо, ирээдүй	Нэг сэдэвт бүтээл, Хянан тохиолдуулсан Доктор Ш. Батсүх, 2002, Улаанбаатар,185 нүүр, Interpress хэвлэлийн компани
	0332	Монгол Улсын Засгийн газрын Хэрэг Эрхлэх газар, Хууль Зүйн Яам, Хууль Зүйн Мэдээллийн Төв	Бүх шатны хурал, Засаг даргын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн актын эмхтгэл	Улаанбаатар, 1998, 481 нүүр, Монгол
	0333	Эмхтгэж редакторласан, П. Увш, В. Удвал	Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний өнөөгийн байдал, цаашдын хандлага	Онол практикийн бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл, , Улаанбаатар, 2005
	0334	Р.Ринчинбазар	Монголын бүс нутгийн тогтвортой хөгжлийн асуудлууд	Нэг сэдэвт бүтээл, 2004 он, Улаанбаатар, 188 хуудас, Монгол, “ВСИ” ХХК-д хэвлүүлэв.
	0335	Р.Ринчинбазар	Монголын бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт, удирдлагын асуудлууд	Нэг сэдэвт бүтээл, 2004 он, Улаанбаатар, 344 хуудас, Монгол, “ВСИ” ХХК-д хэвлүүлэв.
	0336	Р.Ринчинбазар	Монголын бүс нутгийн хөгжлийн эдийн засаг, математикийн загварчлал	Нэг сэдэвт бүтээл, 2004 он, Улаанбаатар, 344 хуудас, Монгол, “ВСИ” ХХК-д хэвлүүлэв.
	0337	Г.Маналжав М.Мандах	Монгол Улсын орон нутаг, түүний удирдлага	Нэг сэдэвт бүтээл, 2004, Улаанбаатар, 112 нүүр, “Хөх судар” принтинг хэвлэлийн компани.
	0338	Улс Төрийн Боловсролын Академи	Монгол Улсын үндсэн хуулийн үзэл баримтлал	Товхимол IV, Улаанбаатар, 2002, Экимто ХХК-д хэвлэв,192 нүүр
	0339	Улс Төрийн Боловсролын Академи	Монгол Улсын үндсэн хуулийн үзэл баримтлал	Товхимол, Улаанбаатар, 2000, Адмон ХХК-д хэвлэв, 115 нүүр
	0340	Б.Өлзийбаян	Нутгийн өөрийн удирдлага	Чойбалсан хот, 2004, 152 нүүр, Засгийн газрын хэвлэх үйлдвэр

Салбарын Код	Код	Зохиогчийн нэр, овог	Бүтээлийн нэр	Хаана, хэдэн онд, ямар хэл дээр хэвлэгдсэн
0330 НОМ, ТОВХИМОЛ	0341	Монголын Нутгийн Удирдлагын Холбоо	Нутгийн өөрийн удирдлагын өнөөгийн байдал ололт, дутагдал, хандлага	Онол практикийн бага хурал, илтгэл, хэлсэн үгийн эмхтгэл - 2002.09.22, Улаанбаатар, 2003, 135 нүүр, “ЭКИМТО” ХХК-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.
	0342	М. Сандаг-Очир	Нутгийн удирдлага	Нэг сэдэвт бүтээл, Хянан тохиолдуулсан Б. Шатар, 2003, Улаанбаатар, 152 нүүр, Удирдлагын Академийн хэвлэх тасагт хэвлэв.
	0343	Монголын Нутгийн Удирдлагын Холбоо	Санаачлага -Үр дүн арга барил, туршлага	Нутгийн өөрөө удирдах ёс үүсч хөгжсөний 10 жилийн ойд зориулав, , эмхэтгэсэн Г.Маналжав, Б.Шарбанди, Улаанбаатар, 2002, 78 нүүр
	0344	“Сум, баг хөгжүүлэх загвар” судалгааны баг	Сумын судалгаа: Онол арга зүйн асуудал	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын эмхтгэл Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэг агентлаг Удирдлагын Академи, хянан тохиолдуулсан доктор, профессор Ш. Түдэв, 2004, Улаанбаатар, 378, нүүр, Удирдлагын Академийн хэвлэх тасаг
	0345	Г.Маналжав	Хурал, өөрөө удирдах ёс	Хянан тохиолдуулсан Ж.Ядамсүрэн, 2000, Улаанбаатар, 132 нүүр, Адмон компанид хэвлэв.
	0346	УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо	“Хүчирхэг орон нутаг-Хүчирхэг Монгол Улс” илтгэлийн эмхтгэл	Товхимол, 2006, Улаанбаатар, Монгол

Салбарын Код	Код	Зохиогчийн нэр, овог	Бүтээлийн нэр	Хаана, хэдэн онд, ямар хэл дээр хэвлэгдсэн
<b>4. СУДАЛГААНЫ ТАЙЛАН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛ</b>				
<b>0400 Судалгааны тайлан</b>	0401	Азийн Хөгжлийн Банк	Шинэчлэлийг хэрэгжүүлэх төв ба нутгийн удирдлагын асуудлуудын судалгаа	2000-2001 онд хэрэгжүүлсэн
	0402	Дэлхийн Банк	Монгол, Төрийн зарлагын болон санхүүгийн удирдлагын судалгаа	2002 онд хэрэгжүүлж дуусан англи бодлогын судалгааны тайлан
	0403	Монгол Улсын Засгийн газар, “Монгол Улсад, төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь II” төсөл	Орон нутгийн улс төрийн ёс зүйн асуудал, судалгааны тайлан	Орон нутгийн удирдлагын хөгжлийн сан, Шведын ореброгийн Их сургуулийн судалгааны хамтарсан баг, Улаанбаатар 2002, 74 нүүр Монгол
	0404	Монгол Улсын Засгийн газар, “Монгол Улсад, төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь II” төсөл	Орон нутгийн улс төрийн ёс зүйн асуудал судалгааны тайлан 2003 он	Орон нутгийн удирдлагын хөгжлийн сан, Шведын ореброгийн Их сургуулийн судалгааны хамтарсан баг, Улаанбаатар 2003, 84 нүүр, монголоор
	0405	Монгол Улсын Засгийн газар, “Монгол Улсад, төвлөрлийг сааруулах, нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь II” төсөл	Орон нутгийн улс төрийн ёс зүйн асуудал судалгааны тайлан 2001-2004 он	Орон нутгийн удирдлагын хөгжлийн сан, Шведын ореброгийн Их сургуулийн судалгааны хамтарсан баг, Улаанбаатар 2004, 110 нүүр, монгол хэлээр
	0406	Жон Кйуага-Нсүбүга	“Орон нутгийн түвшинд ардчиллыг бэхжүүлэх нь: Тулгамдсан асуудлын судалгаа”	Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон олон улсын V бага хурлаас гаргасан “Судалгааны ажлууд ба төгсгөлийн баримт бичгийн эмхтгэл”, 2003, Улаанбаатар, 69-82 хуудас, Монгол

Салбарын Код	Код	Зохиогчийн нэр, овог	Бүтээлийн нэр	Хаана, хэдэн онд, ямар хэл дээр хэвлэгдсэн
0400 Судалгааны тайлан	0407	Монгол Менежмент Төв, ТББ	Санхүүгийн төвлөрлийг сааруулах судалгаа	Судалгааны тайлан. Өрхийн амьжиргааны дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд тус хөтөлбөрийн газрын санхүүжилтээр Монгол менежмент төв ТББ-ын хийсэн судалгаа.
	0408	Нээлттэй Нийгэм Форум, гүйцэтгэгч: Л.Лувсанжамц	Үндэсний ба нутгийн удирдлагын чиг үүргийн зохистой хуваарилалт	Нээлттэй нийгэм форум Улаанбаатар 2005, 54 нүүр, Соёмбо принтинг ХХК-д хэвлэв.
	0409	Азийн Сан, Мерси Корпс /Монгол/	Хөдөөгийн бизнесийн хөгжил-засаглалын үнэлгээ	4 аймгийн захиргааны 15 удирдах ажилтнуудтай ярилцлага явуулсан
0420 Эрдэм шинжилгээний бүтээл	0421	С.Нармандах	Монгол Улсад нутгийн өөрөө удирдах ёсыг хөгжүүлэх үндсэн асуудал	Удирдахуйн ухааны доктор (Ph.D)-ийн зэрэг горилсон диссертаци, эрдэм шинжилгээний удирдагч: Философийн ухааны доктор, (Ph.D) профессор Я.Долгоржав, мэргэжил: 12.00.02, Төрийн удирдлага, Улаанбаатар, 2002, 139 нүүр, Энэ бүтээл нь одоогоор Улсын төв номын санд хадаглагдаж байна.
	0421	Д. Сүхбаатар	Монгол Улсын нутаг дэвсгэрийн хуваарийн түүхэн уламжлал 1921-1932	Түүхийн ухааны доктор (Ph.D)-ийн зэрэг горилж бичсэн зохиол, Улаанбаатар 2000, 119 нүүр, төв номын сангийн Эрдэм шинжилгээний уншлагын танхимд байгаа
	0422	Б.Батбуян	Монгол Улсын засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн хуваарийг оновчтой болгох газар зүйн асуудал	Газар зүйн шинжлэх ухааны боловсролын доктор (Ph.D) зэрэг горилсон диссертаци, эрдэм шинжилгээний удирдагч: газар зүйн шинжлэх ухааны доктор, дэд профессор Д. Базаргүр, Улаанбаатар, 2000, 109 нүүр, төв номын санд
	0423	Л. Галбадрах	Орон нутгийн удирдлагын эдийн засгийн механизмыг боловсронгуй болгох зарим асуудал	Эдийн засгийн ухаанаар боловсролын докторын (Ph.D) зэрэг горилохоор туурвисан бүтээл, удирдагч: Эдийн засгийн шинжлэх ухааны доктор, профессор Д. Базаргүр, Улаанбаатар, 2000, 208 нүүр, төв номын санд